

ОРЧИН 21

МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО




2-12 ЦАГ ҮЙЛ ЯВДАЛ
МЭНДЧИЛГЭЭ



13-37 МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2016
ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТ
СЕМИНАРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



38-57 ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ
УНДНЫ УС, ХАЛААЛТЫН ЗОРИУЛАЛТАЙ
ХООЛОЙН СИСТЕМ



58-62 ЯРИЛЦЛАГА
З.БАЯНСЭЛЭНГЭ: ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮГ
БУУРУУЛСНААР ЗЭЭЛИЙН БОСГО НАМСАЖ,
ТӨЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ БАГАСНА



63-69 ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА
"ТАВАН-ӨНДӨР" ХХК 10 НАС ХҮРЛЭЭ



70-86 ХУУЛИЙН ЗӨВЛӨГӨӨ
"ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦ" ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ



87-92 ЭРҮҮЛ МЭНД
ЦУВРАЛ 11, АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ТА ӨВЧЛӨӨГҮЙ, ХАРИН ЦАНГАСАН
БАЙНА

ОРЧИН 21

ЭРХЛЭГЧ:

Б.Пүрэвжав

/Монгол улсын аж үйлдвэрийн
гавьяат ажилтан, Техникийн ухааны
мастер, МУ-ын зөвлөх инженер/

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

С.Дагвадорж

/Таван Өндөр ХХК-ийн захирал/

МЕНЕЖЕР:

Б.Алтантуул

ДИЗАЙНЕР:

Б.Мөнхцацрал

СЭТГҮҮЛЧ:

Б.Баяртогтох

ISSN 1033-1040X

орчин·21

2016 01 (24) Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо

**БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД З.БАЯНСЭЛЭНГЭ:
ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮГ
БУУРУУЛСНААР ЗЭЭЛИЙН
БОСГО НАМСАЖ, ТӨЛӨЛТИЙН
ХЭМЖЭЭ БАГАСНА**

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ 2015 ОНЫ 9 ДҮГЭЭР
САРЫН 08-НЫ ӨДРӨС 12 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР ХҮРГЭЛ
100 ХОНОГИЙН ХУГАЦААНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

WWW.ORCHIN21.MN УТАС: 70101779 MNAALH@YAHOO.COM



МЭНДЧИЛГЭЭ

Орон сууц, Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний салбарын нийт ажилтан, албан хаагчид, үе үеийн ахмадууд, энэ салбартай хамтран үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд та бүхэндээ эрүүл энх, ажлын амжилтыг хүсэн ерөөж ирж буй “Муу нүүрт” хэмээх БИЧИН жилийн сар шинийн мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Та бүхэн хонь жилдээ хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангасан, сүүлийн үеийн шинэ дэвшилтэт техник, технологиор үйлчилж, тэдний ая тухтай ажиллаж амьдрах орчинг бүрдүүлж, соёлтой боловсон үйлчлэх талаар бүтээсэн зүйл, хүрсэн амжилтыг тань тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Хүн ардынхаа тав тухтай амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх, үйлчилгээний ажлынхаа хэвийн явагдах нөхцлийг хангах ажилдаа улам их амжилт гаргана гэдэгт итгэлтэй байна.

Орон сууц, Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний салбарын хамт олон та бүхэнд хөдөлмөр бүтээлийн их амжилт, айл өрх бүрд аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе.

Та бүхнийг хүндэтгэн мэндчилсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНЫ ТЭРГҮҮН

Жамьянсүрэнгийн БАТСУУРЬ



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ 2015 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДРӨӨС 12 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР ХҮРТЭЛ 100 ХОНОГИЙН ХУГАЦААНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. Салбарын хууль, эрхзүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр:

“Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан төрийн болон төрийн бус байгууллагын 80 гаруй төлөөлөл оролцсон “Барилгын тухай” хуулийн хэлэлцүүлгийг энэ оны 11 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан зарим саналыг хуулийн төсөлд тусган УИХ-ын ажлын хэсэг, байнгын хороогоор хэлэлцүүлэхэд бэлтгэсэн.

- **Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Газрын кадастрын тухай, Геодези, зураг зүйн тухай, Хот байгуулалтын тухай** хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг шинээр байгуулж, хуулийн төслийг боловсруулж байна.
- **Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн тухай, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай, Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тухай, Хот, суурины ногоон байгууламжийн тухай, Авто зогсоолын тухай** хуулиудыг шинээр боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн хуулийн төсөл боловсруулах ажлыг үргэлжлүүлж байна.
- **«Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай»** хууль 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Улсын их хурлаар батлагдсантай холбогдуулан уг хуулийг дагалдан гарах дүрэм, журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 195 дугаар тушаалаар байгуулан холбогдох дүрэм, журам, зааврын төслүүдийг боловсруулж байна.

Хоёр. Салбарын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох чиглэлээр:

- Барилга, хот байгуулалтын салбарын 2015-2017 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан Барилга, хот байгуулалт /БХБ/-ын Сайдын 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 223 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.

- Төрөөс газрын харилцаа, геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/-ын 2015 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 229 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.
- “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” /2016-2030 он/-ын төсөлд барилга, хот байгуулалтын салбарын хөгжлийн үзэл баримтлалд тусгах зорилтуудыг боловсруулж УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос томилогдсон ажлын хэсэгт хүргүүлээд байна.

Хот байгуулалтын чиглэлээр:

- Азийн хөгжлийн банктэй хамтран “Монгол Улсын хот байгуулалтын үнэлгээ” төслийг хэрэгжүүлж, 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдөр “Монгол Улсын хот байгуулалтын үнэлгээ” сэдэвт семинарыг зохион байгуулж, хот байгуулалтын салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, НҮБ-Хабитат, GIZ төсөлтэй санал бодол солилцсон.
- УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг НЗТГ-ын СБТХэлтэс, ЖАЙКА-ийн төслийн багтай хамтарч боловсруулан яамдаас санал авч, БХБ-ын Сайдын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газарт өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.
- ЖАЙКА байгууллагын техникийн туслалцааны “Монгол Улсын хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дахь үе шатны төслийг хэрэгжүүлж эхлэн хот байгуулалт, орон сууцны бодлогын асуудлаар хамтран ажиллаж байна.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн чиглэлээр:

- “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор



Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаад улсын дипломат болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газруудын ашиглалтад олгох газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, тэдгээрийн хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийн солбицлыг хавсралтаар баталсан.

- Төрөөс газрын харилцаа, геодези, зураг зүйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 229 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.
- Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн хилийн цэсийг нарийвчлан тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, үзэл баримтлалыг Хууль зүйн Сайдтай хамтран баталсан.
- “Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”-ыг БХБ-ын Сайдын 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 234 дүгээр тушаалаар баталсан.
- Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрх олгох журмыг техник технологийн боломж, боловсон хүчний зах зээл, хэрэгцээнд тулгуурлан шинэчлэн боловсруулж батлууллаа.



Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр:

- Барилгын материал үйлдвэрлэгч үндэсний аж ахуйн нэгжүүдийг татвар, тарифын бодлогоор дэмжих бодлогын хүрээнд импортын зарим материалын гаалийн тарифын хэмжээг нэмэгдүүлэх, импортын зарим түүхий эдийн гаалийн тарифын хэмжээг тэглэх, зарим үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх тухай асуудлуудыг багцлан Засгийн газрын тогтоолын төслүүд боловсруулж, Сангийн сайд бөгөөд Гаалийн тарифын зөвлөлийн дарга Б.Болорт 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 1/2972 тоотой, хувийг Аж үйлдвэрийн яаманд хүргүүлэн, Гаалийн

тарифын зөвлөлөөр хэлэлцүүлэн Засгийн газарт хүргүүлэхээр ажиллаж байна.

- “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийлгэж, хөтөлбөрт хамрагдсан 33 барилгын материалын үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, гарсан зөрчлийг арилгуулах, цаашид анхаарах асуудлаар удирдамж, чиглэл өгсөн.
- Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолын хүрээнд барилгын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан 23 байгууллагын гүйцэтгэж буй 36 барилга, байгууламжийн материалыг судлан 17 барилга байгууламжид сунгах, 16 барилга байгууламжид ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосон.
- Барилгын салбарын норм, нормативын баримт бичгийг Евростандартын жишигт нийцүүлж боловсронгуй болгох “Дунд хугацааны хөтөлбөр” болон хийгдэх ажлын төлөвлөгөөг БХБ-ын Сайдын 2015 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 199 дүгээр тушаалаар батлан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.
- Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох талаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 75 дугаар тогтоолоор батлагдсан журмыг шинэчлэн, нийтээр дагаж мөрдөх журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг БХБ-ын ТНБД-ын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 256 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр:

- Төрийн орон сууцны корпорацийн үйл ажиллагаа, “Буянт-Ухаа-1” хорооллын цэвэрлэх байгууламж, шугам сүлжээний ажил, “Буянт-Ухаа-2” хорооллын барилга угсралтын ажлын явцтай 2015 оны 10 дугаар сарын 31-ний өдөр танилцаж, иргэд, хэрэглэгчдтэй санал солилцсон.
- Мөн корпорацийн захиалгаар аймаг, орон нутагт хэрэгжиж байгаа орон сууцны төслүүдтэй танилцах, үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын хэсгийг БХБ-ын Сайдын 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 211 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна.
- “Төрийн орон сууцны корпораци” (ТОСК) ТӨҮГ-ын дүрмийн төсөлд тус яамнаас өгсөн саналууд тусгагдаж, Төрийн өмчийн хорооны 2015 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 685 дугаар тогтоолоор батлагдсанаар ТОСК-ийн стратеги болон бизнес төлөвлөгөө, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг зөвшилцөн, тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион



байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайлан, илтгэх бичгийг хүлээн авч танилцан, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах эрх зүйн орчин бүрдлээ.

- Нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн 24 байршилд хэрэгжиж байгаа төслүүдийн явцтай танилцан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл өгөөд байна.
- Бохир ус цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд танилцуулсан.

- УИХ-ын 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр соёрхон баталсан Зээлийн хэлэлцээрийн дагуу АХБ-ны зээлээр хэрэгжүүлэх “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл”-ийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийг холбогдох газруудтай зөвшилцөн байгуулж, ажлыг эхлүүлээд байна.
- Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх асуудлыг хэлэлцүүлж, концессын гэрээгээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн ба уг цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай Монгол Улсын Ерөнхий сайд газар дээр нь танилцаж үүрэг чиглэл өгсөн.

ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН 10 ХУВИЙН УРЬДЧИЛГАА ҮРГЭЛЖЛЭХЭЭР БОЛЛОО



Барилга хот байгуулалтын яам, Голомт банк хамтран орон сууцны урьдчилгаа төлбөрийг 10 хувь болгох ажилд хамтрахаар өнөөдөр санамж бичиг байгууллаа. Энэ нь эхний ээлжид иргэд авах орон сууцныхаа төлбөрийн 10 хувийг бэлнээр төлж, үлдсэн 20 хувьд нь Барилга хот байгуулалтын яам, арилжааны банкнууд, орон сууцаа борлуулж буй барилгын компаниуд хамтран баталгаа гаргах болж байгаа юм. Харин иргэдэд ийм зээл олгож эхлэх хугацаа тодорхойгүй хэвээр үлдлээ.

Салбарын яамнаас нь барилгын компани, арилжааны банкнууд нэгдсэн ойлголцолд хүрч, ипотекийн зээлийг үргэлжлүүлэх шаардлагатай гэсэн байр суурь илэрхийллээ. Харин арилжааны банкнуудын тухайд ипотекийн найман хувийн хүүтэй зээлийг үргэлжлүүлэн олгох боломжтой. Гагцхүү Улсын их хурал зээлийн эрсдэлгүй орчныг бий болгох ёстой гэж байна. Өөрөөр хэлбэл, Үл хөдлөх хөрөнгийн тухай хуульд барьцааны асуудлыг

иргэн, банк аль алиных нь эрхийг хангасан заалтыг оруулж өгсөн тохиолдолд найман хувийн зээлийг үргэлжлүүлэн олгоно гэсэн байр суурьтай байна.

Улсын хэмжээнд ашиглалтад орж, эзнээ хүлээсэн нийт 839 айлын орон сууц бүртгэгдсэнээс орон нутагт 589, нийслэлд 350 орон сууц нь байна. Дээрх орон сууцаас иргэн байр авахын тулд урьдчилгаа төлбөр 10 хувь төлж, арилжааны банк, тухайн барилгын компани, Барилга хот байгуулалтын яам үлдсэн 20 хувьд баталгаа гаргаж, найман хувийн зээлээр борлуулах эхний алхам ийн тавигдлаа.

Гэхдээ орон сууцны урьдчилгаа төлбөрийг 10 хувь болгох Засгийн газрын хөтөлбөрт Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газраас гаргасан өрхийн амьжиргааны түвшний 5-17 бүлэгт хамрагдсан өрхүүд хамрагдах боломжтой юм.

Барилга хот байгуулалтын яам



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНААР 2015 ОНД ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ



Улсын Их Хурлын чуулганы өнөөдрийн 2016 оны нэгдүгээр сарын 15-ны үдээс хойших нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Монгол Улсын Засгийн газраас 2015 онд Эрчим хүчний салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл хийж, тус салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар танилцуулав.

Монгол Улсын Засгийн газар 2015 онд эдийн засгийн хөгжлийн суурь болсон дэд бүтэц, ялангуяа эрчим хүчний салбарын шинэчлэл, хөгжилд онцгой ач холбогдол өгч ажиллалаа. Энэ ажлын хүрээнд найдвартай, чанартай бөгөөд боломжийн үнэтэй эрчим хүчээр айл өрх, хувийн хэвшлийг хангах зорилгоор Засгийн газраас 6 чиглэлээр цогц арга хэмжээг авч хэрэгжүүлснийг Ерөнхий сайд мэдээллийнхээ эхэнд онцлов. Тухайлбал, эрчим хүчний салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд өнгөрсөн онд Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар нүүрсний давхаргын метан болон метаны агууламж өндөртэй хийг хэрэглэхтэй холбоотой дэд бүтэц, хэрэглэгчийн уялдааг хангах зохицуулалт хийж, байгалийн хий ашиглах эрх зүйн орчин бүрдэв. Мөн Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулиуд болон Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулж батлууллаа. Энэхүү бодлогын баримт бичгийг найдвартай хангамж, үр ашиг, байгаль орчин гэсэн гурван тэргүүлэх чиглэлийн хүрээнд 2015-2023 онд түлш, эх

үүсвэрийн чадлын нөөцийг бүрдүүлж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх суурь бий болгох, 2024-2030 онд эрчим хүч экспортлох, сэргээгдэх эрчим хүчийг тогтвортой хөгжүүлэх үе гэсэн хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх юм. Түүнчлэн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос баталсан “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 02 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо хамтран 2015 оныг үр ашгийг дээшлүүлэх, өртөг зардлыг бууруулах жил болгож ажилласны үр дүнд Төвийн эрчим хүчний систем, Дорнод бүсийн эрчим хүчний систем алдагдалгүй ажиллаж, хуримтлагдсан өр, авлагыг буурууллаа. Өнгөрсөн оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр эрчим хүчний салбарын хэмжээнд 5.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.



Мөн агаарын бохирдлыг бууруулах, гэр хорооллын айл, өрхийн цахилгаан халаагуурын хэрэглээг дэмжих зорилгоор төвийн бүсийн гэр хорооллын айл өрхийн шөнийн цагт хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50 хувиар бууруулах шийдвэрийг Засгийн газрын 2015 оны 469 дүгээр тогтоол, Эрчим хүчний зохицуулах хорооны 293 дугаар тогтоолоор баталсан. Энэ хүрээнд Улаанбаатар хот болон төвийн бүсийн 14 аймгийн хэмжээнд гэр хорооллын айл, өрхийн шөнийн цагт хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50 хувиар бууруулснаар жилд нийтдээ 5.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлэхээр тооцсон байгаа. Өнөөдрийн байдлаар шөнийн цагийн цахилгаан эрчим хүчний үнийн хөнгөлөлтөд 120,000 орчим айл өрх хамрагдаж, 2015 оны 12 дугаар сард шөнийн цагт хэрэглэсэн 17.8 сая кВт.ц цахилгаан эрчим хүчинд 1.4 орчим тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлээд байна гэлээ.



Харин эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох чиглэлээр “Багануурын 700 МВт-ын цахилгаан станц”, “Дулааны цахилгаан станц-5” төслийн гүйцэтгэгчтэй концессын гэрээ, Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулсан бол “Баруун бүсийн 60 МВт-ын дулааны цахилгаан станц”, “Дорнод бүсийн 100 МВт-ын дулааны цахилгаан станц”-ын концессын гэрээний хэлцэл, “Бөөрөлжүүтийн цахилгаан станц”-ын гүйцэтгэгчтэй Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний хэлцэл, “Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хийгдэж байна. Түүнчлэн “Эгийн голын усан цахилгаан станц”, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг 35 МВт-аар нэмэгдүүлэх”, “Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих” төслийн хөрөнгө оруулалтыг БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв аймгийн төвд дулааны эх үүсвэр, дулааны шугам барих төслийг БНСУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхээр Засгийн газрын шийдвэр гараад байгааг дурдав.

Мөн Ерөнхий сайдын 2015 оны 64 дүгээр захирамжаар ажлын хэсэг гаргаж ажиллуулснаар салбарын хэмжээнд цалингийн зардлыг 0.48 тэрбум, түлшний зардлыг 2 тэрбум, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 6 тэрбум төгрөгөөр бууруулж, үйл ажиллагааны нийт зардлыг 8.5 тэрбум төгрөгөөр хэмнэж чадлаа. Мөн ОХУ болон БНХАУ-аас өндөр үнэтэйгээр худалдан авдаг эрчим хүчний импортын хэмжээг бууруулж, дотоодын үйлдвэрлэгчдээ дэмжиж ажилласны үр дүнд эрчим хүчний импортыг 120 гаруй сая.кВт.цагаар буюу 18 тэрбум төгрөгөөр бууруулсан. Мөн дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээг 0.6 нэгжээр, дамжуулалтын алдагдлыг 0.1 нэгжээр, цахилгаан түгээлтийн алдагдлыг 0.5 нэгжээр тус тус бууруулснаар хэрэглэгчдэд түгээх цахилгаан эрчим хүчийг 79.5 сая.кВт.цагаар нэмэгдүүлсэн гэдгийг хэллээ.

“Амгалан” дулааны станц 2015 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа эхэлснээр Улаанбаатар хотын зүүн хэсгийн 20 мянган хэрэглэгчийн дулаан хангамж сайжирч, шинээр 40 мянган хэрэглэгчийг дулаанаар хангадаг боллоо. Эрчим хүчний салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалт, Хөгжлийн банкны санхүүжилтээр 2015 онд нийт 66 төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил хийж, улсын комисст хүлээлгэн

өглөө. Ашиглалтад оруулсан нийт шугам сүлжээ, барилга байгууламжийг цахилгаан, дулааны чиглэлээр ангилан авч үзвэл 300 Гкал/ц-ийн хүчин чадалтай дулааны эх үүсвэр, 29.7 км дулааны шугам сүлжээ шинээр барьж, төвлөрсөн дулаан хангамжид 249 Гкал/ц ачааллыг нэмэх боломжийг бүрдүүлсэн. Өнөөгийн байдлаар 87 Гкал/ц хэрэглээг сүлжээнд залгаж, ойролцоогоор 250 орон сууцыг төвлөрсөн дулаанд холболоо. Харин 0.22-110 кВ-ын 1064 км цахилгаан дамжуулах шугам, 0.22-110 кВ-ын 466 дэд станц, хуваарилах байгууламжуудыг шинээр барьж ашиглалтад оруулснаар Улаанбаатар хот болон хөдөө орон нутгийн 120 мянга гаруй айл өрхийг цахилгааны эрчим хүчээр хангах боломж бүрдсэн гэдгийг Ерөнхий сайд дурдаад 2015 онд эрчим хүчний салбарын хэмжээнд ашиглалтад орсон томоохон төслүүд, салбарын үнэ тарифын зохицуулалтын талаар танилцуулсан юм.

Ерөнхий сайд мэдээллийнхээ төгсгөлд, тус салбарын хэмжээнд 2016 онд “Хүртээмжтэй эрчим хүч” гэсэн зорилт тавьж, бүтээн байгуулалтын МЕГА төслүүдийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Энэ хүрээнд салбар системийн бие даасан байдлыг хангах, томоохон хүчин чадлын эх үүсвэрүүдийг барих ажлыг эхлүүлэх, эрчим хүчний импортын хараат байдлаас гарах, эрчим хүчний нэгдсэн систем бий болгох ажлыг эхлүүлнэ. Мөн өндөр насжилттай тоноглолуудыг орчин үеийн дэвшилтэт шинэ техник, технологиор солих ажлыг үе шаттайгаар хийж, хүний хүчин зүйлсээс хамаарах хамаарлыг бууруулах чиглэлийг барьж ажиллах болно. Түүнчлэн сүүлийн гурван жил хийсэн эрчим хүчний үнэ, тарифын бодлогын өөрчлөлт, зах зээлийн зарчмаар ажиллахаар тавьсан эхлэлийг үргэлжлүүлж, цаашид эрчим хүчний үнийг өөрийн өртөгт хүргэх, өрсөлдөөнийг бий болгохоор төлөвлөж байгааг онцоллоо.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Ж.Энхбаяр, Ж.Батсуурь, Ц.Нямдорж, А.Тлейхан, Д.Лүндээжанцан, Ё.Отгонбаяр, Ө.Энхтүвшин, Ч.Хүрэлбаатар, Д.Хаянхярваа нар асуулт асууж тодруулсан юм. Гишүүдийн асуултад Ерөнхий сайд Ч.Сайханбилэг болон Эрчим хүчний сайд Д.Зоригт, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга С.Отгонбаяр нар хариулт өглөө. Мөн гишүүдийн зарим асуултад ажлын хэсгээс нэмэлт хариулт өгсөн юм.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Засгийн газрын гишүүд, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооны холбогдох албан тушаалтнууд оролцлоо.



БАГАНУУРЫН ЦАХИЛГААН СТАНЦЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ ЭХЭЛЛЭЭ



Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Монгол Улсын төвийн бүсийн эрчим хүчний системийн өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах, импортын цахилгаан эрчим хүчийг хаах гэсэн зорилт бий. Энэ хүрээнд Багануурт 700 МВт хүчин чадалтай станц байгуулахаар шав тавьлаа. Энэхүү арга хэмжээнд МУ-ын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Эрчим хүчний сайд Д.Зоригт, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга С.Отгонбаяр тэргүүтэй албаны хүмүүс оролцсон юм.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Монгол Улс анх удаа уурхайн амаа түшиглэж цахилгаан станц барих гэж байна. Засгийн газар эрчим хүчний бодлогынхоо том өөрчлөлтийг энэ төслөөр эхлүүлж байна. Мөн Бөөрөлжүүтийн нүүрсний ордыг түшиглэж Бөөрөлжүүтийн цахилгаан станц, усны эх үүсвэрээ түшиглэж Эгийн голын усан цахилгаан станц баригдана. Тавантолгойн цахилгаан станц ч мөн уурхайгаа түшиглэн баригдана гэж хэллээ.

Багануурын цахилгаан станцын энэ төсөл Монгол, Хятад хоёр улс эрчим хүчний салбарт амжилттай хамтран ажиллаж байгаагийн илэрхийлэл гэдгийг мөн онцоллоо. БНХАУ-тай хамтран “Амгалан” дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалтын төслийг амжилттай хэрэгжүүлж нэг сарын өмнө станцаа ашиглалтад орууллаа. Дулааны III станцын хүчин чадлыг 50 МВт-

аар өргөтгөсөн бол одоо Багануур болон Бөөрөлжүүтийн цахилгаан станц, Эгийн голын усан цахилгаан станцыг ажлыг хамтдаа хийж гүйцэтгэнэ гэж Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Багануурын цахилгаан станцын талбайн ажлыг нээж хэлсэн үгэндээ тэмдэглэлээ.

Багануурын цахилгаан станц Багануур хотын хөгжийн гараа, нүүр царай болох төсөл. Энэхүү бүтээн байгуулалтыг дагаж Багануур хотод шинэ ажил, амьдрал өрнөх болно. 3,5 жилийн дараа бидний

цугласан энэ талбайд 700 МВт хүчин чадалтай том станц босно гэж Ерөнхий сайд хэлээд энэхүү бүтээн байгуулалтыг хийх БНХАУ-ын “China nuclear industry 22” корпорацийн хамт олон хүлээсэн үүргээ хамгийн сүүлийн үеийн технологиор, цаг хугацаатай уралдан амжилттай гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна. Монгол Улсын Засгийн газар, орон нутгийн удирдлага бүтээн байгуулалтын энэ ажлыг бүх талаар дэмжиж ажиллах болно гэдгээ илэрхийллээ.

“Багануур Пауэр” ХХК энэ оны дөрөвдүгээр сард Хөрөнгө оруулалтын газартай Багануурын цахилгаан станц төслийг барих-ашиглах-шилжүүлэх нөхцөлөөр Концессийн гэрээ байгуулсан юм. Энэ төсөл хэрэгжсэнээр 300 гаруй тогтмол ажлын байр, 2500 орчим ажлын байр шинээр бий болно. Багануурын цахилгаан станцын талбайн ажлын нээлтэд Эрчим хүчний сайд Д.Зоригт, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхэт Элчин сайд Син Хайми нар оролцлоо. Багануур хотод баригдах үйлдвэр технологийн парк, Оюутны хотхон зэрэг бүтээн байгуулалтын цахилгаан эрчим хүч, дулаан хангамжийг бүрэн шийдвэрлэж, Багануур дүүргийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулах юм гэж Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албанаас мэдээллээ.



“ХОТ, СУУРИН УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ” СЭДЭВТ ЦУВРАЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛОВ

Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо “Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь” сэдэвт цуврал хэлэлцүүлгийг өнөөдөр /2015.12.23/ Төрийн ордонд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын гишүүд, Барилга хот байгуулалтын яам, Сангийн яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Усны Үндэсний хороо, Туул голын сав газрын захиргаа, Барилгын хөгжлийн төв, Ус сувгийн удирдах газар, Улаанбаатар хотын Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар, Төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцлоо.



Хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар нээж, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд иргэдээс усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой хэрэглэх, усны нөөц ашигласны төлбөрийн төвлөрүүлэлт, зарцуулалт, иргэдийг эрүүл, аюулгүй ундны усаар хангах асуудалтай холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих асуудлаар өргөдлүүд тогтмол ирдэг бөгөөд эдгээр өргөдлийн дагуу тус Байнгын хорооны 2015 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор “Усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаарх иргэдийн өргөдлийг судлан Байнгын хорооны

хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий” ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Х.Баттулга, Д.Сарангэрэл нар ажиллаж байгаа юм.

Ажлын хэсгийн хүрээнд өнөөдрийн хэлэлцүүлгийг зохион байгуулж байгааг Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар онцлоод, хэлэлцүүлгийн үр дүнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналуудыг цуглуулж, цаашид Байнгын хороогоор хэлэлцүүлэх, эрх зүйн орчныг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэж буйгаа хэллээ.

Цэвэрлэх байгууламжуудын үйл ажиллагааны талаар, ундны усны эрүүл, аюулгүй байдлын талаар, усны нөөц ашигласны төлбөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар зэрэг сэдвүүдээр Ажлын хэсгийн хүрээнд цуврал хэлэлцүүлэг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд эхний ээлжинд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр эрдэмтэн, мэргэжилтнүүдийнхээ санаа бодлыг сонсож, хуулийн хэрэгжилтийг хангах, шийдвэрлэх гарцыг олох, түүнийг цаашдын үйл ажиллагаандаа тусгах зорилготой ажээ.



Хэлэлцүүлэгт “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр Барилга, хот байгуулалтын яамны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Р.Батчимэг,



“Хуулийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоо, цаашид анхаарах асуудлууд” сэдвээр Усны үндэсний хорооны ажлын албаны дарга Ц.Бадрах,



“Салбарын байгууллагуудад хэрэгжсэн төслүүдийн дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийн асуудал, төрөөс баримталж буй бодлого” сэдвээр Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн М.Мөнх-Эрдэнэ нар санал бодлоо солилцов.



“Салбарын байгууллагуудын санхүүгийн чадавх, үнэ, тарифын бодлого, цаашдын зорилт” сэдвээр, “ Хүн амын эрүүл мэндэд ус, хөрсний бохирдлын үзүүлэх нөлөө” сэдвээр НЭМХ-ийн Орчны эрүүл мэнд, хор судлалын эрдэм шинжилгээний ажилтан доктор /PhD/ Ш.Батдэлгэр,



Салбарт шинээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын техник, эдийн засгийн үзүүлэлтэд цаг хугацааны үнэ цэнийг тусгасан зардал, үр ашгийн тооцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх шаардлагатай байгааг оролцогчдын зүгээс хэлж байсан юм. Мөн нийгэм, эдийн засгийн үр ашгийг үндэслэн хөрөнгө оруулалтын шийдвэрийг гаргаж байх, энэ шатанд Зохицуулах зөвлөлийн оролцоог хангах, сумдад шинээр байгуулагдсан болон байгуулагдаж байгаа Усны хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн өмчлөл, ашиглалтын асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үүнд Зохицуулах зөвлөлийн оролцоог хангах нь зүйтэй гэсэн саналыг гаргалаа.



Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ч.Эрдэнэчимэг нар илтгэл тавьж хэлэлцүүлэн оролцогчид салбарын санхүү, эдийн засгийн байдал, үйлчилгээний чанар, тулгарч буй хүндрэл бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар

Улсын их хурлын
Өргөдлийн байнгын хороо



УХААЛАГ ХУДАГ 24 ЦАГИЙН ТУРШ ИРГЭДЭД ҮЙЛЧИЛЖ ЭХЭЛЛЭЭ



Ус сувгийн удирдах газраас гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээг хүртээмжтэй хялбар болгох үүднээс нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн 20 орчим ус түгээх худгийг ухаалаг системд шилжүүлж 24 цагийн үйлчилгээ явуулдаг болжээ.



Энэ талаар Сүхбаатар дүүргийн есдүгээр хороонд байрлах ус түгээх худгийн ажилтан “Ухаалаг системд шилжсэн нь хэрэглэгч болон худгийн ажилтны аль алины ажлыг хөнгөвчилж байна. Манайх нэг ажилтан 12 цагаар хоёр ээлжтэй ажиллаж байгаа. Ерөнхийдөө оройн 20-22 цагийн хооронд иргэд их үйлчлүүлж байна. Харин ухаалаг картны хувьд 1000, 3000, 5000, 10000 гэсэн картууд байгаа. 1000, 3000 төгрөгийн картууд зарагдаж дуусаад байна. Мянган төгрөгийн картаар нэг тонн ус авах юм. Харин картгүй хүмүүст бэлэн мөнгөөр үйлчилж байна. Манай худаг ачаалал ихтэй үед өдөртөө 23 тонн ус хэрэглэгчдэд түгээж байна” гэсэн юм.

Харин тус худгийн үйлчлүүлэгч Сүхбаатар дүүргийн оршин суугч “Ухаалаг картаар усаа авч байгаа. Заавал бэлэн мөнгө гэхгүй амар болсон. Хэдэн литр ус авах гэж байгаагаа төхөөрөмж дээр бичихэд тэр хэмжээнд хүрээд ус цаанаасаа зогсдог. Сав хальж гадуур нь ус асгарахгүй гээд ерөнхийдөө сайхан үйлчилгээ болсон байна” гэлээ.

Ухаалаг худаг 24 цаг ажиллах ба иргэд тухайн худгаас картаа авч цаашид төхөөрөмжид картаа уншуулж усаа авах ба дансны үлдэгдлээ харж болох юм. Харин картан дахь мөнгө дуусвал Ус сувгийн удирдах газрын дансанд мөнгөө байршуулж үргэлжлүүлэн картаа ашиглана. Усны үнийн хувьд 1000 төгрөгөөр нэг тонн, 3000 төгрөгөөр гурван тонн, 5000 төгрөгөөр таван тонн, 10000 төгрөгөөр 10 тонн ус авах юм. Одоогоор Баянзүрх дүүргийн 2,10,17,21, 27-р хороо, Чингэлтэй дүүргийн 13,15,18-р хороо, Сүхбаатар дүүргийн 9,10,16-р хороо, Баянгол дүүргийн 16-р хороонд орших 4654




өрхийн 18600 хүн амд үйлчилж эхлээд байна. Цаашид 100 гаруй цэгт дээрх төхөөрөмжийг суурилуулж 24 цагын үйлчилгээтэй ухаалаг худагтай болохоор төлөвлөөд байгаа аж.



Ухаалаг ус түгээх цэгүүд:

1. БЗД 2-р хороо 32-р гудамж
2. БЗД 2-р хороо сэлбийн 13 гудамж
3. БЗД 2-р хороо 35-р гудамж
4. БЗД 10-р хороо Улиастайн задгай
5. БЗД 17-р хороо Эмнэлэгийн 10 гудамж
6. БЗД 21-р хороо сэлбийн 10 гудамж
7. БЗД 21-р хороо сэлбийн 41 гудамж
8. БЗД 21-р хороо Сэлбийн 41-р гудамж
9. БЗД 27-р хороо Сэлбийн 25 гудамж
10. ЧД 13-р хороо Сургуулийн 23 гудамж
11. ЧД 15-р хороо Сургуулийн 20 гудамж
12. ЧД 15-р хороо Жаргалтантын 6 гудамж
13. ЧД 15-р хороо Жаргалтантын 9-р гудамж
14. ЧД 18-р хороо Яргайтын
15. БГД 16 хороо Туулын 5 гудамж
16. СБД 9-р хороо Дөлгөөн нуур ХХК-ны зүүн талд
17. СБД 10-р хороо 100 айл
18. СБД 16-р хороо Бэлхийн 18-608
19. СБД 16-р хороо дамбадаржаагийн 3 гудамж
20. СБД 16-р хороо Бэлхийн 27-р гудамж

Б.ЦОГ





БАТЛАВ. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ПҮРЭВЖАВ

**МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2016 ОНД ЗОХИОН
БАЙГУУЛАХ СУРГАЛТ СЕМИНАРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2015.12.09

Д/ д	Сургалтын төрөл	Хамрагдах хүний мэргэжил	Огноо	Сургалтын төлбөр
1. Дотоод				
1.1 СУРГАЛТЫН ТӨВД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР				
1	Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын ахлах болон ерөнхий инженерүүдийг чадавхжуулах сургалт	Инженер	1-р сар	195000
2	Хувийн Орон сууц нийтийн аж ахуйн компанийн захирлуудын сургалт	Захирал	1-р сар	
3	Цэвэр ба бохир усны насосны станцын машинистын мэргэжил олгох сургалт	Машинист	1-р сар	250000
4	ХААЭАхуйн инженерийн чадавхжуулах сургалт	Инженер	2-р сар	195.000
5	Цахилгааны инженер болон цахилгаанчдын мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалт	Цахилгааны инженер болон цахилгаанчин	2-р сар	195.000
6	Усны тоолуурын засварчныг чадавхжуулах сургалт	засварчин	3-р сар	210.000
7	Сантехникийн засварчны мэргэжил олгох сургалт	засварчин	4-р сар	280.000
1.2 УСУГ-н УСНЫ ЛАБОРАТОРИТОЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР				
8	Усны шинжилгээний лабораторийн химичийг чадавхжуулах сургалт	Химич	1-р сар	200.000
9	Усны шинжилгээний лабораторийн бактериологичийг чадавхжуулах сургалт	бактериологич	5-р сар	200.000
10	Усны шинжилгээний лабораторийн лаборантыг чадавхжуулах сургалт	Лаборант	10-р сар	200.000
1.3 БУСАД СУРГАЛТЫН ТӨВТЭЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР				
11	НАА-н салбарын хүний нөөцийн менежерийн мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалт	хүний нөөцийн менежер	3-р сар	220.000
12	НАА-н салбарын нягтлан бодогчдыг чадавхжуулах сургалт	нягтлан	4-р сар	240.000
13	НАА-н салбарын удирдах ажилтныг чадавхжуулах сургалт	удирдах ажилтан	10-р сар	



2. Орон нутагт зохион байгуулах сургалт			
14	"Цант Орхон" ХХК	Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу
15	"Эрдэнэт УДТС" ОНӨҮГ	Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу
16	"Чандмань Бадрал" ХХК	Засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу
17	"Дулаан шарын гол" ОНӨҮГ	Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу
18	"Ундарга" ОНӨҮГ	Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу
19	"Онги ус" ОНӨҮГ	Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу
20	"Чандмань Увс" ОНӨҮГ	Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу
21	"Амь ус трейд" ОНӨҮГ	Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу
22	"СУАТ" ХХК	Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу
23	"Шим ус" ХХК	Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу
24	"Ундарга Алтай" ОНӨҮГ	Ус түгээгч, засварчин, машинист	Хугацааг тохиролцсоны дагуу

Төлөвлөгөө гаргасан: Сургалтын мэргэжилтэн

Б.Алтантуул



БАТЛАВ. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б. ПҮРЭВЖАВ

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний хөлбооноос 2016 онд гадаадад (олон улсад) зохион байгуулах сургалт, семинар, семинарын төлөвлөгөө

2015.12.09

№	Олон улсад зохион байгуулагдах сургалт, семинар, үзэсгэлэн бага хурал	Үзэсгэлэн, сургалт, семинар болох улс	Хугацаа	Хамрагдах хүний тоо	Очих улс	Нийт зардал
1	"NANB International Builders' Show" 2016 "Барилгын салбарын орчин үеийн дэвшилтэт техник технологи, тоног төхөөрөмж болон сантехникийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл"-н талаар мэдээ мэдээлэл хийсэн олон улсын үзэсгэлэн тавигдаж, бага хурал болно. Жил бүр дэлхийн 100 гаруй орны 50000 гаруй хүн оролцдог томоохон үзэсгэлэн шоу юм.	АНУ-ын Невада мужийн Лас Вегас хот	I/15-24	8	АНУ-н Лас-Вегас, Сан Франциско хот Нийт 9 хоног	4100 \$
2	SBW expo 2016 Ус хангамж болон ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж, сантехникийн тоног төхөөрөмжийн үзэсгэлэн тавигдаж болно	БНХАУ-ын Бээжин хот	IY/12-19	8	БНХАУ-ын Бээжин хот Нийт 7 хоног	1,500,000 ₮
3	Pollution control & Sustainable environment 2016 Бохирдлын хяналт ба байгаль орчны тогтвортой байдал, Бохир усны хүрээлэн буй орчинд нөлөөлөх нь олон улсын бага хурал болно.	АНЭУ-ын Дубай	IV/25-30	8	АНЭУ-ын Дубай хот Нийт 6 хоног	2000 \$
4	"Орон сууц ашиглалтын менежмент" ОСНАА-н салбарын инженер техникийн ажилтан болон мэргэжилтэн, удирдах ажилтны 7 хоногийн сургалт	Солонгос улсын Сеул хот	V/04-11	8	Солонгос улсын Сеул хот Нийт 7 хоног	1800 \$
5	World Leading Trade Fair for Water, Sewage, Waste and Raw Materials Management Messe Munchen 2 жилд 1 удаа зохион байгуулагдаж дэлхийн томоохон үзэсгэлэн. Уг үзэсгэлэнгээр бохир ус, хог хаягдал, ариутгах татуургын инженерийн шугам сүлжээнд ашиглагдаж буй хамгийн сүүлийн үеийн шинэ техник технологи, техникийн шийдлийн талаар танилцуулга хийж үзэсгэлэн, бага хурал болно	ХБНГ-ын улс Мунхен хот	V/30-VI/09	8	Герман, Итали, Швейцарь, Франц, Австри Нийт 10 хоног	3,200 €



6	Aquatech China 2016	Сантехникийн тоног төхөөрөмжийн хамгийн сүүлийн үеийн шинэ техник технологи, техникийн шийдлийн талаар танилцуулга хийсэн үзэсгэлэн болно.	БНХАУ-ын Шанхай хот	VI/12-19	8	БНХАУ-ын Бээжин, Шанхай хот Нийт 7 хоног	1,900,000 ₪
7	Water Expo 2016, The 7th Singapore International Water Week	Сингапурын олон улсын усны 7 хоног нь 2 жилд 1 удаа зохион байгуулагддаг бөгөөд 7 дахь удаагаа болох гэж байна. Хотын ус хангамж, үйлдвэрийн ус хангамж, байгаль орчин, хэтийн төлөв гэсэн сэдвүүдээр хэлэлцүүлэг хийж санал солилцон, салбарын дэвшилтэт техник технологи, шинэ санаа болон туршлага солилцоно.	Сингапур	VII/04-10	8	Сингапур, Малайз улс Нийт 6 хоног	2200 \$
8	Water Smart Innovations Conference and Exposition 2016	Ус хангамж, ариутгах татуургын инженерийн шугам сүлжээнд ашиглагдаж буй дэвшилтэт шинэ техник технологи, техникийн шийдлийн талаар үзэсгэлэн тавигдаж, дэлхийн өнцөг булан бүрээс мэргэжилтнүүд болон инженерүүд хүрэлцэн ирж шинэ санаа болон санал бодол, туршлага солилцсон бага хурал болно.	АНУ-ын Невада мужийн Лас Вегас хот	X/05-15	8	АНУ-н Лас-Вегас, Сан Франциско хот Нийт 10 хоног	4100 \$
9	IWA World water congress & Exhibition 2016	Дэлхийн усны их хурал болон үзэсгэлэнд 100 гаруй орны 5500 гаруй усны мэргэжилтэн, инженерүүд оролцож устай холбоотой шинжлэх ухаан, технологийн шинэчлэл, усны менежмент, чанар эрүүл мэнд гэсэн асуудлууд тавигдана.	Австрали улсын Брисбани хот	XI/6-13	8	Австрали улсын Брисбани хот Нийт 7 хоног	3000 \$
10	Япон улсын Саппоро хотын Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах сургалт	Япон улсын Саппоро хотын Ус ашиглалтын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах сургалт	Япон улсын Саппоро хот	XI/01-10	8	Япон улсын Саппоро хот, Токио хот, Нарита хот Нийт 9 хоног	2000 \$

Жич: Тухайн төлбөрт урилга, визний хураамж, ирэх очих онгоцны билет, сургалт, үзэсгэлэн, семинар, үзвэр, унаа, аялалын зардал, буудал, хоолны үнэ багтсан бөгөөд тухайн үед бага зэрэг өөрчлөгдөж болно.

Төлөвлөгөө гаргасан: Сургалтын мэргэжилтэн

Б.Алтантуул



МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2015 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ СЕМИНАР

Хот, хөдөөгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын удирдлага болон инженер техникийн ажиллагсдыг бэлтгэх, мэргэжил, мэдлэг, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх мэргэжлийн 10 удаагийн сургалтыг Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулж 289 инженер техникийн ажилтан хамруулж чадавхжуулж мэргэжил, мэдлэг олголоо. Үүнээс:

- Мэргэжлийн чадварлаг багш нарын хамт байгууллага дээр нь очиж богино хугацаанд олон ажилтан хамруулсан сургалт зохион байгуулсан бөгөөд “Дархан Ус суваг” ХХК, “Дорнод НАА” ХХК, “Хөвсгөл Ус Чандмань” ОНӨҮГ, “Багануур Ус” ОНӨААТҮГ-ын нийт 4 аймгийн 4 байгууллагын ус түгээх байрны ус түгээгчийн мэргэжил олгох сургалт, цэвэр, бохир усны насосны станцын машинч, цэвэрлэх байгууламжийн машинч, цэвэр, бохир усны хоолойн засварчин, тоног төхөөрөмжийн засварчин гэх мэт 204

ажилчдад мэдлэг, чадвары гээмшүүлснээс гадна мэргэжлийн зөвлөгөө өгч ажилласан.

- Мэргэжлийн сургалтын төвүүдтэй хамтарч салбарын удирдлага болон инженер техникийн ажиллагсадын мэргэжил, мэдлэг, урчадвар, ёс зүйг дээшлүүлэх мэргэжлийн 6 төрлийн сургалтад 85 инженер техникийн ажилтан хамруулж мэдлэг, мэргэжил олголоо. Үүнд

Гадаад харилцаа

Салбарын ажлын чиглэлээр олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэнд оролцох, хөгжилтэй орны зорилго нэгтэй байгууллагатай хамтран ажиллаж харилцаа холбоо тогтоож, тэргүүн туршлага, техник технологитой газар дээр нь танилцаж өөрийн улс орондоо нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэхүүднээс АНУ, ХБНГерман улс, Солонгос гэсэн 3 улсын 4 удаагийн сургалтад 34 хүн хамруулж зохион байгууллаа.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ХӨВСГӨЛ УС ЧАНДМАНЬ” ОНӨҮГ-Н “УС ТҮГЭЭХ БАЙРНЫ УС ТҮГЭЭГЧ”-Д СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хөвсгөл аймгийн “Хөвсгөл Ус Чандмань” ОНӨТҮГ Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоотой хамтран ажилтнуудаа бэлтгэх, мэргэшүүлэх, мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх үүднээс гэр хороололлын оршин суугчдад ус түгээдэг 35 ус түгээх байрны “Ус түгээх байрны Ус түгээгч” нарт мэргэжил олгох сургалтыг 2015 оны 06-р сарын 24,25-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сургалтаар Ус түгээх байранд ажиллагсдын үндсэн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, ашиглалт, Усны чанар, усны ашиг тус, аюулгүй байдал, УТБ-ны эрүүл ахуй ариун цэврийн шаардлага, хувийн

ариун цэвэр, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай, харилцааны соёлын талаар сургалт явуулж сургалтанд 35 ус түгээгч, идэвхи санаачлагатай оролцож, “Ус түгээгч” гэсэн мэргэжлийн чадамжийн гэрчилгээ гардан авч Монгол орны аль ч аймагт очиж ажиллах эрхтэй боллоо. Энэ сургалтанд Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооноос мэргэжлийн сургагч багш нар газар дээр нь сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулж мэдлэг олгож, сургалтанд хамрагдсан Ус түгээгчид маш өндөр сэтгэгдэлтэй байлаа.





АНУ-Н ЛАС ВЕГАС ХОТОД “WATER SMART INNOVATIONS 2015” ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН БАГА ХУРАЛД ОРОЛЦООД ИРЛЭЭ

2015 оны 10-р сарын 06-14-ны өдрийн хооронд АНУ-ын Лас Вегас хотын South Point зочид буудлын Conference center танхимд “Water Smart Innovations 2015” нэртэй дэлхийн томоохон хотуудын усны үр ашигтай, хэмнэлттэй байдлын тухай олон улсын 8-р бага хурал зөвөлгөөн, үзэсгэлэнд 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцоод ирлээ.



South Point Hotel-ийн төвд болсон 8-р бага хуралд АНУ-гийн 35 мужийн өнцөг булан бүрээс 900 гаруй мэргэжилтэн, Австрали, Монгол, Хятад, Дани, Энэтхэг, Израль, Мехсик, Нидерланд, Польш, Шинэ Зеланд зэрэг 11 орны мэргэжилтэнүүд усны үр ашигтай хэрэглээний талаар өөрсдийн санал туршлагаа хуваалцахаар хүрэлцэн ирсэн.


“Water Smart Innovations”-2015 бага хуралтай зэрэгцэн үзэсгэлэнгийн танхимд 70 гаруй компани байгууллага усыг үр ашигтай зарцуулах хамгийн сүүлийн үеийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ил гарган тавьсан. Clark County Wetland парк, Hoover Dam, Venetian Resort-уудад усны үр ашигтай байдлын зөв дадал болон усны нөөцийн талаар техникийн аялал, танилцуулга хийсэн. Энэхүү Water Smart Innovations бага хурал нь хэрэглээний усны талаарх хэлэлцүүлгийн дэлхий дэх хамгийн том арга хэмжээ

юм. Өнгөрсөн 7 жилийн хугацаанд усны мянга мянган мэргэжилтнүүдийг дэлхийн улс орон бүрээс сонгон авч хамтран ажиллаж, санал туршлагаа солилцсоор ирсэн. Хуралд оролцсоноор усны хэрэглээний хамгийн сүүлийн үеийн хөгжлийн талаарх мэдээллээр хангагдсан.

Мөн Лас Вегас хотын Clark County Wetland парк, Hoover Dam, Venetian Resort-уудад хэрэгжүүлсэн усны зүй зохистой хэрэглээ зөв дадал, усыг хэмнэх аргачлал болон усны нөөцийн талаар саарал усыг эргүүлэн ашиглах талаар техникийн аялал хийж, туршлага судаллаа. техникийн аялал хийж туршлага судаллаа.

Өдөр тутмын ердийн хэрэглээнээс гарч байгаа усны бараг 50 орчим хувийг гал тогооны угаагуур, душнээс гарч байгаа саарал ус эзэлдэг байна. Усанд орсоны дараах халуун ус нь ихэнхдээ цэвэр саарал ус байдаг. Гэтэл амьдрал дээр энэ ус шууд бохир усны шугам руу орж урсдаг. Ус болон цахилгааны хэрэглээ хоорондоо холбоотой. Усыг халаахын тулд цахилгаан энерги ихээр зарцуулж, нүүрс хүчлийг ялгаруулан улмаар байгаль орчинд агаарын бохирдол үүсгэж байна. Гэтэл хэрэглээнээс гарч байгаа халуун усыг зүгээр асгаж, үргүй зардал өссөөр л байдгийг бид анзаардаггүй талаар мөн хөндөн ярьлаа.

Америкийн нэгдсэн улсын Лас Вегас хот, Сан Франциско хоттой танилцаж, аяллаа.






“НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТАНЫГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ” ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Салбарын байгууллагын дарга, захирал нарт «НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТАНЫ» 3 хоногийн сургалт, хэлэлцүүлгийг 2015 оны 11 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтад орон нутгийн 19 байгууллагын захирал, удирдлага хамрагдаж сургалт амжилттай зохион байгуулагдлаа.

Д/д	Байгууллагын нэр	Захирал / дарга-ын нэр	Ажлын утас	Мэйл хаяг
1	Увс сумын байгууллага	С.Ариунболд	9601 6946	Sak0015@yandex.com
2	Увс сумын байгууллага	О.Болд	96051241	001.000000@yandex.com
3	Увс сумын байгууллага	П.Доржпалсан	9905 8274	L.Pure111@yandex.com
4	Увс сумын байгууллага	М.Насран	9944462	Холбоо@yandex.com
5	Увс сумын байгууллага	Б.Балд	9911822	6.00000000@yandex.com
6	Увс сумын байгууллага	С.Балд	9905 8889	
7	Увс сумын байгууллага	М.Насран	9905 5018	
8	Увс сумын байгууллага	О.Болд	99 8113	001.000000@yandex.com
9	Увс сумын байгууллага	У.Салсан	99070302	0011-09@yandex.com
10	Увс сумын байгууллага	Б.Толгой	9945 2001	Shagran.000000@yandex.com
11	Увс сумын байгууллага	Г.Цогтсайхан	99095119	УС-650400@yandex.com
12	Увс сумын байгууллага	Д.Сүхбаатар	99462222	764.2222@yandex.com
13	Увс сумын байгууллага	З.Ариунболд	9905 8880	001.000000@yandex.com
14	Увс сумын байгууллага	Б.Балд	99155322	001.1853@yandex.com
15	Увс сумын байгууллага	С.Балд	9905 8880	001.000000@yandex.com
16	Увс сумын байгууллага	У.Салсан	9905 8880	001.000000@yandex.com
17	Увс сумын байгууллага	П.Доржпалсан	9905 8880	001.000000@yandex.com
18	Увс сумын байгууллага	М.Насран	9918 712	001.000000@yandex.com
19	Увс сумын байгууллага	Р.Эрдэнэцэг	99034298	



Сургалтаар Барилга, хот байгуулалтын яамны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын орлогч дарга Р.Эрдэнэцэг Нийтийн аж ахуйн системд хэрэгжүүлж буй ажлын мэдээлэл 2016 оны зорилго, зорилтын талаар мэдээлэл хийж удирдлагуудтай харилцан ярилцлаа.



Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн мэргэжилтэн Ариунаа Салбарын санхүү эдийн засгийн байдал, Усны баланс тооцох аргачлал, Зардлын бүртгэл өртгийн хуваарилалт гэсэн сэдвүүдээр мэдээлэл хийлээ.



Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний Үндэсний зөвлөхүүдийн ахлах С.Бумаа “Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө” боловсруулах сургалтыг аймаг орон нутагт зохион байгуулж буй явцын талаар мэдээлэл хийлээ.



Барилгын хөгжлийн төвийн Орон сууц, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Ө.Цэдэндамба Нийтийн аж ахуйн салбарт шинэчилж буй норм, дүрэм, журам, стандартын талаарх мэдээлэл хийлээ.



“Наран Рашаан” ХХК-ийн захирал Г.Буд Аймаг, сумдын цэвэрлэх байгууламжийг шинэчлэн сайжруулах зураг төслийн үр дүнгийн талаар мэдээлэл хийлээ.



Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн В.Дэлгэрмаа



Удирдлагын Академийн Сургалтын албаны дарга Р.Бадралмаа Удирдах ажилтны удирдах арга барилыг сайжруулах сэдэвт сургалт явууллаа.



МУ-н Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, МУ-н зөвлөх инженер, Техникийн ухааны мастер, Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны гүйцэтгэх захирал Б.Пүрэвжав Нийтийн аж ахуйн салбарын үйл ажиллагаа, цаашдын явц, Хөдөө орон нутгийн цэвэрлэх байгууламжийн ашиглалт, боловсон хүчний сургалт, чадваржилтийн талаар мэдээлэл хийлээ.



Налайх дүүрэгт шинээр байгуулж ашиглалтад оруулсан цэвэрлэх байгууламж мөн цэцэрлэг сургуулийн ус хангамж, халаалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар, шинэ техник технологи, арга ажиллагаатай танилцаж, Чандмань Налайх ОНӨААТҮГ-тай танилцах сургалт зохион байгууллаа.



МНААҮХолбоо, Булган аймгийн “Булган МЭЭЖ” ХХК хамтран “МОНГОЛД НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 84 ЖИЛИЙН ОЙ, НИЙТИЙН АЖ АХУЙ, АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТАНЫ ӨДӨР”-г тохиолдуулан салбарын дарга нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг “ХААН ЖИМС” Жуулчны баазад зохион байгуулж нэг өдрийг цэвэр агаарт сайхан өнгөрүүлээд ирлээ.

Орон нутгийн Нийтийн аж ахуйн байгууллагын дарга нарын дунд Зүүн, Баруун, Хангайн бүс гэсэн баг болгон хөл бөмбөг, олс таталт, дартсын тэмцээн зохион байгуулж авхаалж самбаа хурд хүчээ сорьлоо.





Хөл бөмбөг 3-р байранд Баруун бүсийн баг. Зүүн гар талаас Төв Чандмань ДЭХГ-н Дарга Г.Цогтсайхан, Ундарга ХХК-ийн Захирал Б.Булганчимэг, Шим Ус ХХК-ийн Захирал Д.Нямлхагва, Амь Ус Трейд ХХК-ийн Захирал П.Ганзориг, Чандмань Увс ХХК-ийн захирал Д.Төмөр Өлзий.

Олс таталтын тэмцээн 1-р байранд Хангайн бүс, 2-р байранд Баруун бүс, 3-р Зүүн бүс тус тус байр эзэллээ.

Хөл бөмбөг 1-р байранд Зүүн бүсийн баг. Зүүн гар талаас Чандмань Бадрал ХХК-ийн Захирал У.Санрайжав, Багануур Ус ОНӨААТҮГ-н дарга Ш.Жаргалсайхан, Бор Өндөр Хөгжил ОНӨААТҮГ-н дарга Б.Оюунцэцэг, Чандмань Налайх ХХК-ийн Захирал О.Ганболд, Чандмань Илч ОНӨҮГ-н дарга Б.Төмөрхуяг, Чандмань Налайх ХХК С.Чулуунбат.



Хөл бөмбөг 2-р байранд Хангайн бүсийн баг. Зүүн гар талаас Онги Ус суваг ХХК-н Захирал О.Лхагвасүрэн, Хөвсгөл УСНААК –н Захирал Ж.Магсаржав, Гүний Ус ХХК-ийн Захирал Ж.Энхчимэг, Хөвсгөл Ус чандмань ОНӨҮГ-н Ерөнхий инженер Б.Пүрэвбаатар, Дархан Ус суваг ХХК-ийн захирал Р.Эрдэнэбаяр, Булган МЭЭЖ ХХК-ийн Захирал П.Нөхөрлөлбаяр.





Дартсын тэмцээн 1-р байранд Баруун бүс, 2-р байранд Зүүн бүс, 3-р байранд Хангайн бүс тус тус байр эзэллээ.



Багуудын нийлбэр дүнгээр байр үзлүүлж багууд эн тэнцүүхэн өрсөлдөж багийн дүнгээр 3 багийн оноо тэнцэж шагналыг гардууллаа.



Дархан Ус суваг ХХК-ийн Захирал Р.Эрдэнэбаяр МНААҮХолбоонд Notebook бэлэглэж, бүх аймаг орон нутгийн НАА-н байгууллагын дарга нарт дурсгалын зүйл гардууллаа.





Чандмань Илч ХХК, Бор Өндөр Хөгжил ОНӨҮГ-т МНААҮХолбооны гишүүнчлэлийн гэрчилгээ гардууллаа.



НАА, Ахуйн үйлчилгээний ажилтны өдөр, ОСНАА-н Удирдах ажилтны уулзалт зохион байгуулах эрхийн цомыг Эрдэнэт УДТС, Дархан Ус суваг ХХК 2016 онд зохион байгуулахаар цом гардан авлаа.



Сургалт хариуцсан мэргэжилтэн Б.Алтантуул





БАГАНУУР ДҮҮРГИЙН “БАГАНУУР УС” ОНӨААТҮГ-Н “УС ТҮГЭЭХ БАЙРНЫ УС ТҮГЭЭГЧ”-Д СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Багануур дүүргийн “Багануур Ус” ОНӨААТҮГ Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоотой хамтран ажилтнуудаа бэлтгэх, мэргэшүүлэх, мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх үүднээс гэр хорооллын оршин суугчдад ус түгээдэг 19 ус түгээх байрны “Ус түгээх байрны Ус түгээгч” нарт мэргэжил олгох сургалтыг 2015 оны 11-р сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Сургалтаар Ус түгээх байранд ажиллагсдын үндсэн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, ашиглалт, Усны чанар, усны ашиг тус, аюулгүй байдал, УТБ-ны эрүүл ахуй ариун цэврийн шаардлага, хувийн

ариун цэвэр, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай, харилцааны соёлын талаар сургалт явуулж сургалтанд 19 ус түгээгч, идэвхи санаачлагатай оролцож, “Ус түгээгч” гэсэн мэргэжлийн чадамжийн гэрчилгээ гардан авч Монгол орны аль ч аймагт очиж ажиллах эрхтэй боллоо. Энэ сургалтад Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооноос мэргэжлийн сургагч багш нар газар дээр нь сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулж мэдлэг олгож, сургалтанд хамрагдсан Ус түгээгчид маш өндөр сэтгэгдэлтэй байлаа.





МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2016.01.11-15-НЫ ӨДРҮҮДЭД НАА-Н ЕРӨНХИЙ БОЛОН АХЛАХ ИНЖЕНЕРҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ АМЖИЛТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо салбарын удирдлага болон инженер техникийн ажиллагсадын мэргэжил, мэдлэг, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх үүднээс Орон нутгийн нийтийн аж ахуй, ус сувгийн байгууллагуудын ерөнхий инженер болон ахлах инженерүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж 16 аймгийн инженер хамрагдлаа.


Сургалтаар Уур амьсгалын өөрчлөлтийн ундны ус, эрүүл мэнд, хүний хөгжил, дасан зохицох чадамжид үзүүлэх нөлөөлөл, НАА-н салбарт нэвтэрч буй Шинэ техник технологи, Ус хангамж, ариутгах татуурга болон дулаан хангамжийн

шугам сүлжээнд ашиглагдаж байгаа шинэ тоног төхөөрөмжийн танилцуулга, Аймаг, сумдын цэвэрлэх байгууламжийг шинэчлэн сайжруулах зураг төслийн үр дүн, ач холбогдол, Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага, “Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө” боловсруулах хэрэгцээ шаардлага, “Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө” боловсруулах сургалтыг аймаг орон нутагт зохион байгуулж буй явцын талаар сонсож сонирхсон мэдээллүүдээ авлаа.





Мөн Улаанбаатар хотын УСУГ-н Үйлдвэрийн районы Насосны станцтай танилцаж Насосны станцад ашиглагдаж байгаа шинэ техник технологийн танилцуулга хийж, Налайх дүүрэгт шинээр байгуулж ашиглалтад оруулсан цэвэрлэх байгууламж, Багануур дүүргийн усны шинжилгээний лабораторын үйл ажиллагаатай танилцаж, Ультрасоник ХХК-тай хамтарч Ус хангамж, ариутгах татаарга, дулаан хангамжийг бүрэн цогцоор нь шийдвэрлэсэн хорооллын шинэ техник технологитай газар дээр нь танилцах сургалт зохион байгууллаа.





МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2016.01.11-15-НЫ ӨДРҮҮДЭД НАА-Н ЦЭВЭР, БОХИР УСНЫ ЛАБОРАТОРИЙН АЖИЛТНЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

XXI зууны дэлхий нийтийн анхаарал татаж байгаа гол асуудал бол хүн амыг ундны усаар хангах, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэх явдал юм.


Үүнтэй холбогдуулан улс орон бүр хүн амынхаа ундны ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлын 2008.01.31-ний өдрийн 13 дугаар тогтоолоор Мянганы хөгжлийн зорилтын хавсралтыг шинэчлэн баталж, “2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах” зорилт дэвшүүлсэн билээ. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт аймгууд, томоохон суурин газруудын нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудыг цэвэр, бохир усны суурин болон зөөврийн лабораторитой болгох ажлын эхний үе шат хэрэгжиж лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж ашиглалтанд орсон. Зарим аймгийн НАА-н байгууллагууд боловсон хүчин болон ажлын байрны шалтгаанаас лабораторийн тоног төхөөрөмжөө ашиглалтад оруулаагүй байна. Үүнтэй холбоотой цэвэр, бохир усны суурин болон зөөврийн лабораторийн тоног төхөөрөмжийг хэвийн найдвартай ажиллуулах, ажилчдыг дадлагажуулж мэргэшүүлэх үүднээс лабораторийн ажилчдыг чадавхжуулах сургалтыг Улаанбаатар хотын УСУГ-н Усны төв лабораторитой хамтран зохион байгуулж орон нутгийн НАА-н 9 ажилтан хамрагдаж сургалт амжилттай өндөрлөлөө. Мөн Налайх дүүргийн шинээр ашиглалтад орсон Цэвэрлэх байгууламж, Сургууль цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж, Багануур дүүргийн Усны Лабораторийн үйл ажиллагаатай танилцах сургалт хийлээ.



Сургалт хариуцсан мэргэжилтэн Б.Алтантуул



ТӨВИЙН БҮСИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАЛТ, ТҮГЭЭЛТИЙН 2015 ОНЫ АЛДАГДЛЫН ДҮН МЭДЭЭ




2015 оны дүнгээр Төвийн бүсийн цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдал өмнөх оны мөн үеэс 0.2 нэгжээр буурч 15.0% болсон байна.

Төвийн бүсийн 16 компанийн дүнгээр 2014 онтой харьцуулахад 42.7 сая кВтц буюу 1.1%-иар илүү цахилгааныг хэрэглэгчдэд түгээсэн байна. Үүнээс “Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн худалдан авсан цахилгааны хэмжээ өмнөх оны мөн үеэс 44.8 сая кВтц-аар буюу 2.2%-ийн өсөлттэй гарлаа.

Цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлыг өнгөрсөн оноос “Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК 0.7, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК 0.3, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК 6.5, “Хөвсгөл-Эрчим хүч” ХХК 0.6, “Баянхонгор Эрчим хүч” ЦТК 1.6, “Эрдэнэт ус ДТС” 1.7, “Эрчим сүлжээ” ХХК 0.7 нэгжээр тус тус бууруулжээ.

2015 ОНЫ БҮС НУТГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМҮҮДИЙН ЦАХИЛГААН ДАМЖУУЛАЛТ, ТҮГЭЭЛТИЙН АЛДАГДЛЫН ТАЛААР



2015 оны эхний 12 сарын дүнгээр:

“Баруун бүсийн эрчим хүчний систем”

ТӨХК-ний цахилгаан дамжуулалтын алдагдлын хэмжээ 9.9 хувь болж өмнөх оны мөн үеэс 1.0 нэгжээр буурчээ.

Цахилгаан түгээлтийн алдагдлыг өмнөх оны мөн үеэс “Баян-Өлгийн Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨҮГ (15.4%) 2.1 нэгжээр өсгөсөн бол “Увс цахилгаан түгээх сүлжээ” ХХК (17.4%) 1.4 нэгжээр, “Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК (19.3%) 1.5 нэгжээр тус тус бууруулсан байна.

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”

ТӨХК-ний цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлын хувь 6.9 болж өмнөх оны мөн үеэс 0.4 нэгжээр буурсан байна.

“Алтай-Улиастайн эрчим хүчний систем”

ТӨХК-ний цахилгаан дамжуулалт, түгээлтийн нийт алдагдлын хувь 22.8 болж өмнөх оны мөн үеэс 2.1 нэгжээр бууруулсан байна.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ГЭР ХОРООЛЛЫН ИРГЭДИЙН ЦАХИЛГААНЫ ШӨНИЙН ТАРИФЫГ 50 ХУВИАР ХӨНГӨЛӨХ ШИЙДВЭР ГАРГАЛАА



Эрчим хүчний зохицуулах хорооны ээлжит хориндолдугаар хурал 2015 оны арваннэгдүгээр сарын 30-ны өдөр болж, гэр хорооллын иргэдийн цахилгааны шөнийн тарифыг 50 хувиар хөнгөлөх шийдвэр гаргалаа. Энэхүү хөнгөлөлтөд Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 280 гаруй мянган айл өрхүүд хамрагдах бөгөөд цахилгаан халаалт залгах шаардлагатай хүйтний улиралд буюу 2015 оны 12, ирэх оны 1, 2, 3 сар хүртэл оройн 21 цагаас өглөөний 06 цаг хүртэл хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50 хувиар хөнгөлүүлэх боломжтой болж байгаа юм. Өмнө нь гэр хорооллын иргэд

шөнийн нэг кВт цаг эрчим хүчийг 77.10 төгрөгөөр тооцож худалдан авдаг байсан бол энэ үнийг 50 хувь хөнгөлснөөр 38.55 төгрөг болон үнэ нь буурч, иргэдийн халаасанд 5.2 тэрбум төгрөг үлдэнэ гэсэн урьдчилсан тооцоог Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргажээ.

Эрчим хүчний салбар 2015 оныг “Хэмнэлтийн жил” болгон зарлаж, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооноос салбарын үр ашгийг дээшлүүлж, өртөг зардлыг бууруулах хамтарсан ажлын хэсэг гарган, эрчим хүч үйлдвэрлэгч, түгээгч, дамжуулагч компаниудын үйл ажиллагаанд шалгалт хийж, хяналт тавьж ажилласан бөгөөд үнэ тарифын зохистой зохицуулалт, менежментийн зөв арга барилыг хэрэгжүүлж чадсаны үр дүнд олон жилийн турш хуримтлагдсан алдагдлыг бууруулж чаджээ. Тухайлбал эрчим хүч үйлдвэрлэгч дулааны цахилгаан станцууд дотоод хэрэгцээгээ 0.6 нэгжээр, төвийн бүсийн эрчим хүчний дамжуулалтын алдагдлыг 0.1 нэгжээр, цахилгаан түгээлтийн алдагдлыг 0.5 нэгжээр тус тус бууруулсан байна. Салбарын хуримтлагдсан алдагдал тодорхой хэмжээгээр буурч байгаа учраас Улаанбаатар хот, 15 аймгийн гэр хорооллын иргэдийн цахилгааны шөнийн тарифыг 50 хувиар хөнгөлөх боломжтой болж байгаа юм.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨНГӨЛӨЛТӨД ХАМРАГДАХ АЙМГУУДЫН ЖАГСААЛТ



Эрчим хүчний зохицуулах хорооноос гэр хорооллын иргэдийн цахилгааны шөнийн тарифыг 50 хувиар хөнгөлөх шийдвэр гаргасан. Энэхүү хөнгөлөлтөд Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 280 гаруй мянган айл өрхүүд хамрагдах бөгөөд цахилгаан халаалт залгах шаардлагатай хүйтний улиралд буюу 2015 оны 12, ирэх оны 1, 2, 3 сар хүртэл оройн 21 цагаас өглөөний 06 цаг хүртэл хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50 хувиар хөнгөлүүлэх боломжтой болж байгаа юм. Төвийн бүсийн эрчим хүчний системд нийслэл Улаанбаатар хотоос гадна Хөвсгөл, Сэлэнгэ, Архангай, Булган, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Төв, Говьсүмбэр, Дорноговь, Дархан-Уул, Орхон-Уул, Хэнтий гэсэн арван гурван аймаг харьяалагддаг. Тиймээс нийслэлээс гадна дээрхи 13 аймгийн гэр хорооллын иргэд шөнө хэрэглэсэн цахилгааныхаа үнийг 50 хувь хүртэл бууруулах боломжтой юм.

Эрчим хүчний зохицуулах хороо



“УСНЫ ЦЭНХЭР САВНЫ АЮУЛ”



Дэлхийн хүн төрөлхтөний 21-р зууны айдас болоод байгаа хорт хавдар өвчин хөгжиж буй орнууд түүний дотор Монгол улсад дэлхийн бусад орнуудтай харьцуулахад маш өндөр байгаа нь хэн бүхний сэтгэл зүрхийг эмзэглүүлж түгшээсэн асуудал болон хувираад байна.

Манай улсад зөвхөн 2013 онд 5255 хорт хавдрын шинэ тохиолдол оношлогдсон тухай "Хорт хавдар Монгол улсад-2013" тайланд дурджээ. Мөн ХСҮТөвөөс гаргасан "Хорт хавдар Монгол улсад 2008-2012" тайланд 1991 оноос хойшхи сүүлийн 20 жилийн хугацаанд жил бүр хорт хавдар өвчлөлийн стандартчилсан түвшин /ӨСТ/ нийт өвчлөлийн хувьд 2,25 хувиар нэмэгдсэнийг тэмдэглэсэн байна. Дээр дурдсан 20 жилд манай улсад уул уурхайн үйлдвэрлэл /албан болон албан бус/ ихээхэн нэмэгдэж химийн бодисын хэрэглээ эрс өссөнтэй цаг хугацааны хувьд давхцаж байгаа нь тохиолдлын хэрэг огтхон ч биш харин ч энэ нь шууд нөлөөлж байгааг нотолж байна. Тухайлбал энэ хугацаанд хорт хавдрын өвчлөл 45%-иар нэмэгдэж өнөөдөр манай улсад өдөрт дунджаар 14-15 хүн шинээр хорт хавдар өвчнөөр оношлогдож байна.

Мөн 10000 хүн амд ногдох элэгний хатуурал 2003-2013 оны хооронд 10 жилийн хугацаанд 2,3 дахин /2003 онд 26.15; 2013 онд 60.40/ дахин нэмэгдэн тухай эрүүл мэндийн статистик мэдээнд дурдсан байдаг. Түүнчлэн Globocan -2012 олон улсын судалгаанд 100000 хүн амд ногдох элэгний хорт хавдрын өвчлөлөөр Монгол Улс дэлхийн дунджаас 7.71 дахин өндөр /MGL79-41-WORLD 10.30/ байсан бөгөөд энэ үзүүлэлтээр дэлхийн бусад орнуудаас хол тэргүүлж байна.

ЭМЯ, НЭМХ, АУХүрээлэнгийн 2013 оны хамтарсан судалгаагаар бага насны хүүхдийн цусан дахь хар тугалга (Pb)-ны хэмжээ 2-5 дахин өндөр байгааг тогтоосон байдаг.

Иймд эдгээр тоо баримтыг цаг хугацаатай нь жишиж үзэхэд химийн хорт бодисын болон түүнийг зөөвөрлөж ирсэн хуванцар савны нийгэм

дэх хавтгайрсан олон жилийн хэрэглээнээс шууд хамааралтай болох нь маш тодорхой харагдаж байна. Одоо бидэнд илүү өөр ямар нотолгоо шаардлагатай юм бэ?!

Энэ "цэнхэр" буюу химийн хорт бодисын хуванцар сав хүний эрүүл мэндэд чухам ямар аюултай болохыг бага боловч тодруулахыг хичээе.

Манай улс зөвхөн сүүлийн 6 жил (2008-2013 он) -ийн хугацаанд давхардсан тоогоор 7500 гаруй нэрийн 2,4 сая тонн химийн бодисыг импортоор оруулж ирсэн байдаг. Сүүлийн 20 жилд энэ тоо хэмжээ асар их гарах нь тодорхой.

Химийн бодисын хуванцар савыг зөвхөн аюултай, маш хортой зэрэглэлийн химийн олон нэр төрлийн бодис, ариутгал, халдваргүйтгэл, газар тариалангийн болон ахуйн хортон шавьж устгалын, техникийн зориулалттай төрөл бүрийн шингэн бодис зэргийг удаан хугацаагаар хадгалах, холын зайд зөөвөрлөхөд зориулж үйлдвэрлэсэн байдаг бөгөөд түүний халуун хүйтэн нөхцөл, цохилт доргилтыг тэсвэрлэх чадварыг дээшлүүлэх, уян хатан чанарыг нэмэгдүүлэх зорилгоор эдгээр савны бүтээц, түүхий эдийн орц найрлагад хүнд метал болон бусад химийн элементийг оруулж өвөрмөц технологиор үйлдвэрлэсэн байдгаас гадна эдгээр саванд хадгалсан химийн хорт бодисын шижилт явагдаж тухайн савандаа нэвт шингэсэн байдаг зэрэг онцлогтой.

Ийм учир ашигласан химийн хорт бодисын хуванцар савыг олон улсад "West extremely hazardous" гэж нэрлэн аюултай хог хаягдалд ангилан үзэж түүнийг тусгай технологийн аргаар шууд устгадаг нийтлэг жишигтэй байдаг. Аюултай хог хаягдал мөн тул дахин ашиглах боломжгүй гэж үзэж эдгээр сав суулгыг ахуйн болон хүнсний бүтээгдэхүүн хадгалах, зөөвөрлөх зориулалтаар хэрэглэхийг бүр ч хатуу хориглодог байна.

Гэтэл манай улсад байдал бүр эсрэгээрээ.

Бидний Монголчуудын эртнээс нааш эрхэмлэн дээдэлж хэрэглэж ирсэн ариун тансаг, эмийн увидаст чанартай сүү цагаан идээгээ хүртэл өнөөгийн бид нар өчүүхэн ч сэтгэлийн эмзэглэлгүйгээр эдгээр сав суулганд хадгалж, зөөвөрлөж, хэрэглэсээр өдгөө 20 гаруй жилийн нүүрийг үзэж байна. Бид чинь сүү цагаан идээндээ бохир оруулахыг хатуу цээрлэдэг заншилтай ард түмний үр сад биш билүү. Бүр сүүлдээ саалийн хувин, сүүний шанага, ундны усны савнаас өгсүүлээд хүнсний бүхий л төрлийн бүтээгдэхүүнээ эдгээр зориулалтын бус хуванцар болон нийлэг сав баглаа боодолд хадгалж, зөөж тээвэрлэж байна. Өнөөгийн энэ бодит байдал нь иргэн хүнд ч, төр засагт нь ч "хэрэглэж болдог юм" гэсэн хэрэглээний гаж сэтгэлгээ аль хэдийн тогтож бид нар бүхнээс илүү үнэ цэнэтэй өөрийн эрүүл мэндээ химийн хорт бодисоор өөрсдөө хордуулж, хорлон сүйтгэж



байгаа нь тун эмгэнэлтэй бөгөөд харамсалтай бас хачирхалтай хэрэг. Ийм улс орон энэ дэлхий ертөнц дээр өнөөдөр манайхаас өөр байхгүй!

Өнөөдөр манай улсын хөдөө аж ахуй /ХАА/- гаас бэлтгэж байгаа сүү, сүүн бүтээгдэхүүний 60 хувиас доошгүйг нь буюу 300 сая литрээс багагүй / бидний тооцоогоор / сүү цагаан идээг дээрхи хуванцар саваар зөөвөрлөн зах зээлд нийлүүлж байна. Эдгээр савны албан ёсны статистик мэдээ манай улсад байдаггүй ч баримжаагаар 5-6 сая ширхэг хуванцар сав байнгын хэрэглээнд байна гэж үздэг.

НЭМХүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын 2008 онд хийсэн судалгаа шинжилгээгээр /мөн МХЕГ-ын 2014 онд хийсэн судалгаагаар хортой нь дахин тогтоогдсон байдаг/ ус хадгалсан химийн бодисын том цэнхэр өнгийн болон 25 литрийн шар канистр хуванцар савнаас усанд шилжсэн хүний биед хуримтлагдсаар аажимдаа хорт хавдар үүсгэдэг хүнд металл болох хар тугалга /Рь/-ны шилжилт үндэсний стандартад заасан хэмжээ /0,01мг/л/ -нээс 60-800 дахин, хүний мэдрэлийн системд нөлөөлдөг формальдегид хэмээх хортой бодис ст.хэмжээ /0,1мг/л/ -нээс 1800-6900 дахин их байсныг тус тус тогтоож эдгээр савыг хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалтаар хэрэглэх "БОЛОМЖГҮЙ" гэсэн дүгнэлтийг тус хүрээлэнгээс тухайн үед нь гаргасан байдаг ч түүнээс хойш өдгөө 8 дахь жилийн нүүрийг үзэж байна.

Энэ хугацаанд манай улсын Төр, Засгийн газар холбогдох яамдууд тухайлбал ХХААЯ, ЭМЯ, БОНХЯ ард иргэдийн амь насанд заналхийлсэн энэ аюултай хэрэглээг таслан зогсоох талаар ямар нэгэн бодитой ажил хийж, шийдвэртэй арга хэмжээ авалгүй байсаар өнөөг хүрч байна. Харин дээрхи дүгнэлтийн дагуу сэрэмжлүүлэг, зөвлөмжийг МХЕГ-аас олон удаа гаргасан байдаг ч түүнийг анхаарч хэрэгжүүлж байгаа байгууллага, иргэн өнөөдөр манай улсад нэгээхэн ч алга. Химийн хорт бодисын болон хүнсний зориулалтын бус хуванцар, нийлэг сав баглаа боодлын өнөөгийн энэ ямарч хяналт зохицуулалтгүй нийгэм дэхь хэт хавтгайрсан хэрэглээ нь Монгол улсын Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.1 буюу "Хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн хүнсний зориулалтын сав баглаа боодолд савласан байна" гэсэн заалтыг ноцтойгоор зөрчиж эдгээр хуванцар савнаас шилжсэн химийн хорт бодисын өндөр агууламж бүхий /НЭМХ-ийг 2008 оны судалгааны дүгнэлт/ хүнсний бүтээгдэхүүнийг сүүлийн 20 гаруй жилийн турш хэрэглэж байгаагийн хор уршигаар манай ард иргэд, нийт хэрэглэгчдийн эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж улмаар хүн амын дунд хорт хавдар өвчин үүсэх, цус багадалт бий болох, эхийн урагт нөлөөлж ургийн гаж хөгжлийг үүсгэх, түүгээр ч зогсохгүй хүний төв мэдрэлийн системд нөлөөлөх зэрэг аюултай хүнд хэлбэрийн олон өвчнийг үүсгэх нэг үндсэн хүчин зүйл, шалтгаан нөхцлийг бүрдүүлж дээр дурдсан хорт хавдрын өвчлөлийн тоон үзүүлэлтэд ихээхэн нөлөө үзүүлж байгаа юм.

Энэ бүгдээс харахад дээр дурдсан хуулийн заалтыг удаан хугацаанд маш ноцтой зөрчиж завхруулснаар нийгэмд үүсч бий болсон зөвхөн хорт хавдрын өвчлөлийн бодит байдал нь Монгол улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний үндсэн эрх, Үндсэн хуулийн 2.16.1,2,6 заалтууд ("Хүн амьд явах эрхтэй, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй, эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй")-ыг ноцтой зөрчиж ард иргэд амь нас, эрүүл мэндээрээ асар их хохирч байна.

Манай төрийн бус байгууллагаас 2014 оны 8-р сараас эхлэн дээр дурдсан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн хэрэгжихгүй байгаа 12.1 заалтыг бодитоор хэрэгжүүлэх зорилт тавьж маш тодорхой санал дэвшүүлж МУ-ын Ерөнхийлөгч бөгөөд Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн дарга болон холбогдох бүх яамдын сайд дарга нарт албан бичгээр хандаж зарим сайд дарга нартай биечлэн уулзаж олон сар ажиллах явцдаа төрийн түшээдийн ёс зүйгүй зан байдлыг харж тэд нарын тухайн асуудалд үл тоосон байдлаар хандаж, хүнд суртал хүйтэн сэтгэл гаргаж байсан зэргийг үл тэвчин ХЭҮКомисг 2015.02.12 гомдол мэдүүлсэн билээ. Гэсэн ч түүнээс хойш өнөөдрийг хүртэл тодорхой шийдвэрт хүрч ахиц дэвшил гараагүй л байна.

Эдгээр амин чухал хуулиудын зүйл заалтуудыг удаан хугацаанд ноцтой зөрчиж байгаагийн улмаас ард иргэд маань олон мянгаараа хордож аюулт өвчинд нэрвэгдэж улмаар 2010 онд Улсын Их Хурлаар батлагдсан Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.2.2, 3.4.1.6, 3.4.2.5, 3.4.2.6, 3.4.7.2, 3.4.2.8, 3.5.4.3, 3.5.4.5 заалтуудыг илт зөрчиж улс орны үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж байгааг манай эрх баригчид маань харсан ч хараагүй мэт, мэдсэн ч мэдээгүй юм шиг явцгааж тэдгээрийг засч залруулах талаар бусдын дэвшүүлсэн санал бодол, хэлж ярьж буй зүйлийг хүлээн авахгүй үл тоосон байдлаар хайхрамжгүй хандаж байгаа явдал нь манай төрийн түшээдийн билгийн мэлмий булингартаж, хүнлэг сэтгэл нь дээрхи хортой савны дотор адил ихэд бохирдсон нь харагдаж байна. Ер нь тэд нарт ард түмэн хордож, хавдаж байх нь огтоос хамаагүй бололтой. "Бохирдсон сэтгэл бохир орчныг бүрдүүлж байдаг" гэсэн мэргэдийн сургаал үг ямар үнэн бэ?

Бас "Дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олдоггүй" гэсэн ардын мэргэн үг арга үгүй бодогдож явлаа.





Дээрхи даамжирсан аюултай хэрэглээг зохицуулах хууль эрх зүйн орчин манай улсад байхгүй юу гэвэл бас тийм биш юм аа. Гэхдээ эдгээр нь даан ч хэрэгждэггүй олон шалтаг шалтгаантай.

Сүү болон бусад хүнсний бүтээгдэхүүнийг хуванцар болон нийлэг сав баглаа боодолд савлах, хадгалах, тээвэрлэх тухай өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үндэсний стандартуудад эдгээр хуванцар савны онцлог байдал, түүний заалтууд нь нарийвчлан тусгагдаагүй байдаг. МУ-н Засгийн газрын 2009 оны 32-р тогтоолоор баталсан "Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөрийн 18,7 заалт (Хүнсний бүтээгдэхүүний хуванцар болон нийлэг сав баглаа боодлын стандарт техникийн нөхцлийг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн шинэчлэх) нь хэрэгжихгүй байсаар өдгөө 7 жилийн нүүрийг үзэж байна.

Мөн түүнчлэн ихээхэн цаг алдаж хожуу хойно Улсын Их хурлаар батлан гаргасан "Хог хаягдлын тухай хууль"-ийн 13-р зүйлд заасан аюултай хог хаягдлын устгалтын менежментийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байсаар өнөөг хүрч байна. 2012 онд баталсан энэ хуулийн 13.3, 13.4 заалтуудад тусгагдсан тухайн хуулийг дагаж мөрдөх журмыг МУ-ын Засгийн Газраас 3 жилийн дараа саяхан 2015.06.29 өдрийн 264-р тогтоолоор баталж гаргасан ч аюултай хог хаягдлыг устгах олон улсын жишигт нийцсэн байгууламжийг барьж байгуулах болон түүнд шаардагдах газрын асуудал зэргийг шийдвэрлээгүй байсаар байна.

Бид бүхний сэтгэлгээнд өөрийн орон зайгаа аль хэдийн эзлэн тогтсон хуванцар болон нийлэг сав баглаа боодлын эрээ цээргүй энэ хэрэглээг цаашид яавал зохистой вэ? Мэдсээр байж мэдэн будилж 8 жил,

мэдээ мэдээлэлгүй 10 гаруй жил хэрэглэснээс үүдэн эдгээр сав суулга бид бүхэнд / бидний монголчуудад/ ямар их хор хөнөөл, гай зовлон дагуулсан бол?!

Одоо өнгөрснийг биш маргаашийг харж ярья. Арь болох түргэн хугацаанд цаг алдалгүй шаргуу ажиллаж байж бага хохиролтойгоор энэ аюулын харанга дэлдэж, бараан сүүдэр дагуулсан "цэнхэр" савнаас салах шаардлагатай байна.

Манай төрийн бус байгууллага нь эдгээр хортой савны хэрэглээг эрс хориглож нэн даруй хязгаарлан зогсоох нь өнөөгийн манай нийгэмд шийдвэрлэвэл зохих хамгийн тулгамдсан асуудлын нэг мөн гэж үзэж бид "Сүүн бүтээгдэхүүн ундны усны савны хангамжийг сайжруулах" үндэсний хөтөлбөрийг аль болох богино хугацаанд/2015- 2018 он/ хэрэгжүүлэхийг санал болгон дэвшүүлж тус хөтөлбөрийн төслийг албан бичгийн хамт 2014 онд МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, МУ-ын Ерөнхий сайд, МУ-ын ҮАБЗөвлөлийн Нарийн Бичгийн дарга нарт болон холбогдох бусад яам газруудад удаа дараа хүргүүлж, мөн олон хүнд сорилттой тулгарч байгаа ч бид өмнөө тавьсан томоохон энэ зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Мөн, одоо ЭМСЯ дээр хүнсний бүтээгдэхүүний хуванцар, нийлэг сав баглаа боодлын үндэсний стандартуудыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг, ХХААЯ дээр "Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын аюулгүй байдлыг хангах" дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэг тус тус шинээр байгуулагдан ажиллаж байгаа ч ажлын явц ихээхэн удаашралтай байна.

Өнөөдөр МУ-ын Их Хурлаар "Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, үзэл баримтлал"-ыг батлахаар хэлэлцэж буй энэ цаг үед манай төрийн бус байгууллагаас 2015.07.08 өдөр УИХ-ын гишүүн БОХХАА-н Байнгын хорооны дарга, төрөөс ХХАА-н талаар баримтлах бодлого боловсруулах ажлын хэсгийн ахлагч Су.Батболдод болон МУ-ын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг нарт хандаж дээр дурдсан "Сүүн бүтээгдэхүүн ундны усны савны хангамжийг сайжруулах" үндэсний хөтөлбөрийн гол утга санааг төрийн бодлогын баримт бичигт тусгуулж нэн даруй хэрэгжүүлэхийг хүссэн албан бичгүүдийг хүргүүлсэн болно. Энэ хөтөлбөр нь өөрөө нийгмийг бүрхэлд нь хамарсан шинж чанартай, нэг яам дангаараа бие даан шийдвэрлэх боломжгүй хэд хэдэн салбарын яамд хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоон дээр иж бүрэн хэрэгжих онцлогтой учир МУ-ын Засгийн газраас үндэсний хэмжээний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх нь богино хугацаанд хэрэгжих үндэслэлтэй зөв шийдвэр байх болно гэж бид үзэж байна. Хэрэв өнөөдөр л төрөөс шийдвэртэй арга хэмжээ авч нийгмийг хамарсан энэ аюултай хэрэглээг нэн даруй таслан зогсоохгүй аваас бидэнд болон ирээдүй хойчид маань ирэх нэхэл хатуу төлөөс улам их байх болно. Энэ тухай төр засагт дахин сануулж түмэн олондоо хандаж анхааруулж хэлэхийг хүсч байна.

"Заша өвс төв" тэргүүн: Р.Нямдорж




ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

Тэгш,
Чанартай,
Найдвартай,
Хүртээмжтэй үйлчилгээг бүгдэд

УСНЫ БАЛАНС ТООЦОХ

Усны баланс



Орлого болоогүй ус – УСНЫ АЛДАГДАЛ

Усны бодит алдагдал буюу шугам сүлжээ, тоног төхөөрөмж зэрэг ус олборлон, дамжуулах түгээх зэрэг эцсийн хэрэглээ хүртэлх явцад гарч буй биет алдагдал

Борлуулалтын буюу **ЗҮЙ БУС АЛДАГДАЛ** (тоолуурын заалт буруу авсан, тоолуур алдаатай, задгай хэрэглэгчийн шугам сүлжээ сантехникийн эд анги усны алдагдал ихтэй)

Усны даралт болон төлбөр тооцоогүй хэрэглээнээс үүсэх алдагдал (галын ус болон хууль тогтоомж, дүрэм журмаар зохицуулагддаг төлбөр тооцоогүй усны хэрэглээнүүд)

Орлого болоогүй ус хангагч байгууллагын үр ашигт нөлөөлөх нь

ОБУ нэмэгдсэнээс:

- Борлуулагдаагүй бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэнэ,
- Усны өртөг, зардал өснө.
- Өсөн нэмэгдэх усны хэрэглээг хангахын тулд хөрөнгө оруулалт илүү шаардагдана.
- Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж, усны хомсдол үүсгэнэ.
- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг үнэн зөв үнэлэх боломж буурна.

Орлого болоогүй усны хэрэглэгчид нөлөөлөх нь

- Усны үнийг тасралтгүй нэмэх шаардлага гарч хэрэглэгчдийн ачааллыг нэмэгдүүлнэ.
- Усны хомсдол нүүрлэсэн үед хэрэглэгчийн хэрэглээг хязгаарлахаас өөр аргагүйд хүрдэг

Усны балансыг зөв хийх !!!

	Гүйцэтгэх ажил	Гүйцэтгэгч	Хяналт тавих
1	Олборлосон болон дамжуулан авсан ус хэмжих хэрэгслэлээр болон АКТ-р баталгаажсан байх.	ашиглалтын инженер	Ерөнхий инженер
2	Хэрэглэгчийн тоолуур хэмжих хэрэгслэл баталгаатай байх	ашиглалтын инженер	Ерөнхий инженер
3	Ус ашиглалтын гэрээг тодорхой зөв хийх. Задгай хэрэглээний нормыг зааж өгөх.	ашиглалтын инженер	Ерөнхий инженер
4	Хэрэглэгчийн бичилтийг үнэн зөв, тодорхой хугацаанд хийх	Тоолуурын байцаагч	ашиглалтын инженер
5	Технологийн хэрэглээний усыг зөв тодорхойлох – алба бүрээр	ашиглалтын инженер	Ерөнхий инженер
6	Усны баланс хийж, алдагдал тооцох	ашиглалтын инженер	Ерөнхий инженер

Усны баланс /олон улсын түвшинд/

Олборлон системд нийлүүлсэн ус	Зөвшөөрөгдсөн ус хэрэглээ	Төлбөр нэхэмжилсэн хэрэглээ	Тоолууртай хэрэглэгч	Усны орлого
		Төлбөр тооцоогүй хэрэглээ	Тоолуургүй хэрэглэгч	
Усны алдагдал	Борлуулалтын алдагдал		Тоолууртай хэрэглэгч	Орлого болоогүй ус
			Тоолуургүй хэрэглэгч	
	Бодит алдагдал		Зөвшөөрөгдөөгүй хэрэглээ /хулгай/ Тоолуурын алдаа, бүртгэлийн алдаа гарсан	
Думжуулах, түгээхэд гарсан усны алдагдал				
Усан сангийн алдагдал				
			Холболтын цэгээс хэрэглэгчийн тоолуур хүртэлх алдагдал	



ЗАРДЛЫН БҮРТГЭЛ, ӨРТГИЙН ХУВААРИЛАЛТ

Зардлын бүртгэл

1. Үйл ажиллагааны ангилал тус бүрээр төлөвлөлт хийх, зардал-орлого зөв тооцох, хуваарилах
2. Анхан шатны бүртгэл - Шаардах хуудас
3. Санхүүгийн тайлан тооцоонд зөв хуваарилах
4. Үйл ажиллагааны тайланг Тусгай зөвшөөрлийн ангилал тус бүрээр гаргах – нэгдсэн баланс гарах

Төлөвлөлт зөв байх:

БАТЛАВ: "....." ХХК-НИЙ ЗАХИРАЛ

"....." ХХК-НИЙ 20... ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

ЗАРДАЛ, ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (мян.төг-р)

№	Зардлын төрөл	НИЙТ ЗАРДАЛ	ДУЛААН	ТӨВЛӨРСӨН УС ХАНГАМЖ	АРИУТГАХ ТАТУУРГА	ӨӨРИЙН ЭХ ҮҮСВЭРТЭЙ УС ХАНГАМЖ	БУСАД
1	Орон тоо - ажиллагсад	0					
2	Үндсэн ба нэмэгдэл цалин						
3	Ажлын олгогчийн төлөх НДШ						
4	Цахилгаан - өөрийн хэрэглээ						
5	Дулаан - өөрийн хэрэглээ						
6	Ус - өөрийн хэрэглээ						
7	Засвар-сэлбэгийн зардал						
8	Түлш-шатхуун						
9	Албан томиллолт						
10	Бичиг хэрэг						
11	Харилцаа холбоо						
12	Хөдөлмөр хангаал эрүүл ахуй						
13	Гүйцэтгэх удирдлагын зардал						
14	Үндсэн хөрөнгийн элэгдэл						
15	Маркетинг-зар сурталчилгаа						
16	Нийгэм халамжийн зардалд						
17	ТЭЖ Зохицуулалтын хөлс						
18	Татвар даатгалын зардал						
19	Гадны үйлчилгээний хөлс						
20	Бусад үйл ажиллагаа						
21	Дамжих эрчим хүч - дулаан, ус						
	Үйл ажиллагааны зардлын дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ОРЛОГО							
1	Үйл ажиллагааны үндсэн орлого	0.0					
2	Суурь хураамжийн орлого	0.0					
3	Бусад орлого	0.0					
	Орлогын нийт дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
	АШИГ*, АЛДАГДАЛ -	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Хавсран: Ерөнхий нягтлан
Ерөнхий инженер
Тооцоо хийсэн: Инженер - Эдийн засагч
Нягтлан

Үйл ажиллаганы ангилал тус бүрээр төлөвлөлтийг хийх

1. Зардалын ангилал:

Үндсэн ба нэмэгдэл цалинд: Захирлын тушаал, өмнөх оны

1. Албан тушаалын үндсэн цалин
2. Сарын үр дүнгийн шагналт цалин
3. Удаан жилийн нэмэгдэл
4. Зэргийн нэмэгдэл
5. Шөнийн цагийн нэмэгдэл
6. Илүү цагийн нэмэгдэл
7. Албан тушаал хавсран ажилласан нэмэгдэл

2. Өөрийн хэрэглээний эрчим хүчний зардалд:

Хангагчтай хийсэн гэрээ, хавсралт, өмнөх оны гүйцэтгэл

1. Цахилгаан - Алба хэсэг бүрийн өөрийн хэрэглээний цахилгаан
2. Дулаан - Алба хэсэг бүрийн өөрийн хэрэглээний дулаан
3. Ус- Алба хэсэг бүрийн өөрийн хэрэглээний цэвэр, бохир ус

3. Засвар сэлбэгийн зардалд:

Засварын төлөвлөгөө, батлагдсан төсөв.

Өмнөх жилийн гүйцэтгэл

1. Дунд засвар
2. Үрсгал засвар
3. Туслах материал

4. ХАБЭА-н зардалд:

Өмнөх оны гүйцэтгэл, хамтын гэрээ, ажлын гэрээ

1. Ажлын хувцас - Зун, өвөл
2. Хамгаалах хэрэгсэл
3. Ажлын үндсэн багаж хэрэгсэл
4. Хор саармагжуулах зардал - сүү г.м
5. Эрүүл мэндийн үзлэг
6. Аптек + эм, ороох боох материал
7. Сургалт + сурталчилгаа /самбар, анхааруулах плакат/

5. Гүйцэтгэх удирдлагын зардалд:

Өмнөх оны гүйцэтгэл, тушаал

1. Захирал
2. Ерөнхий инженер
3. Ерөнхий нягтлан
4. ТУЗ-н зардал

6. Маркетинг зар сурталчилгааны зардалд:

Өмнөх оны гүйцэтгэл, батлагдсан төсөв

1. Зар, мэдээлэл
2. Реклам, щторк
3. ИШСүлжээний зураг схем хэвлүүлэх
4. Алдагдал бууруулах. Борлуулалт өсгөх талаар явуулсан шалгалт, урамшууллын зардал

7. Нийгэм халамжийн зардалд:

Хамтын гэрээ, тушаал, өмнөх оны гүйцэтгэл

1. Хоолны хөнгөлөлт
2. Унааны хөнгөлөлт
3. Түлээ нүүрсний хөнгөлөлт
4. Буцалтгүй тусламж тэтгэмж
5. Амралт эмнэлэг сувилалын хөнгөлөлт
6. Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл

8. Тусгай зөвшөөрөл, зохицуулалтын хөлс:

Холбогдох албан тоот

1. Алба хэсэг тус бүрийн тусгай зөвшөөрөл болон зохицуулалтын үйлчилгээний хөлсний

9. Татвар, даатгалын зардалд:

Гэрээ хавсралт, өмнөх оны гүйцэтгэл

1. Газрын татвар
2. Үл хөдлөх хөрөнгийн татвар
3. Тээврийн хэрэгслэлийн татвар
4. Тээврийн хэрэгслэлийн даатгал



10. Гадны байгууллагын үйлчилгээний хөлс:

Гэрээ-хавсралт, гүйцэтгэл

1. Банкны үйлчилгээ
2. Аудитын хөлс
3. Программ хангамжийн төлбөр /Санхүү, борлуулалт/
4. Хөрөнгийн бүржийн хураамж
5. Үнэт цаасны хорооны хураамж
6. Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зардал
7. Түрээсийн зардал

11. Бусад үйл ажиллагааны зардалд:

Гүйцэтгэл, тушаал, төсөв

1. Сургалт
2. Шагнал урамшуулал
3. Урлаг, спортын арга хэмжээ
4. Баяр ёслолын арга хэмжээ

12. Дамжих эрчим хүчний зардалд:

Хангагчийн гэрээ, хавсралт

1. Алба тус бүрийн дамжуулан түгээсэн эрчим хүчний худалдан авсан өртөг үнээр

Орлогын ангилал:

1. Үндсэн үйл ажиллагааны орлогод:
 1. Цэвэр усны борлуулалтын орлого
 2. Бохир ус татан зайлуулсан орлого
 3. Дулааны борлуулалтын орлого
 4. Халуун усны борлуулалтын орлого
 5. Суурь хураамжийн орлого
2. Үндсэн үйл ажиллагааны бусад орлогод:
 1. Төлбөрт үйлчилгээний орлого
 2. Техникийн үйлчилгээний орлого
 3. Нөхөн төлбөрийн орлого

Зардал, өртгийн хуваарилалт:

Шууд зардал

• Тухайн хэсэгт шууд хамаарах зардлууд (ажиллагсад болон тоног төхөөрөмжийн шууд зардлууд)

Хуваарилах зардал

• Байгууллагын нийтлэг зардлууд (удирдлагын, захиргааны цахилгаан, дулаан, бусад)

Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл













УНДНЫ УС, ХАЛААЛТЫН ЗОРИУЛАЛТАЙ ХООЛОЙН СИСТЕМ

aquatherm green pipe

Дэлхий даяар 30 гаруй жил ашиглагдаж буй ундны ус, халаалтын зориулалттай хоолойн систем нь эрүүл ахуйн шаардлага хангасан метал, химийн хорт бодис агуулаагүй хамгийн аюулгүй хуванцар шугам гэдгээрээ тэргүүлж, дэлхийн олон орны бүтээн байгуулалтанд өргөн цар хүрээтэй ашиглагдаж байна.

-  Ундны ус хангамжийн шугам сүлжээ
-  Орон сууц, олон нийтийн барилгын дотор халуун, хүйтэн ус хангамж
-  Гадна ус хангамжийн шугам сүлжээ
-  Төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээ
-  Орон сууц, олон нийтийн барилгын халаалтын шугам
-  Хөдөө аж ахуйн усалгааны систем
-  Усан сан, бассейн
-  Химийн бодис дамжуулах хоолой

Диаметр: 16-450мм
Даралт: PN10,PN16,PN20
Ашиглалтын хугацаа: 50 жилээс дээш

Албан ёсны борлуулагч **Ультрасоник ХХК**











ХАЛААЛТ БА ХӨРГӨЛТИЙН ЗОРИУЛАЛТАЙ ХООЛОЙН СИСТЕМ




aquatherm blue pipe

Blue pipe дамжуулах хоолойн систем нь ундны усны гадна шугам сүлжээнд тусгайлан зориулан үйлдвэрлэгдсэн. PP-R дамжуулах хоолойн системийн бүхий л давуу талуудыг агуулахаас гадна Green pipe-тэй харьцуулахад нимгэн хананы нөлөөгөөр зарцуулалт харьцангуй өндөртэй байдаг.

-  Төвлөрсөн дулаан хангамж
-  Орон сууцны барилгын халаатын шугам хоолой
-  Хөргөлтийн систем
-  Усан сан
-  Газрын гүний дулаан
-  Химийн бодис дамжуулах хоолой

Диаметр: 20-630мм
Даралт: PN10,PN16,PN20,
Ашиглалтын хугацаа: 50 жилээс дээш

Албан ёсны борлуулагч Ультрасоник ХХК







ГАЛЫН СПРИНКЛЕР СИСТЕМИЙН ШУГАМ ХООЛОЙ

aquatherm red pipe

Red pipe нь хялбар шатдаггүй хүчитгэсэн 3 давхар үетэй, ISO чанарын стандартаар баталгаажсан хамгийн найдвартай галын спринклер системийн шугам хоолой юм.

 Галын хамгаалалтын систем

 Зэврэлт болон химийн үйлчлэлд тэсвэртэй

Бат, бөх чанар өндөртэй

Диаметр: 16-160мм

Даралт: PN12

Ашиглалтын хугацаа: 50 жилээс дээш

Албан ёсны борлуулагч **Ультрасоник ХХК**









ДУЛААЛГАТАЙ ШУГАМ ХООЛОЙН СИСТЕМ

AQUATHERM T1


Хол зайд халуун хүйтэн усыг түгээх, энергийн хувьд алдагдалгүй байх хамгийн үр дүнтэй арга бол шугам хоолойг газар доогуур булаах арга байдаг.

Энэхүү хэрэглээнд зориулж Aquatherm фирм нь ундны ус, халаалт, хөргөлтийн ус дамжуулах системд 20 бар даралт, 90 температур хүртэл ажиллах боломжтой ISO чанарын стандартын шаардлагыг хангасан дулаалгатай хоолойг бүтээсэн. Aquatherm T1 шугам хоолой нь үйлдвэрээс гарахдаа урьдчилан дулаалга хийгдсэн байдаг.

-  Халаалтын систем
-  Хөргөлтийн усны технологи
-  Ундны усан хангамж
-  Үйлдвэрийн усан хангамж

Диаметр: 16-355мм
Даралт: PN12
Ашиглалтын хугацаа: 50 жилээс дээш

Албан ёсны борлуулагч **Ультрасоник ХХК**





ТААЗ, ХАНА БА ШАЛНААС ХАЛААХ, ХӨРГӨХ СИСТЕМ

aquatherm black system

Орчин үеийн хэлбэр загварт баригддаггүй хэн бүхний сонирхол татахуйц загвар бол яах аргагүй BLACK систем юм. Халуун, хүйтэн холигчийн туслалцаатайгаар бүхэл бүтэн барилгын нэг өрөөгч өөрийн хүссэнээр температурыг сонгох болоцоотойгоор өрөөнд тань таатай уур амьсгалыг бүрдүүлж чадна.

Өндөр түвшинд хийгдсэн гагнуур холболт нь хоолойг нэгэн бүхэл болгохоос гадна найдвартай байдлыг дээд зэргээр хангаж эдэлгээг уртасгадаг.

- Чийгтэй болон хуурай байгууламжинд зориулагдсан
- Хяналтын энгийн төхөөрөмжтэй
- Холболтын аргачилал нь найдвартай
- Байгуулалтын өргөнийг хамгийн бага байхаар шийдсэн
- Зураг төсөл, дизайны өргөн сонголттой
- Усны алдагдалгүй




Албан ёсны борлуулагч Ультрасоник ХХК



AQUATHERM

ШУГАМ ХООЛОЙН ДАВУУ ТАЛ



Polypropylene-random (Полипропилен санамсаргүй/PP-R)- бол нүүрс төрөгч болон устөрөгчийн гинжнээс бүрдсэн термопластик юм. Энэ нь химийн хувьд тогтвортой болохоор түүний эргэн тойронд байгаа хортой болон хоргүй ямарч химин бодистой урвалд ордоггүйн дээр гадны нөлөөнд үл автах материал юм.

ХАЙЛУУЛАХ ТЕХНИК



Хуванцар шугам хоолой болон холбогч хэсгүүдийг тусгай гагнагч багаж ашиглан халааж эвцэлдүүлэх ба халааж нийлүүлсэнээс хэсэг хугацаа өнгөрсөний дараа нэг цул биет болдог.

Дэлхийн хамгийн өндөр стандартын дагуу үйлдвэрлэгдсэн полипропилен хуванцар шугам хоолойн систем.





ШУГАМ ХООЛОЙН УГСРАЛТ

1. ХОЛБОХ ТЕХНИК

Дамжуулах хоолой, түүний тоноглолыг хуванцар хайлуулах замаар нэгэн төрлийн болгож холбоно. Ингэхдээ дамжуулах хоолой дагалдах хэрэгслэлийг тусгай зориулалтын гагнуур ашиглан халаасны дараа шууд угсрана.

Холбогдсон хэсэгт хоёр материал давцан гагнаасыг зузаан болгох бөгөөд энэ нь гагнуурын найдвартай байдлыг хангахаас гадна дамжуулах хоолойн хамгийн чухал хэсэг болохыг илтгэж өгнө.

Aquatherm-н холбох техникийн тусламжтайгаар та маш хялбар байнгын бөгөөд ямар ч алдагдалгүй холболтыг хийж чадна.

2. ГАГНУУРЫН ТЕХНИК

Дамжуулах хоолойн суурилуулалтын төгсгөлийн үед ч гэсэн холболтыг хялбархан хийж гүйцэтгэх боломжтой.

Эмээл хэлбэрийн гагнуурын тусламжтайгаар та материал болон цагаа хэмнэнэ.

Гурвалсан холболтыг хийхийн тулд суурь хоолой болон салбар хоолой байхад хангалттай.

Албан ёсны борлуулагч **Ультрасоник ХХК**

1. ХОЛБОХ ТЕХНИК



2. ГАГНУУРЫН ТЕХНИК



«a»
aquatherm



ШУГАМ ХООЛОЙН ХОЛБОХ ХЭРЭГСЛҮҮД



Албан ёсны борлуулагч **Ультрасоник ХХК**



ҮЙЛДВЭР , АЛБАН БАЙГУУЛЛАГА, ОРОН СУУЦЫГ ЦАХИЛГААН, ДУЛААН, УСНЫ ТООЛУУРААР ХАНГАХ ТООЦООГ АВТОМАТЖУУЛАХ ТӨСӨЛ



ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Үйлдвэр , албан байгууллага, орон сууцыг олон улсын стандартын шаардлага хангасан ХБНГУ-ын сүүлийн үеийн тэргүүний техник технологид суурилсан цахилгаан, дулаан, усны тоолуураар хангах тооцонд автомат систем нэвтрүүлж үр ашгийг хүртэх

ТӨСЛИЙН ҮР ДҮН:

- Хэрэглэгч хэрэглэсэн хэмжээгээ тооцож, цахилгаан, дулаан, усны төлбөр тооцоогоо хийх
- Хэрэглээний хүрээд эрчим хүчийг хэмнэх
- Хэрэглэгчийн тав тухыг хангасан тооцооны систем нэвтрүүлэх



Албан ёсны борлуулагч УЛЬТРАСОНИК ХХК

ЦАХИЛГААН ТООЛУУР



ED1000



ED3000



ITZ



LZQJ



ТООЛУУРУУДЫН НИЙТЛЭГ ҮЗҮҮЛЭЛТ


АЖИЛЛАХ ТЕМПЕРАТУР	-40°C...+70°C
ТАРИФЫН ТОО	4+1тариф
Өнгөрсөн 15 сарын үр дүнг хардаг.	
8 тооны LC дэлцэгтэй, нөөц зай хураагуур > 10 жил	
Өвөл зуны цагийн хуваарьт автоматаар шилжинэ.	

ТООЛУУРЫН ЗААЛТ АВАХ БАГАЖ RACONET

////////////////////////////////////



- Raconet сүлжээний төлөвлөлт
- Радио холболтын чанарт анализ хийх
- Тоолуур бүрийн гаралтыг унших
- Ашиглахад хялбар
- UBS интерфейс
- Антеннтай



ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛ

1 ФАЗЫН ОЛОН ТАРИФТ ЭЛЕКТРОН ТООЛУУР

Тоолуурын марк: **ED1000**

////////////////////////////////////

ХҮЧДЭЛ	220 В
ГҮЙДЭЛ	5 (60) А
ДАВТАМЖ	50 Гц
НАРИЙВЧЛАЛ	Класс 1 (IEC 62053-21)
МЭДЭЭЛЭЛ	RS485B, D0

3 ФАЗЫН ТАРИФТ ЭЛЕКТРОН ТООЛУУР

/ACTIVE ENERGY/

Тоолуурын марк: **ED3000**

////////////////////////////////////

ХҮЧДЭЛ	3x220В/380В
ГҮЙДЭЛ	5 (60) А
ДАВТАМЖ	50 Гц
НАРИЙВЧЛАЛ	Класс 1 (IEC 62053-21)
МЭДЭЭЛЭЛ	RS485B, D0

3 ФАЗЫН ТАРИФТ ЭЛЕКТРОН ТООЛУУР

/ACTIVE ENERGY, REACTIVE ENERGY/

Тоолуурын марк: **ITZ**

////////////////////////////////////

ХҮЧДЭЛ	3x220В/380В
ГҮЙДЭЛ	5 (100) А
ДАВТАМЖ	50 Гц
НАРИЙВЧЛАЛ	Актив Класс 1
	Реактив Класс 2.0
МЭДЭЭЛЭЛ	RS485B, D0

ДАМЖУУЛАХ СҮЛЖЭЭНИЙ 4-Н КВАДРАНТ

/ КОМБИ ЭЛЕКТРОН ТООЛУУР

Тоолуурын марк: **LZQJ**

////////////////////////////////////

ХҮЧДЭЛ	3x100В
ГҮЙДЭЛ	5 (100) А
ДАВТАМЖ	50 Гц
НАРИЙВЧЛАЛ	Актив Класс 1
	Реактив Класс 2.0
МЭДЭЭЛЭЛ	RS485B, D0

ТООЛУУРЫН ЗААЛТ АВАХ АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМ

////////////////////////////////////

- Оптик толгойгоор заалт авах
- M-BUS-аар заалт авах
- Ойрын зайнаас заалт авах
- ARM алсын зайнаас заалт авах



Албан ёсны борлуулагч УЛЬТРАСОНИК ХХК

ДУЛААНЫ ТООЛУУР



Landis
Gyr+
manage energy better



ҮЙЛДВЭР, АЛБАН БАЙГУУЛЛАГЫН
ХЭРЭГЛЭЭНИЙ УСНЫ ТООЛУУР



ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ
УСНЫ ТООЛУУР

ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛ

ОРОН СУУЦНЫ ДУЛААНЫ ТООЛУУР

ULTRAHEAT 2WR6

ULTRAHEAT T230

ҮЙЛДВЭР, АЛБАН БАЙГУУЛЛАГЫН
ДУЛААНЫ ТООЛУУР

ULTRAHEAT UH50

ДАВУУ ТАЛ

- Хэт авианы зарчмаар ажилладаг
- Баттерейгаар ажилладаг (6 жил)
- Ашиглалтын хугацаа 15 жилээс багагүй
- Баталгаажуулалт хоорондын хугацаа 5 жил
- Сүүлийн 36 сарын хэрэглээгээ хянах боломжтой
- Олон улсын ISO9001 стандартад нийцсэн

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Номинал зарцуулалт	Qn=1.5m ³ /цаг
Диаметр	15мм
Температур	халуун ус +90 С хүртэл хүйтэн ус -40 С хүртэл
Даралт тах	105мм





ДУЛААНЫ ТООЛУУРЫН ҮЗҮҮЛЭЛТ, ТӨРЛҮҮД



НЭР ТӨРӨЛ	НОМИНАЛЬ ЗАРЦУУЛАЛТ м³/цаг	МАКСИМУМ ЗАРЦУУЛАЛТ м³/цаг	ДИАМЕТР мм	НОМИНАЛЬ ДАРАЛТ /бар/
-----------	----------------------------------	----------------------------------	---------------	-----------------------------

ULTRANEAT ДУЛААНЫ ТООЛУУР


UH5039	2.5 ХҮРТЭЛ	5,0 ХҮРТЭЛ	DN20	PN25
UH5046	3,5	7	DN25	PN25
UH5052	6	12	DN25	PN25
UH5061	10	20	DN40	PN25
UH5065	15	30	DN50	PN25
UH5070	25	50	DN65	PN25
UH5074	40	80	DN80	PN25
UH5083	60	120	DN100	PN25

ULTRANEAT 2WR6 ДУЛААНЫ ТООЛУУР /ОРОН СУУЦ/

2WR638	0.6	1,2	3/4"	PN25
2WR638	1.5	3	3/4"	PN25
2WR638	2.5 ХҮРТЭЛ	5,0 ХҮРТЭЛ	3/4"	PN25

ДУЛААНЫ ХЭРЭГЛЭЭГ ТООЛУУРААР ТООЦСОН ХЭМНЭЛТИЙН ГРАФИК

МОНГОЛЫГ ХҮҮХДИЙН ОРДОНЫ ЖИШЭЭН ДЭЭР:



63%

ХЭМНЭЛТ 63% БУЮУ 25,250,000₮





ШАЛГАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

НЭГ БА ГУРВАН ФАЗЫН 10 БА 5-Н ТОЛГОЙТОЙ ЦАХИЛГААН
ТООЛУУР ШАЛГАХ СУУРИН СТЕНД



НЭГ БА ГУРВАН ФАЗЫН ЦАХИЛГААН ТООЛУУР ШАЛГАХ ЗӨӨВРИЙН
СТЕНД, ГҮЙДЭЛ, ХҮЧДЭЛИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ХАМТ



PTS3.1



PTS3.3



PTS400.3

ЦАХИЛГААНЫ ТООЛУУР БА ХЭМЖИЛТИЙН
ТРАНСФОРМАТОР ШАЛГАХ ЗӨӨВРИЙН СТЕНД



CALPORT 300

ГҮЙДЛИЙН ТРАНСФОРМАТОР ШАЛГАХ ЗӨӨВРИЙН БАГАЖ



РТТ 2.1

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүчдэл: 46V-300V

Гүйдэл: 1mA-3000mA

Хэмжээ: W125 x H236 x D41mm

Жин: 650gp

НЭГ БА ГУРВАН ФАЗЫН ЦАХИЛГААН ТООЛУУР ШАЛГАХ ЗӨӨВРИЙН БАГАЖ
техникийн бус алдагдалыг тодорхойлох, газар дээр нь хэмжилт хийх зориулалттай



PSM 2.1

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1 ФАЗЫН

Хүчдэл: 46V-300V

Гүйдэл: 1mA-3000mA

Хэмжээ: W125 x H236 x D41mm

Жин: 650gp



PWS 2.3

ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

3-Н ФАЗЫН

Хүчдэл: 46V-300V

Гүйдэл: 1mA-3000mA

Хэмжээ: W290 x H216 x D81mm

Жин: 2200gp

Албан ёсны борлуулагч **УЛЬТРАСОНИК ХХК**



АМИНЫ ОРОН СУУЦНЫ ЦОГЦ ШИЙДЭЛ

STIEBEL ELTRON









ШӨНӨ ДУЛААН ХАДГАЛАГЧ




АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХАЛААЛТЫН ЦОГЦ ШИЙДЭЛ



Шөнө дулаан хадгалагч нь өндөр багтаамжтай нягтаршуулсан тусгай тоосгыг цельсийн 600 градус хүртэл халааж дулаанаа нөөцөлдөг ба нөөцөлсөн дулаанаа өдрийн цагт ялгаруулах зарчимаар ажилладаг. Дулаан түгээлт нь шөнө дулаан хадгалагчийн дотор байрлах дуу чимээгүй зориулалтын сэнсний тусламжтайгаар явагддаг. Ийм замаар өрөө тасалгаанд халуун агаар жигд хурдан тархдаг.

-  • Шөнө дулаан хадгалагч нь дулааныг хуримтлуулах болон ялгаруулах электрон удирдлагатай
-  • Өрөө тасалгааны температурыг +10...+30oC тохируулах боломжтой
-  • Шөнийн ачаалал багатай, хямд тарифын цахилгааныг ашигладаг
-  • Шалны цахилгаан халаалт болон цахилгаан хийн түлшний зуухны халаалттай харьцуулахад урсгал зардал 3-4 дахин бага
-  • Нүүрс, түлш, халаалтын зуух, халаах хэрэгсэл труба хоолой шаардахгүй
-  • 100% агаарын бохирдолгүй /агаарыг шатаахгүй, хуурайшуулахгүй/



ХАЛААЛТЫН ТӨХӨӨРӨМЖИЙН ТӨРЛҮҮД

МАРК	ЦАХИЛГААН ҮЗҮҮЛЭЛТ		ОВОР ХЭМЖЭЭ /ММ/		
	ХҮЧДЭЛ	ЧАДАЛ	УРТ	ӨРГӨН	ӨНДӨР
ETS 700	380 В	7 КВТ	1494	245	650
ETS 600	380 В	6 КВТ	1314	245	650
ETS 500	380 В	5 КВТ	1144	245	650
ETS 400	220/380 В	4 КВТ	964	245	650
ETS 300	220/380 В	3 КВТ	794	245	650
ETS 200	220/380 В	2 КВТ	605	245	650
ETC 340	220 В	3,4 КВТ	1045	170	700
ETC 250	220 В	2,4 КВТ	815	170	700
ETC 170	220 В	1,7 КВТ	605	170	700

Албан ёсны борлуулагч **Ультрасоник ХХК**



ХАНАНЫ КОНВЕКТОР

АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХАЛААЛТЫН ЦОГЦ ШИЙДЭЛ



Хананы конвектор нь бүх төрлийн өрөө тасалгаанд үндсэн болон нэмэлт халаалтаар хананд суурилуулж хэрэглэнэ.

- Хөлдөлтөөс хамгаалах функцтай
- Угсарч суурилуулахад хялбар, бага орон зай эзэлнэ
- Өрөө тасалгааны температурыг +5 °C... +30 °C хооронд тохируулах термостат тохируулагчтай
- Ажиллах үеийн дуу чимээгүй

ЗАГВАР ТӨРӨЛ	ЧАДАЛ	ОВОР ХЭМЖЭЭ /мм/	ЖИН /кг/
CNS 50	0,5 кВт/230 В	450/370/100	3
CNS 100	1,0 кВт/230 В	450/450/100	4,2
CNS 150	1,5 кВт/230 В	450/590/100	5,6
CNS 200	2,0 кВт/230 В	450/740/100	7
CNS 250	2,5 кВт/230 В	450/890/100	8,4



ХӨЛДӨЛТӨӨС ХАМГААЛАГЧ

АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХАЛААЛТЫН ЦОГЦ ШИЙДЭЛ

- Жижиг өрөө тасалгааг хөлдөх хэмээс дээш байлгах үед хэрэглэнэ
- Усны өрөө, жижиг агуулах г.м газарт илүү тохиромжтой
- Усны шугамуудыг хөлдөхөөс найдвартай хамгаалж, зөдрэхээс сэргийлнэ

ЗАГВАР ТӨРӨЛ	ЧАДАЛ	ОВОР ХЭМЖЭЭ /мм/	ЖИН /кг/
CFK 5	0,5 кВт/230 В	387/170/110	1,2



ИНФРА ТУЯАНЫ ХАЛААГУУР

АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХАЛААЛТЫН ЦОГЦ ШИЙДЭЛ

- Нарны туяаны бүгцэд байдаг инфра туяаны дулаан солилцооны зарчмаар ажилладаг
- Агаарыг халаалгүйгээр шууд инфра туяа туссан хэсгийн гадаргууг халаадаг.
- Тусгалын өнцгийг 20°- 40° тохируулж болно.
- Террас, өвлийн сад, ариун цэврийн өрөө, бассейны өрөө

ЗАГВАР ТӨРӨЛ	ЧАДАЛ	ОВОР ХЭМЖЭЭ /мм/	ЖИН /кг/
IW 120	0,4/0,8/1,2кВт/230В	145/535/85	1,55
IW 180	0,6/1,2/1,8 кВт/230В	145/535/85	1,55



Албан ёсны борлуулагч **Ультрасоник ХХК**



ЗӨӨВРИЙН КОНВЕКТОР

АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХАЛААЛТЫН ЦОГЦ ШИЙДЭЛ



- Өрөө тасалгааны халаах шаардлагатай бүх хэсэгт нэмэлтээр зөөж ашиглах боломжтой
- Тасалгааны температурыг +5°C-аас +30°C хооронд тохируулах термостат тохируулагчтай
- Хананд суурилуулж ашиглах боломжтой
- CS 20 L загвар нь нэмэлт үлээх сэнстэй

ЗАГВАР ТӨРӨЛ	ЧАДАЛ	ОВОР ХЭМЖЭЭ /мм/	ЖИН /кг/
CS 20	0,75/1,25/2,0 КВТ	435/600/100	4,6
CS 20 L	0,75/1,25/2,0 КВТ	437/600/100	6



ХАНАНЫ СЭНСТЭЙ ХУРДАН ХАЛААГЧ

АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХАЛААЛТЫН ЦОГЦ ШИЙДЭЛ



- Маш хурдан хугацаанд өрөө тасалгааг халаах ба хананд суурилуулж ашиглана
- Сэнсний тусламжтайгаар агаарын урсгалыг хурдасгаж халаадаг
- Өрөө тасалгааны температурыг +50C-аас +300C хооронд тохируулах термостат тохируулагчтай
- Агаар шатаахгүй, хуурайшуулахгүй
- Бага зай эзэлдэг
- Ажиллах үеийн дуу чимээ бага
- Ариун цэврийн өрөөнд маш тохиромжтой

ЗАГВАР ТӨРӨЛ	ЧАДАЛ	ОВОР ХЭМЖЭЭ /мм/	ЖИН /кг/
CKR 205	1,0/2,0 КВТ/230 В	460/335/123	4,4



Албан ёсны борлуулагч **Ультрасоник ХХК**



ЭЗЭЛХҮҮНИЙ УС ХАЛААГЧ



БАЙНГЫН ХАЛУУН УС



ЗАГВАР ТӨРӨЛ	ЧАДАЛ	ОВОР ХЭМЖЭЭ /УРТ, ӨНДӨР/	БАГТААМЖ /л/
SN 5 S, SNU 5 S	2 КВТ/220 В	263/230/422	5
SN 10 S, SNU 10 S	2 КВТ/220 В	295/275/503	10
SN 15 S	2 КВТ/220 В	316/295/600	15

ЗАГВАР ТӨРӨЛ	ЧАДАЛ	ОВОР ХЭМЖЭЭ /УРТ, ДИАМЕТР/	БАГТААМЖ /л/
PSH 30 Si	2 КВТ/220 В	623 / 338	30
PSH 50 Si	2 КВТ/220 В	918 / 338	50
PSH 80 Si	2 КВТ/220 В	780 / 505	80

ТӨВЛӨРСӨН ЦАХИЛГААН БОЙЛЕР

- Температур тохируулагчтай
- Шөнийн хямд тарифаар ажилладаг
- Дулааны алдагдал маш бага
- Ашигт үйлийн коэффициент өндөр



БАГТААМЖ	ХАЛУУН УСНЫ ХОЛЦЫН ХЭМЖЭЭ 40°C / 10°C / 65°C	ЗАРЦУУЛАЛТ /Л, МИН/	ЦАХИЛГААН ҮЗҮҮЛЭЛТ /ШӨНИЙН ТАРИФААР АЖИЛЛАХ/	ОВОР ХЭМЖЭЭ /ДИАМЕТР, ӨНДӨР/
200	370л	30	2, 4КВТ - 220В 2, 3; 4; 6КВТ - 400В 2/4; 4/4КВТ - 230В 2/6; 3/6; 4/6; 6/6КВТ - 400В	430 / 1570
300	550л	38	2, 4КВТ - 230В 2, 3; 4; 6КВТ - 400В 2/4; 4/4; 4/4.1КВТ - 230В	490 / 1585
400	730л	45	2/6; 2/6.3; 3/6; 4/6; 6/6; 6/6.3КВТ - 400В	540 / 1755
600	1100л	50	7,5; 5; 12КВТ - 400В 6/12; 12/12КВТ - 400В	750 / 1685
1000	1830л	70	12; 9; 18КВТ - 400В 9/18; 18/18КВТ - 400В	750 / 2525

SH...S, SHU...S

- Температур тохируулагчтай 350С-850С
- Гал тогоо, угаалтуурт зориулсан
- Цахилгаан зарцуулалт маш бага



PSH...Si

- Температур тохируулагчтай 350С-650С
- 30, 50, 80, 100, 120, 150 л багтаамжтай



SHZ...LCD

- LCD дэлгэцтэй
- Температур тохируулагчтай 350С-820С
- 220в хүчдэлээр ажилладаг
- Хурдан халаах функцтэй
- 30, 50, 80, 100, 120, 150 л багтаамжтай



УС БУЦАЛГАГЧ

- Температур тохируулагчтай 350С-1000С
- 220в хүчдэлээр ажилладаг
- 5, 15, 50 л багтаамжтай



Албан ёсны борлуулагч **Ультрасоник ХХК**



ХАЛУУН УСНЫ ДУЛААНЫ НАСОС

БАЙНГЫН ХАЛУУН УС



АМИНЫ ОРОН СУУЦНЫ ХАЛУУН УСНЫ ДУЛААНЫ НАСОС

- Температур тохируулагчтай 350С-650С
- 300л багтаамжтай



НИЙТИЙН ОРОН СУУЦНИЙ ХАЛУУН УС, АГААРЖУУЛАЛТЫН ДУЛААНЫ НАСОС

- Температур тохируулагчтай 350С-650С
- 100л багтаамжтай



Албан ёсны борлуулагч **Ультрасоник ХХК**



БАЙНГЫН ХАЛУУН УС

Халаалтын цахилгаан зуух нь төвийн нэгдсэн дулаанд холбогдоогүй амины орон сууц, жуулчны бааз болон амралт сувилалын газар гэх мэт жижиг барилга байгууламжийн радиаторан ба шалны халаалтын системийг халаахад зориулагдсан бүтээгдэхүүн юм.

Зуухны хүчин чадлыг тухайн халаах талбайнаасаа хамааруулж ихэсгэж багасгах боломжтой.

ДАВУУ ТАЛУУД:

- Өөрийн хүссэн дулааныг тохируулах автомат удирдлагатай
- Бүрэн тоноглогдсон
- Суурьлуулахад хялбар бөгөөд энгийн
- Орчин тойронд хор нөлөө байхгүй.

ХАЛААЛТЫН ЗУУХНЫ ИЖ БҮРДЭЛ:

- Эх бие халаагч тенн
- Эргэлтийн насос
- Температур тохируулагч электрон хэсэг
- Даралт хэмжигч манометр, термометр
- Аюулгүйн вентиль
- Тэлэлтийн сав,
- Хувиарлагч
- Гадна хайрцаг
- Өрөөний температур тохируулагч
- Хугацааны реле





З.БАЯНСЭЛЭНГЭ: ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛСНААР ЗЭЭЛИЙН БОСГО НАМСАЖ, ТӨЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ БАГАСНА

Ипотекийн зээлийн хүүг 5 хувь болгох боломжтой тухай мэдээлэл магадгүй энэ жилийн хамгийн таатай мэдээлэл биз. Олон нийтийг баярлуулж, чийгийг мялаасан энэ асуудал Засгийн газрын хуралдаанаар дэмжигдэж, УИХ-аар хэлэлцэгдэхээр болоод байна. Үүнтэй холбогдуулан БХБ-ын сайд З.Баянсэлэнгээс зарим зүйлийг тодрууллаа.

- Удтал яригдсан бас хүлээлт үүсгэсэн энэ асуудал гацаанаас гарч байх шиг байна. Ярилцлагаа эхлэхээс өмнө танд болон БХБЯ-ны хамт олонд иргэдийн өмнөөс талархах нь зүйтэй болов уу

-За баярлалаа. Өнгөрсөн хугацаанд хамтран ажилласан бүх хүмүүстээ бас талархлаа илэрхийлье. Одоо орон сууцны зах зээл дээр орон сууцанд орох иргэдийн тоо өсч, иргэдийн худалдан авах чадвар, орон сууцны борлуулалт нэмэгдэх гээд үсрэнгүй өөрчлөлтүүд гарна. Эцэстээ барилга, барилгын материалын үйлдвэрлэл сэргэж, эдийн засагт сайнаар нөлөөлөх юм. Сайхан байна.

- Засгийн газрын хуралдаанаар ипотекийн зээлийн хүүг бууруулах саналыг дэмжсэн. Одоо энэ зээлийн хүүгийн асуудал эцэслэж, хэрэгжиж эхлэхийг л иргэд тэсэн ядан хүлээж байна даа?

-Энэ асуудал нэг их хүндрэлгүйгээр шийдэгдчих байх. Учир нь энэ зээлийн хөтөлбөрийг үндсэндээ МАХН, "Шударга ёс" эвслийнхэн, Иргэний зориг, Ногоон нам, АН-ын нийт 47 гишүүн санаачлан өргөн барьж байгаа. УИХ-ын 76 гишүүний 47 нь гэхээр дийлэнх олонх тул дэмжигдэнэ гэж найдаж байна. Дээр нь МАН-ынхан ч энэ асуудлыг дэмжихээр болсон. Өөрөөр хэлбэл, улстөрийн "ногоон хаалга" нээгдчихлээ гэсэн үг. Зээлийн хүүг бууруулах ажлыг хийж байгаа бидний хувьд ч улстөрийн уур амьсгал нь аятайхан болж байна уу даа гэсэн дүгнэлт хийж байна.

-Засгийн газрын хуралдаанаар салбарын ямар асуудлуудыг голчлон авч хэлэлцэв?

-Хоёр асуудлыг авч хэлэлцсэн. Нэгдүгээрт, ипотекийн зээлийн нөхцөл доторх 80 м2 хүртэл гэх заалтыг хасч 100 м2 хүртэл, 100 м2-аас дээш гэсэн 2 хувилбар гаргаж ирсэн. Монголчууд одоо хэчнээн ядуу, эдийн засгийн хямралтай байгаа хэдий ч гэсэн зай талбай томтой, сайхан байранд ая тухтай амьдрахыг хүсэх нь мэдээж шүү дээ. Эдгээр иргэд дээрх хуулийн өөрчлөлтөөр ипотекийн зээлд хамрагдах боломжтой болох төдийгүй нөгөө талаас ам бүл олуулаа айл 80 м2-аас дээш хэмжээтэй байр авмаар байдаг ч боломж нь хаалттай байсан бол одоо эрх нь нээгдэж ипотекийн 5% ийн зээлд хамрагдах боломжтой болж байгаа юм. Хоёр дахь асуудал бол талбай томтойгоос болоод борлуулагдахгүй байсан орон сууцнууд эргэлтэд орох явдал. Нийт барилгын 11-24 хувь нь 80 м2-аас дээш байх магадлал өндөр гэх судалгааг бид бас хийсэн. Тэгэхээр нийт барилгын 11-24 хувь нь ипотекийн зээлд хамрагдан борлуулагдаж чадахгүй байж. Ийм тохиолдолд барилгын компаниуд борлогдохгүй байгаа байруудаа дахин засч, зохион байгуулалтыг нь өөрчлөн, эрэлттэй хэмжээнд нийцүүлэх гэж хичээх болсон. Энэ дахин ийм байдал үүсэхээргүй боллоо.

-Ингэхэд ипотекийн зээл хэр явж байв? Одоо гацаанаас яаж гарах вэ, арга замыг нь яаж харагдаж байна?

-Ер нь бол сард дунджаар 1200-1300 өрх ипотекийн 8 хувийн хүүтэй зээлд хамрагддаг байжээ, Үндсэн хуулийн цэцийн 13 тоот шийдвэрээс өмнө. Одоо бол зогсонги байдалд байгаа шүү дээ. Яагаад ийм байдалд хүрсэн гэхээр, өмнө нь банк иргэн хоёр хоорондоо хүүгээ, хэмжээгээ тохироод гэрээгээ хийдэг байсан. Энэ үед бол банк тухайн иргэнийг байраа хөлслөхийг, түрээслэхийг, өөр хүнд ашиглуулахыг зөвшөөрч байсан. Гэтэл дээр



дурдсан шийдвэрээр давхар барьцаалах эрх үүссэнээрээ иргэнд тухайн үл хөдлөх хөрөнгөө бусдад шилжүүлэх, эрх шилжүүлэх, бэлэглэх, давхар барьцаалах, давхар худалдах эрхийг үүсгэчихсэн. Энэ тохиолдолд банкууд эрсдэл үүслээ гэж үзээд зээлээ зогсоочихсон. Ийм нөхцөл байдал үүсэхээр банкуудын холбооны хуулийн зөвлөхүүд ажиллаад манай гаргаж байсан саналуудтай адил төстэй санал гаргаж ирсэн. Энэ нь Иргэний хуулийн 171.2, Үл хөдлөх хөрөнгө барьцаалах хуулийн 23.2, 30.3, 30.4 дэх заалтыг өөрчлөх. Ингэхдээ анхны барьцаалагчаас заавал зөвшөөрөл авах гэсэн заалт оруулах хэрэгтэй.

-Өмнө нь хэдий хэмжээний зээл олгосон юм бол? Цаашид зайлшгүй үргэлжлүүлэх шаардлагатай юу?

-Анх 2013 оны зургадугаар сарын 17-ноос хойш ипотекийн зээл олгож эхэлсэн бөгөөд банкууд өнөөг хүртэл нийт 76600 өрхөд 3.4 их наяд төгрөгийн зээл өгчээ. Одоо Монголбанкнд 330 тэрбум төгрөг бүхий зээлийн хуримтлалын сан бий. Энэ бол маш том тоо. 2015 оны байдлаар Улаанбаатар хотод 18723, орон нутагт 5627, нийт 24350 айлын орон сууц ашиглалтад орсон бол ирэх жил Улаанбаатарт 18941, орон нутагт 7177, нийт 26118 айлын орон сууц дахиад ашиглалтад орно. Ялангуяа орон нутагт орон сууц ашиглалтад орох тоо нэлээд хэмжээгээр нэмэгдэж байгаа. 2015 оны үлдэгдэл дээр 2016 онд шинээр нэмэгдэх орон сууцны тоо нэмэгдээд 40-өөд мянга болсон ийм нөхцөлд ипотекийн зээлийг үргэлжлүүлэхээс өөр арга байхгүй. Тэр тусмаа даруйхан шийдэхгүй юм бол банкаа ч, эдийн засгаа ч унагах эрсдэлтэй нөхцөл байдал үүснэ. Үүнийг манай төрийн өндөрлөгүүд ач холбогдол өгөөд оролцож байгаад нь маш их талархаж байна.

-Гадаад орнуудын туршлагаас харахад ипотекийн зээл их олон төрөл байдаг юм билээ. Манай хөрсөнд буулгаж байгаа энэ хувилбарыг яаж үр ашигтай үргэлжлүүлэх вэ?

-Дэлхий дахин ипотекийн зээлийн хэрэгждэг 14 төрлийн арга буюу борлуулалтын суваг байдгийн хоёрыг нь л Монголд хэрэглэж байна. Нэг нь ипотекийн үндсэн зээл. Нөгөөх нь түрээсийн орон сууц. Бид үндсэн зээлээрээ "Ипотекийн зээлийн баталгааны бонд" гэж бий болгоно. Үүнийг Монголбанкнд дахь 3.4

их наяд төгрөгийн хуримтлалаас 2016 онд 2.5-2.6 их наядыг нь төвлөрүүлэх юм байна лээ. Энэ мөнгөө Төрийн сан буюу ирээдүйн тэтгэврийн сан руу нийлүүлж, эндээсээ орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгааг санхүүжүүлбэ, эрүүл мэнддээ, тэтгэвэртээ өгье гэсэн санааг Засгийн газар болон Монголбанк УИХ-аар дамжуулаад шийдэхээр болсон.

-Зээлийн асуудал УИХ, Засгийн газрын түвшинд судлагдаад, хэлэлцэгдээд явж байна. Ямар өөрчлөлтүүд гарахаар байна вэ?

-Одоо УИХ, Засгийн газар дээр юу хийгдэж байгаа вэ гэхээр УИХ-аас ипотекийн зээлийн хуучин процессийг хэвийн болгоё гэдэг дээр ерөнхийдөө санал нэгдчихсэн явж байгаа. Үүнийгээ Засгийн газрын тогтоолоор баталгаа гаргаад ипотекийн зээлээр баталгаажсан 2.5 их наядын бондыг бий болгох. Эндээсээ иргэддээ нэрийн данс үүсгээд, бондыг арилжааны банкууд МИК-иар дамжуулаад арилжаална. Банкууд иргэдтэй гэрээ хийж, иргэдийг бондтой болгон мөнгөжүүлээд орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгааг санхүүжүүлэх юм. 2013 оноос Ипотекийн зээл олгож эхэлснээс хойш нийт 2,7 их наяд төгрөгийн зээлийг 60,5 мянган иргэнд олгосон байдаг. Үүнийг нэг хүнд тооцож үзвэл 46 сая төгрөгийн зээлтэй, зээлийн хүнд сард 307 мянган төгрөг төлдөг байсан. 18 жил, 8 хувиар нь тооцоход шүү дээ. Тэгвэл одоо 5 хувиар тооцоход зээлийн хүүнд сард 192 мянган төгрөг төлөх болж сар бүр 115 мянган төгрөг хэмнэх тооцоо гарч байгаа юм.

-Зээлийн босго ч намсаж, төлбөрийн нөхцөл ч хөнгөрч байгаа, тиймүү?

-Тэгэлгүй яахав, тухайн иргэний байрны зээлийн хүү гуравны нэгээр багасч байна. Энэ нь иргэдэд олдож байгаа бас нэг маш том бололцоо.

-Та банкуудын захирлуудыг дуудаж уулзсан гэсэн. Ямар тохиролцоонд хүрэв?

-Өмнө нь яагаад ипотекийн зээлийн хүү 8 хувь байсан бэ гэвэл төр 4 хувийнх нь санхүүгийн эх үүсвэрийг өгөөд, банкууд өөрийнхөө үйл ажиллагааны 4 хувийг нэмж байсан. Одоо банкууд 4 хувь дээр үйл ажиллагааныхаа зардлын 1 хувийг нэмээд 5 хувь байх бололцоотой гэдэг дээр санал нэгдсэн.



Засгийн газрын энэ оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар Төрийн орон сууц корпорацийн захиалгаар Улаанбаатар хот болон орон нутагт барьж ашиглалтад оруулсан 929 айлын орон сууцыг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

ЭНЭ ТАЛААР БХБЯ-НЫ БАРИЛГА, НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГЫН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.ЭНХТУЯАТАЙ ЯРИЛЦЛАА

- Төрийн түрээсийн орон сууцанд иргэд хэзээнээс хамрагдах вэ, ямар шаардлага хангасан иргэд хамрагдах боломжтой вэ?

Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг баталсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд, тус яамнаас төрийн түрээсийн орон сууцны сан бүрдүүлэх асуудлаар санал боловсруулж Засгийн газрын энэ сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, ТОСК-ийн захиалгаар Улаанбаатар хот болон орон нутагт барьж ашиглалтад оруулсан 929 айлын орон сууцыг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэхээр шийдвэрлүүлсэн.

Эдгээр 929 орон сууцны 350 орон сууц нь Улаанбаатар хотод, 579 орон сууц нь Архангай, Увс, Дархан-Уул, Хэнтий, Ховд аймгийн төвүүд, Сэлэнгэ аймгийн Зүүнхараа, Хэнтий аймгийн Бор-Өндөрт баригдсан сууцууд байгаа.

Одоо тус яамнаас хөтөлбөрийн хүрээнд бий болсон түрээсийн сууцанд иргэдийг хамруулах, түрээсийн орон сууцанд амьдрах иргэн ямар нөхцөл шаардлагыг хангасан байх, түрээсийн орон сууцтай холбоотой харилцаанд оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлох асуудлаар журмын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авах түвшинд байна.

Энэхүү журмыг энэ оны 1 дүгээр улиралд багтаан батлуулж, мөрдүүлнэ. Журам батлагдсанаар иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах асуудал тодорхой болно.

Орон сууц худалдаж авах боломжгүй, орон сууцанд амьдрах хүсэлтэй иргэдэд хүрсэн бодлогыг анх удаа хэрэгжүүлэх гэж байна. Энэ нь олон талын ач холбогдолтой.

Тухайлбал, манай улсад 1990 оноос хойш хотжилт эрчимтэй явагдаж, иргэд хот, суурин газарт шилжин суурьших болсонтой холбоотойгоор төлөвлөлт, зохицуулалтгүйгээр гэр хороолол ихээхэн нэмэгдэж агаар, хөрс, усны бохирдол зөвшөөрөгдөх дээд хэмжээг даваад байна.

Иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулснаар дээрх асуудлыг зохих хэмжээнд бууруулахаас гадна тэдний орон сууцны нөхцлийг сайжруулахад маш чухал нөлөөтэй. Орон сууцны нөхцөл сайжирснаар тэдний ажиллах, сурч, боловсрох нөхцөл сайжирна.

-Түрээсийн орон сууцанд тавигдах шаардлага ямар байх, хэдэн төгрөгийн төлбөртэй байх вэ.

Хөтөлбөрт түрээсийн орон сууцанд тавигдах шаардлагыг тодорхой тусгасан байгаа. Төрийн болон орон нутгийн өмчийн нэг айлын түрээсийн сууц нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчинг бүрдүүлсэн, инженерийн иж бүрэн хангамжтай, зочны, унтлагын, гал тогоо, ариун цэврийн өрөө бүхий 30-50 м2 хүртэлх талбайтай сууц байна. Хувийн хэвшлийн нэг айлын түрээсийн орон сууцны хувьд талбайн дээд хязгаарыг тогтоохгүй бөгөөд талбайн доод хэмжээ 30 м2-аас багагүй байна гээд заачихсан байгаа.

Мөн түрээсийн орон сууцны нэг сарын түрээсийн хөтөлбөрийн хэмжээг Үндэсний статистикийн хорооноос гаргадаг жил бүрийн “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-нд тулгуурлан өрхийн дундаж орлогын 25 хувиас хэтрэхгүй байхаар хот, хөдөөд ялгавартай тогтоож мөрдүүлэхээр заасан байгаа.

Үүний дагуу түрээсийн орон сууцны үнийн талаар Засгийн газрын мөн өдрийн хуралдаанд танилцуулсан. Тодруулбал, орон сууцны талбайн хэмжээнээс хамааруулан нийслэлд ам метр нь 6500 төгрөг, орон нутагт ам метр нь 4500 төгрөг байх саналыг дэмжсэн. Гэхдээ энэ үнэ жил бүр өөрчлөгдөнө. Яагаад гэвэл Үндэсний статистикийн хорооноос гаргадаг өрхийн дундаж орлого жил бүр өөрчлөгддөг.

-Хэдэн жил төрийн түрээсийн орон сууцанд амьдрах боломжтой вэ?

-Амьдрах хугацааг түрээслэгч, түрээслүүлэгчийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулахаар журмын төсөлд тусгаж байна.

-Тухайн иргэн түрээсийн орон сууцанд амьдарч байгаад цаашид худалдаж авч болох уу?

Худалдаж авахыг хөтөлбөрт хориглосон байгаа. Түрээсийн орон сууцыг бусдад худалдах, барьцаалах, бэлэглэх, өв залгамжлуулах, дамжуулан түрээслэх болон өөр ямар нэгэн хэлбэрээр бусдын өмчлөлд шилжүүлэхийг хориглосон. Яагаад гэвэл түрээсийн сууц нь тухайн иргэнийг хуримтлалтай болоод, өөрийн орон сууцтай болох хүртлээ амьдрах байр юм.

Ярилцлага өгсөн танд баярлалаа.
Баярлалаа.



Р.МЯГМАР: ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙГ ГЭРЭЭТ АРИЛЖААНЫ ЗАГВАРТ ШИЛЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ

хүчний зах зээлийг өрсөлдөөний хэлбэрт шилжүүлэх, үе шаттайгаар хөгжүүлэх, зах зээлд оролцогчид арилжааны хэлбэрт шилжих суурь нөхцөлийг бүрдүүлэхгүй байна гэсэн үг юм.

Герман улсын цахилгааны зах зээл ямар зарчмаар явдаг, бид түүнийг хэрэгжүүлэх боломж байна уу?

Цахилгааны өрсөлдөөнт зах зээлийг нэвтрүүлсэн 30 орчим улс орон байдаг. Герман улсын хувьд 1998 он хүртэл байгалийн монополи байсан бол 2001 оноос өрсөлдөөнт зах зээлрүү шилжих эхлэлийг тавин манайхтай төстэй станцуудаа буулгаж, шинэ станцууд ашиглалтад оруулснаар энэ загварт шилжсэн байдаг. Үүнийг хэрэгжүүлэхэд эхний ээлжинд эрчим хүчний байгууллагын бүтцийн задаргаа хийдэг юм байна. Манай улс бүтцээ задалчихсан боловч Германы үлгэр жишээг хуулбарлаад бий болгох бололцоо байхгүй. Яагаад гэвэл хэрэглэгч өөрийнхөө сүлжээг сонгох, хангагч үйлдвэрлэгчээ сонгох техникийн бололцоогүй. Мөн хот суурин газрын дулаан хангамжийг сайжруулахад зориулсан станцуудын хүчин чадал нь харилцан адилгүй учраас өртгийн зөрүүтэй. Үүнээс гадна бүтээгдэхүүн хоорондын татаас гэж байна. Энэ нь дулаан бодит өртөгтөө хүрээгүй учир цахилгаанаас татаас авдаг, хэрэглэгчийн үнийг тогтмол хязгаарлан бүсчлэн тогтоож байгаа зэрэг нь өртөгт суурилсан тариф тогтоох нөхцөл бүрдээгүйг харуулж байна. Харин бид өрсөлдөөний зах зээлийг нэвтрүүлэхээр эхний шатанд гэрээт арилжааны загварыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Гэрээт арилжааны загварыг нэвтрүүлэх ажил ямар төвшинд явж байна вэ?

Бид эхний ээлжинд “Гэрээт арилжааны загвар”-ыг нэвтрүүлэхээр судалгаа хийж аргачлалыг боловсруулах төвшинд ажиллаж байна. Энэ бол цаг хугацаанаас хамаарсан үе шаттай хийгдэх ажил учир эрчим хүчний шинэ эх үүсвэрүүд ашиглалтад орохтой уялдуулан төлөвлөгөө гаргаад байна.

Одоогийн цахилгааны зах зээлд мөрдөгдөж буй нэг худалдан авагчтай загварыг өөрчилснөөр ямар үр дүн гарах вэ?

Эрчим хүчний салбар л зах зээлийн нийгэмд төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоотой үйл ажиллагаагаа явуулсаар байна. Энэ нь ТЗЭ компаниуд цаашид зах зээлийн зарчмаараа ажиллах нөхцөлийг бүрдүүлэхгүй, өр авлага үүсгэж салбарын хэмжээнд алдагдалтай ажиллаж байгаа юм. Тэгвэл гэрээт арилжааны загварт шилжсэнээр тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын санхүүгийн хариуцлагын систем сайжирч, эх үүсвэрийн авлага өглөг, нэг худалдан авагчтай загварын алдагдал үүсэхгүй байх боломжтой юм.

Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний системийн үр ашиг төслийн хэрэгжүүлэгчидтэй хамтран 2016 оны нэгдүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Эрчим хүчний зах зээл болон эрчим хүчний арилжаа сэдэвт сургалт зохион байгууллаа. Энэхүү сургалтад Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо болон тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын төлөөлөл оролцов. Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулагч Р.Мягмараас цахилгааны зах зээлийн загварын талаар тодрууллаа.

Манай улс цахилгаан эрчим хүчний зах зээлийн ямар загварыг мөрдөж ажилладаг вэ?

Манай улс төвийн бүсийн цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хүрээнд “Нэг худалдан авагч”-тай загварыг мөрдөөд 15 жил болж байна. Энэ загвар нь 2011 он хүртэл харьцангуй тогтвортой байсан. Гэвч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд дотоод тарифыг өсгөх хандлагыг бий болгож, өрсөлдөөний зарчмаар явах боломжгүй байсаар өдийг хүрсэн. Тарифын өрсөлдөөнийг бүрдүүлээгүй учраас шинэ тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нэг худалдан авагчтай загварт шууд оролцох боломжтой, орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд төвийн бүсээс татаастай ажилладаг гээд тулгамдаж буй асуудлууд байсаар байна. Уг нь нэг худалдан авагчтай загварын сонгодог хувилбар нь эх үүсвэрүүд үнээр өрсөлдөж нэг худалдан авагч буюу дамжуулах сүлжээнд цахилгаан нийлүүлдэг зарчимтай. Гэтэл манайд харилцан адилгүй өртөгтэй үйлдвэрлэгчидтэй тул өрсөлдөх боломж хязгаарлагдмал учраас бүх үе шатандаа зардалд суурилсан тарифын зохицуулалт хийгддэг, байгалийн монополи арилжааны урсгал буюу өөрөөр хэлбэл мөнгө, энергийн урсгалын хуваарилалтын загвар байдлаар үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь цаашид цахилгаан эрчим



Х.ЭРДЭНЭЧУЛУУН: ТӨВИЙН БҮСИЙН 280 МЯНГА ГАРУЙ ӨРХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨНГӨЛӨЛТӨД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ

Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Эрчим хүчний сайд Д.Зоригт, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга С.Отгонбаяр нартай уулзаж, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо хамтраад системийн зангилаа хэсэг болгон дээр зохицуулалтын болон бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд 100 тэрбум төгрөгт хүрч байсан системийн алдагдлыг тэглэж чадсанд баяр хүргээд, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулахын тулд цахилгааны шөнийн хэрэглээнд эрчим хүчний тарифын дэмжлэг үзүүлж ажиллахыг чиглэл болгосон. Тиймээс энэ талаар Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын албаны дарга Х.Эрдэнэчулуунаас тодруулга авлаа.

-Олон жил алдагдалтай ажилласан эрчим хүчний салбар энэ онд алдагдлаа тэглэж байгаа. Хуримтлагдсан алдагдлын талаар мэдээлэл өгч болох уу?

-Эрчим хүчний салбар 2015 оныг "Хэмнэлтийн жил" болгон зарлаж, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооноос салбарын үр ашгийг дээшлүүлж, өртөг зардлыг бууруулах хамтарсан ажлын хэсэг гарган, эрчим хүч үйлдвэрлэгч, түгээгч, дамжуулагч компаниудын үйл ажиллагаанд шалгалт хийж, хяналт тавьж ажилласан. Үүнээс гадна үнэ тарифын зохистой зохицуулалт, менежментийн зөв арга барилыг хэрэгжүүлж чадсаны үр дүнд олон жилийн турш хуримтлагдсан алдагдлыг тодорхой хэмжээгээр бууруулаад байгаа. Тухайлбал эрчим хүч үйлдвэрлэгч дулааны цахилгаан станцууд дотоод хэрэгцээгээ 0.6 нэгжээр, төвийн бүсийн эрчим хүчний дамжуулалтын алдагдлыг 0.1 нэгжээр, цахилгаан түгээлтийн алдагдлыг 0.5 нэгжээр тус тус бууруулсан. Мөн энэ оны эхний гуравдугаар улирлын байдлаар эрчим хүчний салбарын зардлын өсөлт 9.4 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20 гаруй хувиар буураад байгаа үзүүлэлт юм.

-Эрчим хүчний үнэ тарифын талаар ярихаар энэ салбарын алдагдалтай холбоотой асуудал зайлшгүй сөхөгдөж гардаг. Тэгвэл энэ удаа гэр хорооллын иргэдийн цахилгааны шөнийн тарифыг хөнгөлөх боломжтой гэж үзэж болох уу?

-Салбар их хэмжээний алдагдалтай ажиллаж байгаа нөхцөлд цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт үзүүлэх боломжгүй байдаг. Харин 2015 оны эхний гурван улирлын байдлаар эрчим хүчний салбарын алдагдал буурч байгаа учраас гэр хорооллын айл өрхүүдийн шөнийн цахилгааны тарифт хөнгөлөлт үзүүлэх боломжийг урьдчилсан байдлаар тооцоод байна. Энэ нь агаарын бохирдлыг бууруулахад зохих хувь нэмэр оруулахаас гадна, шөнийн бага ачаалал тодорхой хэмжээгээр нэмэгдэж эрчим хүчний систем технологи ажиллагааны хувьд үр ашигтай ажиллахад эерэг нөлөөлөл үзүүлэх үр дүнг бас харгалзан үзэж байгааг тодруулах хэрэгтэй. Үүнээс гадна хэрэглэгчдэд ч ээлтэй шийдвэр гарна. Энэ асуудлыг хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны хурлаар ойрын хугацаанд хэлэлцэж, шийдвэрлэнэ.

-Энэ хөнгөлөлтөд нийт хичнээн айл өрх хамрагдах боломжтой вэ?

-Өнөөдөр гэр хорооллын иргэд шөнийн цагаар хэрэглэсэн нэг кВт цаг цахилгааныхаа төлбөрт 77.10 төгрөг төлж байгаа. Хэрвээ энэ шийдвэр гарвал 50 хувийн хөнгөлттэй үнэ буюу 38.55 төгрөгөөр эрчим хүч хэрэглэх боломжтой болох юм. Урьдчилсан тооцоогоор цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтөд төвийн бүсийн нэгдсэн сүлжээний гэр хорооллын 280 гаруй мянган айл өрх хамрагдаж, хүйтний улиралд буюу энэ оны 12 сар, ирэх оны 1,2, 3 сар хүртэл оройн 21 цагаас өглөөний 06 цаг хүртэл хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50 хувиар хөнгөлүүлэх боломжтой болно. Энэ шийдвэр гарснаар хэрэглэгчдийн халаасанд нийт 5.2 тэрбум үлдэх юм.



“ТАВАН-ӨНДӨР” ХХК 10 НАС ХҮРЛЭЭ

Монгол улс социалист нийгмээс салаад удаагүй байсан тэр шилжилтийн үеийн он жилүүдэд дэлхийн соёлт ертөнцийн жишиг болсон өндөр барилга, хот байгуулалтад хөрөнгө оруулах зүрх зоригтой байгууллага, хувь хүмүүс ховорхон байсан цаг дор “Бодь” группээс “Голомт хотхон”-ыг бүтээн байгуулсан нь барилгын салбарын үсрэнгүй хөгжлийн шинэ үеийн түүчээ нь байлаа.

Монгол улсын шилдэг аж ахуйн нэгжүүдийн нэг “Бодь” группээс хэрэгжүүлсэн томоохон төслүүдийн тоонд зүй ёсоор орох “Голомт хотхон” болон “Зүүн хүрээ хотхон” орон сууцны цогцолборуудын ашиглалт, үйлчилгээг манай хамт олон хариуцан ажилладаг.



“Голомт хотхон” -2005 оноос “Зүүн хүрээ хотхон” - 2014 оноос ашиглалтанд орсон. Өнөөдөр Нийслэл хотынхоо хамгийн гол төв зам дагуу Энх тайвны өргөн чөлөөний Их тойруутай огтлолцох Баруун болон Зүүн 4 замд хотын төв цэгээс адилхан 2 км зайд сүндэрлэн боссон 16-18 давхар 10 барилгад, 700-гаад айл өрх, 500-гаад авто зогсоол, 50 орчим аж ахуйн нэгж, үйлчилгээний газрууд оршиж байна.



2015 оны 4-р сард ОСНАА Үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшдэг хот болон орон нутгийн, хувийн өмчийн нийт байгууллагуудын санхүүгийн тайланд “ХСУХАТАУ-г зохицуулах зөвлөлөөс” хийсэн хураангуй шинжилгээний дүнгээр “Таван-Өндөр” компани, Ашигтай ажилласан, санхүүгийн хувьд харьцангуй тогтвортой ажилласан аж ахуйн нэгжүүдийн 3-рт орсон нь манай хамт олны үйл ажиллагааны үр дүн, амжилтыг гэрчилж дүгнэсэн байна.

Өнөөдөр “Таван-Өндөр” компанид мэргэжлийн болон үйлчилгээний ажилтан, инженер техникчид, удирдах албан тушаалд 50 гаруй хүн ажиллаж байна.

Тэртээ 2005 оны өвөл Нийслэлийн төв хэсэг Баруун 4 замд тэр үедээ хотны маань орон сууцны хамгийн өндөр барилга газар доор 2 давхар хэсэгтэй хотхоны эхний ээлжийг улсын комисст өгөхөөр “Бодь” группийн удирдлагаас эхлээд “Бодь-Пропертийз” компаний ажилтнууд хотхоныг барьж байгуулсан тэр олон баг, компаниуд, ашиглалтыг цаашид хариуцахаар ажиллаж байсан бидний хэдэн ИТА-ууд цаг мөчтэй уралдан ажиллаж байсан нь саяхан мэт санагдана.

Энэ л цаг үед “Таван-Өндөр” компани “Бодь” группийн бас нэгэн охин компани болон мэндэлснээр 2006 оны нэгдүгээр сараас бие даан үйл ажиллагаа явуулж эхэлсэн түүхтэй билээ.

“Бодь” группийн сүндэрлүүлсэн “Голомт хотхон” нийслэлд өнгө үзэмж, сүр жавхаа нэмэн эрхэмсэг сайхнаар хот дүүргийнхээ төв хэсэгт оршсоор нэг л мэдэхэд 10-н жил болжээ.

Энэ жилүүдэд бид тодорхой мэдлэг, туршлага, арга барилтай болж хамт олон маань мэргэжлийн сайн баг болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Компанийхаа 10 жилийн ойг угтаж хийсэн ажлаас

Оны эхэнд компаний удирдах зөвлөлөөс 2015 онд ойг тэмдэглэх, угтаж хийх ажлын талаар чиглэл гаргасны үндсэн дээр дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:



1. Ажлын байр, өрөө тасалгаануудыг засаж тохижуулсан.
2. Богдхануулын Цэцээгүн оргилд хамт олноороо гарч идэвхтэй эко амралт, цэвэрлэгээ зохион байгуулав.
3. Хамт олноороо эрүүл агаарт гарч Гандан-Уул амралтын газарт архи дарсгүйгээр 1 хоногийн амралт зугаалга, эко цэвэрлэгээ зохион байгуулав.
4. ОСНАА-н салбарын ажилчдын спорт, биеийн тамирын арга хэмжээнд сагсан бөмбөгийн тэмцээнд багаараа оролцсон.
5. ОСНАА-н өдөрт зориулсан нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон.
6. Компаниас 10 хүртэл жил ажилласан зарим хүмүүсийг ОХУ-ын Улаан-Удэ Итгэлт хамбын дацанд аялуулж Байгаль нуурт амруулсан.
7. Байгууллага дотроо ОСНАА-н ажилчдын өдөр болон улсын байр, шинэ жилийг тохиолдуулж ширээний теннис, даам, дартсын төрлөөр тэмцээн зохион байгуулсан.
8. Автогараашид ухаалаг картын системийг нэвтрүүлж, РС дохио гэрэл, урсдаг мэдээллийн самбар, мэдрэгчүүдийг шинээр суурилуулсан.
9. 10 жилийн ойд зориулсан цаг тооны бичигтэй ханын календарийг хэвлүүлсэн.
10. Мөн ойд зориулсан товхимол бэлтгэж хэвлүүлэв.
11. Автогараашийн зам, талбайг цэвэрлэхэд хөдөлмөр хөнгөвчлөх, шал угаах, цэвэрлэх төхөөрөмжтэй болсон.

Хамт олны нийгмийн хариуцлагын талаар

Байгуулагдсан цагаасаа бид нар нийгмийн хариуцлагаа ухамсарлан ажил бизнесийн үйл ажиллагааныхаа нэг хэсэг болгож, нийгмийн сайн сайхны төлөө санаа тавьж ирсэн билээ.

Энэ нь зөвхөн бизнесийн ашгийн төлөө бус, улс нийгэм, байгаль орчинд эерэг бага ч атугай хувь нэмэр чин сэтгэлээсээ сайн дураараа оруулан явж ирсний нотолгоо гэж манайхан бахархаж явдаг. Нэмэр хандив багадахгүй, “Өгье гэвэл ганцаасаа” гэдэг дээ.

Энэрэнгүй сэтгэлийг түгээж нийгэмдээ буян үйлдэхийг эрхэмлэх нь үнэхээр сайхан зүйл мөн. Энэ талаар дурдвал:

1. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэг-Шарга морьтын зусланд Сэлбэ голын гүүрийн зүүн хойт хэсэгт улиасан төгөл 73 ш мод суулгаж тарив. (2007 он)
2. Монгол улсын Морин хуурын чуулгад 2008 оны 07-р сарын 01-нд учирсан хохирлыг нөхөхөд тусламж болгож 2 өдрийн цалингаа хандивлав. (2008 он)
3. 2010 оны 1-р сард байгаль, цаг уурын их хүйтрэл, цас зуд болсны учир хөдөө орон нутгийн малчдад ОБЕГ-аар дамжуулан хамт олны 1 өдрийн цалин болон сайн дурын

хандив 400.000 төгрөгөөр туслав.

4. Хэрлэн Аравт ТББ-ийн санаачилсан Бурхан Халдун Хайрханы өвөрт “ Мод тарьцгаа ” уриалгыг дэмжих 100 ширхэг шинэс мод тарив. (2012 он)
5. НЭПКО хэвлэлийн газраас эрхлэн гаргасан Агнистийн гэгээ-ний 9-р цуврал болох Очир огтлогч номыг хэвлүүлэхэд хамт олноосоо 1 сая төгрөгийг хандивлан номын буяны нөхдийг даган баясацгаав. (2012 он)
6. Үндэсний бүтээн байгуулалт Их Майдар төсөлд хамт олноороо хандив өргөж Майдар бурхан бүтээлгэв. (Серийн дугаар 004721) (2013 он)
7. Ажиа Гэгээн Лувсантүвдэн ламтны хандиваар Цусны эмгэг хавдартай хүүхдийн эмнэлэгийг барьж бүтээх үйлсэд хамт олноосоо 500,000 төгрөгийн өргөл өргөв. Эмнэлэгийн барилгыг хүлээн авах, цэвэрлэгээний ажилд 6 хүн 1 өдөр ажиллаж туслав. (2014 он)
8. Монгол улсын Морин хуурын чуулгын ерөнхий удирдаач Ардын жүжигчин Ц.Батчулуун гуайн эмчилгээнд зориулж хамт олноосоо 1 өдрийн цалин болон сайн дурын хандив 500,000 төгрөг шилжүүлэв. (2015 он)
9. Нобелийн шагналтнууд хүүхдийн номын санд хамт олноороо ном цуглуулж шинэ 78, хуучин 30 ширхэг танин мэдэхүйн чиглэлтэй нийт 108 ном хандив болгов. (2015 он)
10. 25-р суваг телевизээс санаачилсан “Сайн үйлсийн төлөө-1000 төгрөг” хандивын аянд хамт олноороо оролцов. (2015 он)

Хамт олны дотроос хэн нэгэн хэвлэл, мэдээллээс мэдээд хэнд, хаана туслах тухай санал гаргаад бусад нь дэмжээд идэвхтэй оролцдог болсон сайхан уламжлал тогтсонд талархалтай байдаг.

Манайхан “Буяны үйл буцаж эзэндээ үржээд ирдэг, гарсан зүйл эргээд ордог” гэдэгт итгэлтэй байдаг “Сайхан сэтгэлийн үзүүрт тос”, “Өгч чадвал авч бас чаддаг” гэдэг дээ.

Бидний сэтгэл, зүтгэл, гар нийлсэн хамт олноос амжилт бүтээл ундарч, дотоод гадаадын үйллүүлэгч олныхоо итгэлийг хүлээж, ая тухтай амьдралыг нь бүрдүүлж буйгаараа манайхан бахархдаг.

Хотхондоо ая тухтай, амар амгалан сайхан орчинг буй болгосноороо өөрсдөө болон үйллүүлэгч нар маань сэтгэл хангалуун байх болно.

Улмаар үйллүүлэгч нарынхаа итгэл хүндлэлийг хүлээж, амжилт бүтээлийг сэтгэл зүрхээрээ мэдэрсэн тийм хамт олон байхын төлөө бид хичээдэг. Энэ хүндтэй эрхэм үүргээ бид хэрэгжүүлж чадна. Манайхан чаднаа гэж бодож итгэж зүтгэж байгаа.

Сайн сайхан бүхэн дэлгэрч, амжилт бүтээл, аз жаргалаар дүүрэн байх болтугай.

“Таван-Өндөр” компанийн анхны гүйцэтгэх захирал, инженер С.Дагвадорж



“ДАРХАН-УС СУВАГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТҮҮХТ 50 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

“Дархан-Ус суваг” Хувьцаат компанийн үүсч хөгжсөн түүхэн замналауд

Дархан хотын “УС СУВГИЙН ТОВЧОО” /1965-1990 ОН/

БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1965 оны 03 дугаар 17-ны өдрийн 68 дугаар тогтоолоор Дархан хотод Ус сувгийн товчоо байгуулах шийдвэр гарч 1965 оны 09 дүгээр сарын 01-нд Дархан хотын **“Ус сувгийн товчоо”** нэртэйгээр Цэвэр усны анги, Сувагжуулах анги, Засвар цех, Автограж, Цахилгаан диспетчер зэрэг анги салбаруудтай 34 ажлын байрны орон тоотойгоор анх байгуулагдаж Дархан өртөөний суурингийн хүн амыг цэвэр усаар хангадаг хоногт 700м куб ус шахах хүчин чадалтай, уул уурхайн ганц худагтайгаар анхныхаа галыг асаасан түүхтэй.

“УС СУВАГ АШИГЛАЛТЫН ГАЗАР” /1990-2001 ОН/

Дархан хотын ОСНААУГазрын харьяа “Ус сувгийн товчоо” нь 1990 оны 06 дугаар сарын 01-ны өдөр аж ахуйн зохион байгуулалтын хувьд өөрчлөгдөн Дархан хотод харьяалалтай **“Ус Суваг Ашиглалтын Газар”** болон өргөжиж 264,2 сая төгрөгний хөрөнгөтэй болж, үүний 86 хувь нь үндсэн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, дамжуулах байгууламж байсан ба 260 гаруй ажиллагсадтайгаар зах зээлд шилжжээ.

“ДАРХАН РАШААН” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР/2001-2003/

Дархан Уул аймгийн “Ус Суваг Ашиглалтын Газар”-ыг 2001 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор **“Дархан Рашаан”** орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчилж шинэ бүтэц зохион байгуулалтаар ажиллах болсон. Тус ОНӨҮГ-ыг аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр томилогдсон дарга удирдах болж, дэргэд нь даргад зөвлөх эрхтэй Зөвлөл ажиллах болов. Үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн явуулах, сахилга дэг журмыг бэхжүүлэх, хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах, аюулгүй ажиллагааг хангах, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, ажилтнуудын хийсэн ажилд нь тохирсон цалин хөлс олгох, хөдөлмөрийн бүтээмж үйлдвэрлэлийн үр ашиг, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлж ажил олгогч ажилтан хоёрын хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг гэрээгээр зохицуулах “Хөдөлмөрийн дотоод журам” боловсруулан даган мөрдөж ажиллаж ирсэн.

“ДАРХАН УС СУВАГ” ХУВЬЦААТ КОМПАНИ 2015 ОН

“Дархан Ус суваг” Хувьцаат Компани нь Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2003 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 100 төгрөгний нэрлэсэн үнэ бүхий 33.844.314 хувьцаатай, 100 хувь орон нутгийн өмчит хувьцаат компанийн зохион байгуулалтанд орсон. Тус компани нь 3 хэлтэс, 5 албатай, ус шинжилгээний нэгдсэн лаборатори гэсэн бүрэлдэхүүнтэйгээр нийтдээ 263 ажилтан албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Хараа голын эргийн дагуу байралсан цэвэр усны гүний 18 худаг, дамжуулан шахах 2 өргөгч станцад 4 насостай, нийт 16000м3 багтаамжтай усан сан, мөн 215 км урт бохирын ба 223 км цэвэр усны шугам хоолойтой, холболтын болон зангилгаа үзлэгийн 4500 худагтай ажиллаж байна.

Нэгдүгээр өргөгч станц нь хоногт 70.000 м3 усыг олзворлох, төв цэвэрлэх байгууламж нь хоногт 50.000 м3 бохир усыг татан зайлуулан цэвэрлэх төслийн хүчин чадалтай. Төвлөрсөн усан хангамжаар нийт 1300 гаруй аж ахуй нэгж, үйлдвэр аж ахуйн газар, 10 гаруй мянган өрх буюу 30 шахам мянган оршин суугч, гэр хорооллын орон сууцны 20 гаруй мянган өрх буюу 40 гаруй мянган оршин суугч, иргэдэд унд ахуйн стандартын шаардлага бүрэн хангасан цэвэр усаар тасралтгүй найдвартай үйлчилж байна.





Энэхүү түүхэн замналаар жилээс жилд өргөжин тэлж, хөгжин үйл ажиллагаагаа тасралтгүй найдвартай явуулан ирсэн нь улс эх орон, нийгэм эдийн засгийн хөгжил, ахмад үеийнхний минь мэдлэг оюун ухаан, бүтээлч, хөдөлмөрч байдал, хичээл зүтгэлийн үр дүн билээ.

Ойн баярын үйл ажиллагаанд урилгаар салбарын яам болон хот, хөдөө орон нутаг дахь орон сууц нийтийн аж ахуйн салбарын байгууллагууд, орон нутгийн удирдлагууд, харилцагч, хамтран ажиллагч зэрэг 150 гаруй байгууллагуудын 200 гаруй зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж оролцсон юм.

Тус компанид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан 140 гаруй ахмад ажилтнуудаа 10 дугаар сарын 07-ны өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүлэн компанийн үйл ажиллагааны хөгжил дэвшлийн талаар мөн ойн баярыг угтаж аймгийн болон компанийн хүрээнд хийж бүтээсэн олон бүтээлч ажлуудын талаар танилцуулан тэдний үнэтэй сургаалийг сонслоо. Мөн ахмад буурлуудынхаа улс эх орондоо оруулсан гавьяа зүтгэлийг нь үнэлж 10 гаруй хүнийг шагнаж урамшууллаа.



Түүхийн өнгөрсөн үеийг бүтээн байгуулсан ахмад, дунд үе болон тэдний ариун үйлсийг залгамжлан авч яваа хамт олны гэрэл зургийн үзэсгэлэнг аймгийн Залуучууд театрын танхимд 2015 оны 10-р сарын 7-ноос 9-ний хооронд байрлуулан ирсэн зочдод толилуулсан. Нээлтийн үйл ажиллагаанд аймаг хотоос хүрэлцэн ирсэн эрхэм

зочид төлөөлөгчид компанийн ахмадууд, нийт ажилтан албан хаагчид оролцов. Үзэсгэлэнгийн үйл ажиллагааг Дархан-Ус суваг ХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Эрдэнэбаяр албан ёсоор нээж зочид төлөөлөгчдөд хандан 50 жилийн ойн баярын мэнд дэвшүүлж үг хэллээ.



Ойн баярын хурлыг Дархан-Ус суваг ХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Эрдэнэбаяр нээж тус компанийн өмнөх болон одоогийн үйл ажиллагаа, бүтээл байгуулалтын ажлууд, үе үеийн түүхэн он цагийн хөгжил дэвшлийн талаар дурьдаж мөн ирээдүйд хийж бүтээх их ажил үйлсийн талаар илтгэл тавин ойн баярын мэндийг дэвшүүллээ. Мөн Дархан-Уул аймгийн засаг дарга А.Энхболд, ИТХ-н дарга П.Эрдэнэбат, Дархан-Ус суваг ХК-ийн ТУЗ-н дарга Г.Батбаяр нар баяр хүргэж мэндчилгээ дэвшүүлэв.



Тус компанинд олон жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллан улс эх орондоо үнэтэй хувь нэмрээ оруулж буй ажилтнуудын хичээл зүтгэлийг нь өндрөөр үнэлж урамшуулан шагнах ёслолын үйл ажиллагаагаар үргэлжилсэн юм.



Барилгын хөгжлийн төвийн дэд захирал Ч.Отгончулуун баяр хүргэн мэндчилгээ дэвшүүлж компанийн 9 ажилтныг тус төвийн **“БАЯРЫН БИЧИГ”**- ээр шагнаж урамшуулав.

Монголын нийтийн аж ахуйн **“ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН”** цол тэмдгээр 13 ажилтан, Барилга хот байгуулалтын яамны **“ЖУУХ БИЧИГ”**- ээр 8 ажилтан, Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо, мэргэжлийн төрийн бус байгууллагын **“ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”**-өөр 8 ажилтаныг тус тус шагнаж урамшуулав.

Тус шагналуудыг Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо, мэргэжлийн төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүд болох “Дархан-Ус суваг” ХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Эрдэнэбаяр, Төв аймгийн “Төв чандмань” дулааны эрчим хүчний газрын дарга Г.Цогтсайхан, “Эрдэнэт-Ус Дулаан Түгээх Сүлжээ” ОНӨХК-ийн захирал Р.Гантулга нар болон “Дархан-Ус суваг” ХК-ийн ТҮЗ-ийн дарга Г.Батбаяр, Нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны мэргэжилтэн Б.Алтантуул, Ш.Оюунцэцэг нар баяр хүргэн гардуулан өглөө.



ХСУХАТАУЗЗ-ийн **“ХҮНДЭТ ӨРГӨМЖ-ЛӨЛ”**-өөр 2 ажилтан, Дархан-Уул аймгийн **“ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН”**-аар 11 ажилтан, Засаг даргын **“ЖУУХ БИЧИГ”**-ээр 6 ажилтан, Дархан сумын Засаг даргын **“ЖУУХ БИЧИГ”**-ээр 9 ажилтныг тус тус шагнаж урамшуулав.

Мөн МҮЭХ, НАМЗХ, АОЭХ, зэрэг ТББ-ууд, харилцагч, хамтран ажиллагч байгууллагуудын шагналаар ажил хөдөлмөрөөрөө тэргүүлэгч 40 гаруй ажилтан албан хаагчид шагнуулан энгэрээ мялаав.



Орон сууц нийтийн аж ахуйн салбарын мэргэжил, зорилго нэгт байгууллагуудын төлөөллүүд хүрэлцэн ирж баяр хүргэн мэндчилгээ дэвшүүлэн дурсгалын зүйлс гардуулан өглөө. Монгол Улсын гавьяат тамирчин, “Дархан-Ус суваг” ХК-ийн Гадаад харилцааны менежер Х.Цагаанбаатар баяр хүргэж мэндчилгээ дэвшүүлэв.

Баярын хүндэтгэлийн концертын ерөнхий найруулагчаар МУ-ын УГЗ, Буриад Улсын УГЗ, СУИС-ийн хүндэт профессор, Д.Ухнаа ажиллав. Тус концерт нь хүндэтгэл ёслолын бүжгээр эхлэсэн бөгөөд МУГЖ, СТА-ууд мөн компанийн ахмад болон залуу уран бүтээлчид зэрэг нийтдээ 60 гаруй уран бүтээлчид оролцон ая дууны цэнхэр хадаг өргөв.

Төгсгөлд нь “Дархан-Ус суваг” ХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Эрдэнэбаяр төрөлх хотынхоо сүлд дуу болох **“ХАМГИЙН САЙХАН ХОТ”**-ыг дуулсан бөгөөд концертын үйл ажиллагаа ёслол төгөлдөр болж өндөрлөлөө.



Баярын үйл ажиллагаа хүндэтгэлийн хүлээн авалтаар үргэлжилсэн бөгөөд захирал Р.Эрдэнэбаяр болон ТУЗ-ын гишүүд хүрэлцэн ирсэн эрхэм зочид төлөөлөгч нарт “Дархан-Ус суваг” ХК-ийн **“ХҮНДЭТ ТЭМДЭГ”** болон гарын бэлэг гардуулан өглөө.



Бидний урилгыг хүлээн авч хүндэтгэн ирсэн компанийн үе үеийн ахмад ажилтанууд болон нийт ажилтан албан хаагчид, салбарын мэргэжил зорилго нэгт байгууллага хамт олон, орон нутгийн төр захиргаа, харилцагч байгууллагууд та бүхэндээ “Дархан Ус суваг” ХК-ийн түүхт 50 жилийн ойн баярын өдрүүдийг хамтдаа ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлсэнд компанийн нийт хамт олны зүгээс гүнээ талархал илэрхийлье.

“Дархан Ус суваг” ХК





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 1 дүгээр
сарын 11-ний өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг
хэрэгжүүлэх зарим арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын захиалгаар Улаанбаатар хот болон орон нутагт барьж ашиглалтад оруулсан 929 айлын орон сууцыг хавсралтад заасны дагуу төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн 929 айлын орон сууцны барилгыг барихад зарцуулсан зээлийн төлбөрт шаардагдах 52,058,944,500.00 (тавин хоёр тэрбум тавин найман сая есөн зуун дөчин дөрвөн мянга таван зуун) төгрөгийг хянаж тодотгосны үндсэн дээр 2017, 2018, 2019 оны улсын төсвийн төсөлд үе шаттайгаар тусган шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Болор, Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ нарт даалгасугай.

3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан зээлийн төлбөрийг бүрэн төлж барагдуулах хүртэлх хугацаанд зээлийн хүүгийн төлбөрийг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн 929 айлын орон сууцны түрээсийн төлбөрөөс бүрдүүлэхийг Сангийн сайд Б.Болор, “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал А.Гантулга нарт зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Барилга, хот байгуулалтын сайд

З.БАЯНСЭЛЭНГЭ



Засгийн газрын 2016 оны 38 дугаар
тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦНЫ САНД ШИЛЖҮҮЛЭХ
"ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ" ТӨҮГ-ЫН ЗАХИАЛГААР
БАРЬЖ, АШИГЛАЛТАД ОРУУЛСАН
ОРОН СУУЦНЫ ЖАГСААЛТ

№	Байршил	Нийц орон сууцны тоо	Түрээсийн орон сууцны санд шилжүүлэх орон сууцны тоо	Түрээсийн орон сууцны санд шилжүүлэх талбайн хэмжээ м ²	1 м ² талбайн худалдан борлуулах үнэ мян.төг	Нийт үнэ мян.төг
1	Архангай	120	120	5,581.80	1,190.00	6,642,342.00
2	Увс	105	84	3,801.00	1,250.00	4,751,250.00
3	Дархан-Уул	189	83	3,681.00	1,280.00	4,711,680.00
4	Сэлэнгэ, Зүүнхараа	126	90	3,897.45	1,250.00	4,871,812.50
5	Хэнтий	120	96	3,964.32	1,250.00	4,955,400.00
6	Ховд	120	96	3,964.32	1,250.00	4,955,400.00
7	Хэнтий, Бор-Өндөр	20	10	513.90	1,150.00	590,985.00
8	Орон нутгийн дүн	800	579	25,403.79		31,478,869.50
9	Буянт-Ухаа 2	1620	350	15,244.50	1,350.00	20,580,075.00
	Нийт дүн	2420	929	40,648.29		52,058,944.50



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

САНГИЙН ЯАМ, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ,
“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨҮГ-Т


Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлд:

“ХҮИ.ХЭЛЭЛЦСЭН нь: “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов.

2. Төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн 929 айлын орон сууцны өмчлөх эрхийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Болорт даалгав.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцны 1 сарын төлбөрийг орон сууцны нийт талбайн хэмжээ, өрөөний тоог харгалзан нийслэлд 200.0-280.0 мянган төгрөг, орон нутагт 140.0-230.0 мянган төгрөгөөр тогтоох тухай “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын саналыг зүйтэй гэж үзэн, зохих журмын дагуу шийдвэрлэхийг тус корпорацийн ерөнхий захирал А.Гантулгад даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ**

2015 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 227

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.3 дахь хэсэг, "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай" Засгийн газрын 1997 оны 52, 53 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2012 оны 142 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Барилга, хот байгуулалтын салбарын тэргүүний ажилтан болон яамны шагнал олгох журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Шагналд нэр дэвшигчийн анкетын загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Яамны "Хүндэт дэвтэр", "Жуух бичиг" /хавтас, үнэмлэх/ хийлгэх зардлыг яамны төсвөөс, "Тэргүүний барилгачин", "Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг /үнэмлэх, хавтас/ хийлгэх зардлыг "Барилгын хөгжлийн төв" Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газараас, "Газрын харилцааны тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг /хавтас, үнэмлэх/ хийлгэх зардлыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас тус тус гаргаж байхыг холбогдох байгууллагуудын дарга нарт даалгасугай.

3. Энэхүү журмыг 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /М.Болортуяа/-г үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 46 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.




З.БАЯНСЭЛЭНГЭ

Com /d/ tushaal-2015

08 000654



Барилга, хот байгуулалтын сайдын
2015 оны 11 дүгээр сарын 20 ны
өдрийн 227 дугаар тушаалын
Нэгдүгээр хавсралт



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Барилга, хот байгуулалтын салбарыг хөгжүүлэхэд идэвхи зүтгэл, үр бүтээл, ажлын амжилт гаргасан, салбарын бүтээн байгуулалтад тодорхой хувь нэмэр оруулсан ажилтнуудыг Барилга, хот байгуулалтын салбарын шагналаар шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Барилга, хот байгуулалтын салбарын шагналын зорилго нь Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй /инженерийн байгууламж/, газрын харилцааны салбарын ажилтнуудын хөдөлмөр зүтгэл, амжилт, бүтээлийг үнэлэх, тэдний идэвхи санаачлагыг дэмжиж урамшуулахад оршино.

3. Барилга, хот байгуулалтын салбарын шагналыг олгохдоо шагналд нэр дэвшсэн ажилтны ажлын амжилт, бүтээл, тус салбарт ажилласан хугацааг гол шалгуур болгохын зэрэгцээ тухайн ажилтны ажилладаг байгууллагын үйл ажиллагаа, бүтээн байгуулалт, ажлын үр дүнг харгалзан үзэж олгоно.

Хоёр. Шагналын төрөл

2. Барилга, хот байгуулалтын салбарын шагнал нь дараах төрөлтэй байна.

Үүнд:

2.1. Засгийн газрын шагнал:

- 2.1.1. “Тэргүүний барилгачин” хүндэт тэмдэг;
- 2.1.2. “Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;
- 2.1.3. “Газрын харилцааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг;

2.2. Барилга, хот байгуулалтын яамны шагнал:

- 2.2.1. Яамны “Хүндэт дэвтэр”-т бичиж дурсгалын гэрчилгээ олгох;
- 2.2.2. Яамны “Жуух бичиг”.

Гурав. Шагнал олгох ерөнхий нөхцөл

3.1. Барилга, хот байгуулалтын салбарыг хөгжүүлэхэд идэвхи зүтгэл гарган мэргэжлээрээ 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж амжилт бүтээл нь хамт олон, мэргэжлийн хүмүүст үнэлэгдсэн, мэргэжлийн туршлагатай, өндөр чадвартай ажилтныг “Тэргүүний барилгачин” хүндэт тэмдэг, “Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, “Газрын харилцааны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг /цаашид “Салбарын тэргүүний ажилтан” гэх/-ээр шагнана.

3.2. Тус салбарт 20-оос доошгүй жил ажиллаж салбарын хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулан хөдөлмөрийн өндөр амжилт, бүтээл гаргасан удирдах



болон ахмад ажилтны алдар гавьяа, үлгэр дууриаллыг алдаршуулан Барилга, хот байгуулалтын яамны "Хүндэт дэвтэр"-т нэрийг нь бичиж дурсгалын гэрчилгээ олгоно. Барилга, хот байгуулалтын яамны "Хүндэт дэвтэр"-т бичигдэх ажилтан салбарын тэргүүний ажилтан тэмдгээр шагнагдсан байна.

3.3. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй /инженерийн байгууламж/, газрын харилцааны салбарт 8-аас доошгүй жил идэвх санаачлагатай ажиллаж, ажил үйлсээрээ бусдыгаа тэргүүлсэн ажилтнуудыг Барилга, хот байгуулалтын яамны "Жуух бичиг"-ээр шагнана.

3.4. "Салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр дор дурьдсан шалгуур үзүүлэлтийг хангасан ажилтнууд шагнагдана. Үүнд:

3.4.1. Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй /инженерийн байгууламж/, газрын харилцааны салбарт үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлж, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг ханган, өндөр үр ашигтай ажиллуулах, дэвшилтэт техник, технологи эзэмшин нэвтрүүлэх, үйлчилгээний нэр төрөл, хүрээг өргөтгөх, мэргэжлийн ур чадвараа дайчлан шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэл, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд санаачлага гаргаж ажилласан удирдах болон инженер техникийн ажилтан, ажилчид;

3.4.2. ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажиллаж, мэргэжлийн өндөр ур чадвар гарган ажил, үйлчилгээг үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцүүлж чанартай гүйцэтгэн эрхэлсэн ажилдаа өндөр амжилт гарган идэвхи санаачлагатай, техникийн осол, зөрчилгүй ажиллаж байгаа ажилтан, ажилчид;

3.4.3. салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, сургахад бодитой хувь нэмэр оруулсан, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд амжилт, нээлт, бүтээл гаргасан багш, эрдэмтэд;

3.4.4. салбарыг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан төр, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, ахмадууд, гадаадын иргэд;

3.4.5. салбарын ажил, үйлчилгээнд онцгой үр дүн өгөхүйц нээлт, шинэ бүтээл, санал, санаачлага гаргасан, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой шинэ техник, технологи, шилдэг арга ажиллагаа нэвтрүүлсэн ажилтан, иргэд;

3.4.6. үйлдвэрлэлд учирч болохуйц ноцтой аюул ослыг урьдчилан сэргийлж таслан зогсоох арга хэмжээ авсан, түүний хохирол уршгийг арилгах, түүнчлэн нэн төвөгтэй үүрэг, даалгаврыг иргэний зориг гарган гүйцэтгэсэн ажилтан, ажилчид;

3.4.7 улс орны болон салбарын хэмжээний тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой хууль, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажилд тодорхой үүрэг гүйцэтгэсэн ажилтан, албан хаагчид.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.1. "Салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр шагнуулах санаачлагыг өмчийн аливаа хэлбэрийг харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага гаргаж болох бөгөөд ямар нэг байгууллагад харьяалагддаггүй иргэнийг харьяалах баг, хороо тодорхойлж болно.



4.2. Улс төрийн нам, эвсэл болон төрийн бус байгууллага нь гишүүд, идэвхтнээ шагнуулах саналыг тухайн хүний ажиллаж байсан үндсэн байгууллагад гаргана.

4.3. Шагналд нэр дэвшигч нь энэ журмын 3.4-т заасан болзлыг бүрэн хангасан, байна.

4.4. “Салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнуулахаар нэр дэвшигч яамны шагнал буюу “Жуух бичиг” – ээр шагнагдсан байх ба шагнуулснаас хойш 5-аас доошгүй жил тогтвортой ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшингээс ахисан нөхцөлд дараагийн шатны шагналд нэр дэвшүүлнэ.

4.5. Энэхүү журмын 3.4.5, 3.4.6, 3.4.7 хэсэгт заасан үзүүлэлтээр шагнагдах ажилтнуудад ажилласан жил, шагнал хоорондын хугацааг хамааруулахгүй байж болно.

4.6. Шагнуулах иргэдийн материалыг нийтээр тэмдэглэх баяр / Үндэсний Их баяр наадам, Цагаан сар, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баяр / болон салбарын ажилтны өдөр, ой болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө цахим болон цаасан хэлбэрээр Барилга, хот байгуулалтын яаманд ирүүлнэ. Шагналын материалыг хугацаа хожимдуулсан тохиолдолд дараагийн тэмдэглэлт баяр, ойгоор асуудлыг шийдвэрлэх ба энэ журмын 4.7.-д заасан материалыг дутуу ирүүлсэн тохиолдолд үндэслэлийг дурдан тодорхойлолт ирүүлсэн байгууллагад буцаана.

4.7. Барилга, хот байгуулалтын салбарын шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлж буй ажилтны ажил байдлын тодорхойлолтод түүний шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, судалгаа, тооцоогоор баталгаажуулан, бүтээлийн жагсаалтыг хавсаргаж дараах материалын хамт ирүүлнэ. Үүнд:

- 4.7.1. шагнуулах тухай эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэй албан бичиг;
- 4.7.2. шагналд өргөн мэдүүлсэн хүний анкет /Журмын хоёрдугаар хавсралт/;
- 4.7.3. ажил байдлын тодорхойлолт, бүтээлийн жагсаалт;
- 4.7.4. хамт олны хурлын тэмдэглэл;
- 4.7.5. аж ахуйн нэгж, байгууллагын тозч танилцуулга;
- 4.7.6. урьд өмнө шагнагдсан бол шагналын үнэмлэхний хуулбар;
- 4.7.7. онцгой амжилт гаргасан /энэ журмын 3.4.5, 3.4.6, 3.4.7 / бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар.

4.8. Салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнуулахаар ирүүлсэн материалыг холбогдох бодлогын газруудад танилцуулан санал авч, шагнах тухай Барилга, хот байгуулалтын сайдын тушаал гаргаж шийдвэрлүүлнэ.

4.9. Шагнуулахаар ирүүлсэн материалыг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд шагнал олгохгүй.

Тав. Шагналыг шийдвэрлэх, олгох

5.1. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газар шагналын материалыг хүлээн авч, энэ журмын дагуу бодлогын газраас санал авч, шагналын асуудлыг шийдвэрлүүлэх саналаа сайдад танилцуулна.

5.2. Шагнах асуудлыг Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар шийдвэрлэнэ.



5.3. "Салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгийг энэ журмын 3.4 -т заасан шалгуур үзүүлэлтийг хангасан ажилтнуудад салбарын онцлогийг үндэслэн дараах чиглэлээр олгоно. Үүнд:

5.3.1. барилга угсралт, засвар, хот байгуулалт, төлөвлөлт, архитектур, зураг төсөл, барилгын материалын үйлдвэрлэлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллагын ажиллагсад болон энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулдаг, тэдгээрт үйлчилдэг төрийн албан хаагчид, салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг сургуулийн багш, эрдэмтэд, шинжлэх ухааны ажилтан албан хаагчдад "Тэргүүний барилгачин" хүндэт тэмдэг;

5.3.2. орон сууц, нийтийн аж ахуй /инженерийн байгууламж/-н салбарын ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсад, энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулдаг, тэдгээрт үйлчилдэг төрийн албан хаагчид, салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг сургуулийн багш, эрдэмтэд, шинжлэх ухааны ажилтан албан хаагчдад "Нийтийн аж ахуйн тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг;

5.3.3. газрын харилцаа, геодези, зураг зүйн ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагсад, энэ чиглэлээр төрийн бодлого боловсруулдаг, тэдгээрт үйлчилдэг төрийн албан хаагчид, салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэдэг сургуулийн багш, эрдэмтэд, шинжлэх ухааны ажилтан албан хаагчдад "Газрын харилцааны тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг.

5.4. "Салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдгээр шагнахад Засгийн газрын 2012 оны 142 дугаар тогтоолыг үндэслэн 100 000 /нэг зуун мянга/ төгрөг, "Хүндэт дэвтэр"-т бичигдсэн тухай гэрчилгээ олгоход 20000 (хорин мянга) төгрөг, Жуух бичгээр шагнахад 10000 (арван мянга) төгрөгийн дагалдах мөнгөн шагналыг Засгийн газрын 1997 оны 53 дугаар тогтоолыг үндэслэн тухайн ажилтныг шагнуулахаар тодорхойлсон үндсэн байгууллагаас нэг удаа олгоно.

5.5. "Салбарын тэргүүний ажилтан" хүндэт тэмдэг, үнэмлэх, яамны "Жуух бичиг"-ийг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн олгож болно. Нөхөн авахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.


- 5.5.1. Тэмдэг, үнэмлэх нөхөн олгохыг хүссэн өргөдөл;
- 5.5.2. Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 5.5.3. Зохих дансанд тушаасан төлбөрийн баримт.

Зургаа. Бусад

6.1. Салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнагдсан иргэдийн нэгдсэн бүртгэлийг хөтлөх, шагналыг олгох ажлыг яам хариуцна.

6.2. Шагнуулахаар ирүүлсэн материалыг архивын ажлын үндсэн зааврын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивлана.

_____оОо_____



Барилга хот байгуулалтын сайдын
2015 оны 11 дугаар сарын 20-ны
өдрийн 29 дугаар тушаалын
Хөөрдугаар хавсралт

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЛБАРЫН ШАГНАЛД
НЭР ДЭВШҮҮЛЭХ АЖИЛТНЫ ТАНИЛЦУУЛГА**

1. Ургийн овог:
2. Эцэг /эх/-ийн нэр:
3. Өөрийн нэр:
4. Төрсөн он, сар, өдөр:
5. Регистрийн дугаар:
6. Нас, хүйс :
7. Яс үндэс:
8. Үндсэн захиргаа:
9. Боловсрол, мэргэжил эзэмшсэн байдал /он дарааллаар/



№	Төгссөн сургууль	Суралцсан хугацаа	Эзэмшсэн боловсрол, мэргэжил

10. Ажил эрхэлсэн байдал /он дарааллаар/

№	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа /он сараар/	Эрхэлсэн ажил албан тушаал

11. Нийт ажилласан жил:, үүнээс: Тухайн салбарт: жил

12. Шагнагдаж байсан шагналууд /оны дараалал баримтлан бичих бөгөөд шагналын үнэмлэхний хуулбарыг заавал хавсаргана./



№	Шагналын нэр	Шагнагдсан он

13. Шагнуулах үндэслэл. /Товч, тодорхой бичнэ./

.....

14. Ямар шагналд нэр дэвшүүлж буй санал:

15. Хамт олны саналын хувь:

16. Байгууллагын холбоо барих утас, ажилтны нэр:

Танилцуулгыг баталгаажуулсан:

Захирал /дарга, эрхлэгч/...../нэр/ Гарын үсэг

Огноо



**ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН
УС, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙД ТАВИГДАХ НОРМ, ШААРДЛАГА**

Нэг. Унд, ахуйн ус хангамжид тавигдах шаардлага

1.1. Ундны усны хангамжид тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

1.1.1. Ундны ус нь үндэсний стандартын шаардлагыг хангасан байх.

1.1.2. Усны чанар, аюулгүй байдалд жилд 2-оос доошгүй удаа шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах.

1.1.3. Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэртэй байна. Усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг 50 метрээс доошгүй зайд тогтоож, дэглэмийг мөрдөх.

1.1.4. Сургууль, цэцэрлэгт хүүхэд бүр өдөрт 1 литрээс доошгүй ундны цэвэр ус уух боломжоор хангагдсан байх.

1.1.5. Ундны ус зөөх, хадгалах сав нь таглаатай, угааж цэвэрлэхэд хялбар, хүнсний зориулалтын материалаар хийгдсэн, хүүхдийн эрүүл мэндэд эрсдэлгүй байх.

1.1.6. Ундны ус хадгалах савыг 7 хоногт 1-2 удаа бүрэн суллаж, угааж, халдваргүйтгэх.

1.1.7. Сурагчид хувийн аяга болон ундны ус уух савтай байх.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлага

1.1.8. Дотуур байрын сурагч бүр өдөрт 2 литрээс доошгүй ундны ус уух боломжоор хангагдсан байх.

1.2. Ахуйн хэрэглээний ус хангамжид тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

1.2.1. Сурагч бүр хувийн ариун цэвэр сахихад 6-7 литр усны хангамжтай байх

1.2.2. Усаар зайлуулдаг бие засах газартай сургуулийн сурагчид өдөрт 10-15 литр усны хангамжтай байх.

1.2.3. Ил задгай усны эх үүсвэр нь жорлон болон бохир ус, ариутгах татуургын ус зайлуулах хоолойноос хөрсний байдлаас шалтгаалан наад зах нь 30-50 метр хол байх.

1.2.4. Угаалга цэвэрлэгээний ус авах газар нь бага ангийн сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ойр, тохиромжтой, хүртээмжтэй байх.

1.2.5. Угаалга цэвэрлэгээний газар бүрт ус зайлуулах байнгын ажиллагаатай хоолой болон бохир усны цооногтой байх.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлагууд

1.2.6. Хүүхэд бүр гар угаах, усанд орох болон бусад хэрэглээндээ өдөрт 20 литр усны хангамжтай байх.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/253 /251 /173

Улаанбаатар хот

Норм, шаардлага батлах тухай

Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг үндэслэн, ТУШААХ нь:

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлагыг хавсралт ёсоор баталсугай.

2. Норм, шаардлагыг жил бүрийн батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, аймаг, дүүрэг бүрт цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нийтлэг шаардлагыг хангасан загвар орчин байгуулах, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Эрдэнэчимэг), Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ц.Баярхүү), Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр)-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (М.Оюунцэцэг), Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Оюунсүрэн), Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт тус тус даалгасугай.





Хоёр. Ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага

2.1. Ариун цэврийн байгууламжийг төлөвлөх, барихад тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

2.1.1. Нэг ээлжинд хичээллэж буй 30 эмэгтэй хүүхдэд 1 суултуур, 40 эрэгтэй хүүхдэд 1 суултуур + 1 шээлтүүр ногдохоор тооцож байгуулах

2.1.2. Ариун цэврийн өрөө нь хүүхдийн нас, хүйсийн онцлогт тохирсон, хүүхдэд ээлтэй байх.

2.1.3. Эрэгтэй/эмэгтэй хүүхэд болон багш, ажилчдад зориулсан ариун цэврийн өрөө тусдаа байх.

2.1.4. Сургууль болон дотуур байрны ариун цэврийн өрөөнд явган суултуур суурилуулж болно.

2.1.5. Гадна жорлон нь хэрэглэгчээс 30 метрийн дотор байрлах бөгөөд улирлын ямар ч нөхцөлд ашиглагдахуйц байх.

2.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон нэг жорлонтой байх.

2.1.7. Гадна жорлон нь зохих ёсны агааржуулагч, гэрэлтүүлэг, доторлогоо, дотроосоо түгждэг цоожтой, таглаатай хогийн савтай байх.

Цэцэрлэгийн нэмэлт шаардлага

2.1.8. Цэцэрлэг болон бага сургуулийн сурагчдад зориулсан ариун цэврийн өрөөг дотор байгуулах.

2.1.9. Цэцэрлэгийн 15-аас ихгүй хүүхдэд, бага ангийн 30 сурагчдад нэг суултуур тус тус ногдохоор тооцож байгуулах.

2.1.10. Хөтөвч ашигладаг хүүхэд бүр тусдаа хөтөвчтэй байх.

2.1.11. Суултуур, шээлтүүр нь хүүхдийн нас, өндөрт тохирсон хийцтэй, хэрэглэхэд хялбар байх.

Шилжилтийн насны охидод зориулсан нэмэлт шаардлага

2.1.12. Ариун цэврийн хэрэглэл бусад хог хаягдлыг хаях тагтай хогийн савтай байх.

2.1.13. Дотуур байранд охидын хувцсаа угаах, солиход нь зориулсан хаалгатай тусгай угаалгын өрөө байх ба шаардлагатай үед угаалга цэвэрлэгээндээ хэрэглэх цэвэр усаар хангагдсан байх.

2.1.14. Охидын угаалга болон хувцас солих өрөөний хогийн савыг өдөр тутам цэвэрлэж, хаягдлыг аюулгүй зайлуулж байх.

2.2. Ариун цэврийн байгууламжийн ашиглалт ба байнгын ажиллагааг хангах талаар

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

2.2.1. Суултуур/шээлтүүрийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээг цаг тухайд нь хийж, эвдрэл гэмтэлгүй, цэвэр байлгах (муухай үнэргүй, ялаагүй, ил задгай бие засаагүй).

2.2.2. Ариун цэврийн цаас болон цэвэрлэгээний бусад материалыг хүртээмжтэй байлгах.

2.2.3. Ариун цэврийн өрөө нь завсарлага болон хичээлийн үед ч ашиглаж болох байнгын ажиллагаатай байх.

2.2.4. Ариун цэврийн өрөөний хаалга, бариул нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой байх.

2.2.5. Цэвэрлэгээ халдваргүйтгэл тогтмол хийх.

Цэцэрлэгийн нэмэлт шаардлага

2.2.6. Бага насны хүүхдийн хөтөвчийг хэрэглэх бүрт угааж цэвэрлэх, халдваргүйтгэх.



Гурав: Гар угаагуур болон шүршүүрт тавигдах шаардлага

3.1. Гар угаах байгууламж

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

3.1.1. Сургууль: 40 сурагчид нэг гар угаах угаагуур ногдохоор тооцож байгуулах.

3.1.2. Дотуур байр: 30 сурагчид нэг гар угаах угаагуур ногдохоор тооцож байгуулах.

3.1.3. Цэцэрлэг, сургууль, дотуур байранд хүүхдүүд бүлээн усаар гараа угаах нөхцлөөр хангагдсан байх.

3.1.4. Гар угаах угаагуур бүрийн дэргэд саван тогтмол байлгах.

3.1.5. Гар угаах байгууламж нь бага насны сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ойр, тохиромжтой, хүртээмжтэй байх.

3.1.6. Гар угаах угаагуурын хажууд алчуур/гар хатаагч болон таглаатай хогийн сав байрлуулах.

Цэцэрлэгийн нэмэлт шаардлага

3.1.7. Цэцэрлэг: 20-оос ихгүй хүүхдэд нэг гар угаах угаагуур ногдохоор тооцож байгуулах.

3.1.8. Гар угаах угаагуурыг дотор байрлуулах ба халуун, хүйтэн усны холигчтой байх.

3.1.9. Гар угаах угаагуур нь хүүхдийн өндөрт тохирсон байх.

3.1.10. Угаалга цэвэрлэгээний бодис, хэрэглэгдэхүүнийг хүүхдийн гар үл хүрэх түгжээтэй шүүгээнд хадгалах.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлага

3.1.11. Гадна жорлонтой сургуулийн дотуур байрны гар угаах угаагуурыг дотор байгуулах.

3.1.12. Хоолны газрын дэргэд гар угаагуурыг байгуулах.

3.2. Усанд орох онгоц, шүршүүр

Сургуулийн дотуур байрт

3.2.1. Охид, хөвгүүд тус тусдаа усанд орох боломжоор хангагдсан байх.

3.2.2. 20 охид, хөвгүүд тутамд нэг шүршүүр ногдохоор тооцож байгуулах.

3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдэд зориулсан тохиромжтой шүршүүр бүхий өрөө 1-ээс доошгүй байх.

3.2.4. Саванбусад тоног төхөөрөмжөөр хангагдсан угаалгын өрөөтэй байх.

Дөрөв. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн засвар үйлчилгээнд тавигдах шаардлага

Сургууль, дотуур байрт:

4.1. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжид засвар үйлчилгээг хийх төлөвлөгөөтэй, төлөвлөгөөний дагуу засвар үйлчилгээ хийдэг байх.

4.2. Ариун цэврийн байгууламжийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн материал худалдаж авах, ашигласан усны төлбөр төлөх зэрэг бусад шаардлагатай үйлчилгээнд зарцуулах төсөвтэй байх.

4.3. Сургуулийн дотоод болон гадаад орчныг тогтмол цэвэрлэж байх (хог хаягдал, бохир усыг цаг тухайд нь аюулгүй зайлуулах, мөсөн бүрхүүлгүй байлгах).



Тав. Эрүүл ахуйн боловсрол, зан үйлийн өөрчлөлтөд тавигдах шаардлага

5.1. Эрүүл ахуйн боловсрол

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

5.1.1. Эрүүл ахуйн боловсрол нь сургалтын хөтөлбөрийн салшгүй хэсэг байх ба ариун цэврийн өрөөг хэрхэн ашиглах, гар угаах, шүд угаах, хог хаягдал зэрэг агуулгыг багтаасан байх.

5.1.2. Эрүүл ахуйн боловсрол олгоход шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, материал нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, хүртээмжтэй байх.

5.1.3. Сургууль (дотуур байр) бүр ус, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлыг хариуцсан ажилтантай байх.

5.1.4. Эрүүл мэнд болон ус, ариун цэвэр, эрүүл ахуйн клубуудыг сургууль дээр байгуулж, идэвхтэй ажиллуулах.

5.1.5. Эцэг эх, асран хамгаалагчдад ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг байх.

5.1.6. Ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр хичээлээс гадуурх үйл ажиллагаа зохион байгуулах.

5.1.7. Сурагчдын мэдлэг, хандлага, зан үйлийн өөрчлөлтийг хянаж үнэлэх дотоод хяналтын тогтолцоотой байх.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлага

5.1.8. Жендерийн болон нөхөн үржихүйн асуудал нь хичээлээс гадуурхи сургалтын хэсэг байх.

5.1.9. Хүүхдэд эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулах болон үйлчилгээ үзүүлэх өрөөтэй байх.

5.1.10. Сургалтад хамрагдсан ажилтан өсвөр насны охид, хөвгүүдэд бие бялдрын өсөлт хөгжил, бие махбодийн өөрчлөлтийн талаар зөвлөгөө өгдөг байх.

5.1.11. Охидод сарын тэмдгийн хуанли хөтлөх, ариун цэврийг сахих талаар зөвлөж, дэмждэг байх.

5.2. Эрүүл ахуйн дадал, зан үйлийн өөрчлөлт

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

5.2.1. Ил задгай бие засахгүй, хог хаяхгүй байх.

5.2.2. Суултуур/шээлтүүрийг зөв ашигладаг байх.

5.2.3. Гараа савандаж угаах дадал хэвшилд суралцсан байх.

5.2.4. Гараа савандаж угаахын ач холбогдлыг ойлгосноор бусдад зааж сургадаг, сурталчилдаг байх.

5.2.5. Эцэг эхийн зөвлөл нь олон нийттэй хамтран жилд нэгээс доошгүй удаа эрүүл ахуйн талаарх мэдлэг сайжруулах талаар ажил зохион байгуулдаг байх (сургуулийн урлагийн тоглолт, жүжиг гэх мэт).



Зургаа. Гал тогоо болон хоол хүнс боловсруулахад тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

6.1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авах хэсэг, хүнсний бүтээгдэхүүн хадгалах төрөлжсөн агуулах, бэлтгэлийн өрөө, халуун хоол боловсруулах өрөө, гурилан бүтээгдэхүүнээр үйлчилдэг бол нарийн боовны өрөө, халуун хоол олгох хэсэгтэй, технологийн урсгал дамжлагыг баримталсан, гал тогооны хүчин чадалд хүрэлцэхүйц бүрэн ажиллагаатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, багш, ажилчдаас тусдаа хувцас солих өрөө, ариун цэврийн болон шүршүүрийн өрөөтэй байх.

6.2. Гал тогооны өрөөний шал, хана, таазыг ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, өнгө үзэмж сайтай, цэвэрлэхэд хялбар, сайн чанарын материалаар хийж, хортон шавж, бичил биетэн үржихээс хамгаалах өрөө тасалгаанд агааржуулагч, тоног төхөөрөмж бүрд агаар сэлгэлтийн систем байрлуулах бөгөөд гал унтраах хэрэгслүүдийг нүдэнд ил харагдах газарт байрлуулах.

6.3. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэсэг нь сайжруулсан усан хангамжтай, бохир ус зайлуулах цооногтой байх бөгөөд бие засах газар, хог хаягдлын цэг, бохирын эх үүсвэрээс хол байгуулах.

6.4. Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх ундны цэвэр ус нь стандартын шаардлага хангасан, гүний болон тээвэрлэн зөөвөрлөж ирсэн усыг стандартад нийцүүлэн шүүлтүүрт шүүсний дараа хоол хүнсэнд хэрэглэх.

6.5. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдад гар бохирдох бүрт, хүүхдүүдэд хооллохын өмнө гар угаах, ариутгах орчин нөхцөлийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх.

6.6. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрөл бүхий худалдаа, үйлчилгээний байгууллагатай гэрээ хийж сав, баглаа боодол дээрх үйлдвэрлэгчийн нэр хаяг, үйлдвэрлэсэн он сар өдөр, цаг, хадгалах хугацаа, нөхцөл зэргийг шалган авч байх.

6.7. Түргэн гэмтэх түүхий эд, бүтээгдэхүүн /мах, сүү, өндөг г.м-ийг/ зориулалтын хөргөгч, хөргүүртэй агуулахад хадгалах, түүхий болон болсон хоол хүнсийг хооронд нь холих, хамт хадгалахаас зайлсхийх, шууд хэрэглэх бэлэн бүтээгдэхүүн, болгож бэлтгэсэн хоол хүнсийг 2 цагийн дотор олгох, болгож хонуулсан хоолыг хүүхдийн хоолонд дахин ашиглахгүй байх.

6.8. Хүүхдийн аманд орж байгаа бүхий л хоол хүнснээс дээж авах/чихэр, боов, хавчуургатай печень, хоол, шүүс, ундаа, цай/. Олгож буй хоолноос 250-500гр хүртэл, ширхэгийн бүтээгдэхүүн бол хүүхдэд өгч буй хэмжээгээр дээжийг авч 48-72 цаг хадгалж устгана.

6.9. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчид ажлын дүрэмт хувцас (өмсгөл, малгай, хормогч, ажлын гутал өмсөж гарын алчууртай)-аа бүрэн өмсөж, бөгж, бугуйвч, цаг зүүгээгүй, хумс ургуулаагүй, хумсны будаггүй, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд жилд хоёр удаа хамрагдах ба хэрэв халдварт өвчний нян тээгч илэрсэн тохиолдолд эрүүлжүүлэх арга хэмжээ авах, өвчин илэрвэл заавал эмчлүүлэх.

6.10. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэсгийн шал, хана, хаалгыг өдөр бүр цэвэрлэж, цэвэрлэгээг хийж дууссаны дараа ариутгалын бодистой халуун усаар халдваргүйжүүлэн, цэвэрлэгээний багаж хэрэгслийг тусгай байранд хадгалах.

6.11. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэсэн багаж хэрэгсэл, сав суулгыг зориулалтын угаалгын шингэнээр угааж, ариутгах.



6.12. Мэргэжлийн байгууллагаар улирал тутам хортон шавж, мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлтийн ариутгал хийлгэх.

6.13. Хог хаягдлыг шинж чанараар нь зориулалтын таглаатай саванд ангилан цуглуулж, хогийн цооног, хог цуглуулах цэгт хаях.

Долоо. Хатуу хог хаягдал, бохир усыг зайлуулах менежментэд тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

7.1. Ариун цэврийн өрөө бүрт тагтай хогийн сав байрлуулах.

7.2. Сургууль бүр хатуу хог хаягдлыг цуглуулж хаях хогийн цэгтэй байх.

7.3. Сургууль, дотуур байр нь хог хаягдлын цуглуулах, зайлуулах талаар холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөх.

7.4. Сургуулийн хогийн цооног, хог цуглуулах цэг нь сургуулиас болон усны эх үүсвэрээс 100 метр, барилга байгууламжаас 30 метрээс доошгүй зайд байрлах ба хана, хашаагаар тусгаарлагдсан битүүмжлэл сайтай хаалттай байх.

7.6. Хэсгийн цэвэрлэх байгууламжтай тохиолдолд цэвэрлэгдсэн ус нь үндэсний стандартын шаардлагад нийцсэн байх.

7.7. Бохирын цооногтой бол холбогдох дүрэм журамд заасны дагуу бохир усыг соруулан зайлуулах



ТА ӨВЧЛӨӨГҮЙ, ХАРИН ЦАНГАСАН БАЙНА.

УС-ЭРҮҮЛ МЭНД

Цуврал 11

Арван дөрөвдүгээр бүлэг

ТАНЫ ЭРҮҮЛ МЭНДЭД ШААРДЛАГАТАЙ БУСАД БОДИСУУД

Ус, давс, эрдэс бодисууд нь хүний бие махбодыг эрүүл байлгахад нэн чухал байдагтай адил хоол хүнсээр авдаг тэжээлийн бодисууд нь, биеийн тамирын дасгал хөдөлгөөн тогтмол хийж биеийн хэлбэрээ хадгалахад мөн чухал байдаг. Энэ бүлэгт хүнийг эрүүл байлгахад зайлшгүй хэрэгтэй уураг, өөх тос, жимс, ногоо, нарны туяа, биеийн дасгал хөдөлгөөнүүдийн талаар товч авч үзнэ.

УУРАГ

Олон эрдэмтэн, мэргэжилтнүүд хүн кг жиндээ багаар бодоход 1.1-1.4 гр өндөр чанарын уураг өдөр бүр хэрэглэх шаардлагатай гэдэг саналыг дэмждэг. Булчингийн жинг барихын тулд 90 кг жинтэй хүн өдөрт 120 гр уураг хэрэглэнэ гэсэн үг. Ийм хэмжээний уураг хэрэглэхэд бие махбод өөрийн уургийн хэвийн нөөцөө хадгалдаг ба зарим аминхүчлийн нөөцийг багасгадаггүй байна. Хүүхдэд жингийнх нь 450 гр тутамд багаар бодоход 1 гр уураг шаардлагатай. Хоол, хүнсэнд агуулагдах уургийн агууламж эх үүсвэрээсээ хамаараад өөр өөр байдгийг тооцох хэрэгтэй. Тухайлбал: нэг өндөг ойролцоогоор 50 гр байдаг ба ердөө 6 гр цэвэр уураг, 28 гр мах 7 гр, 28 гр хатуу бяслаг 7 гр, 28 гр зөөлөн бяслаг ойролцоогоор 3 гр, 28 гр аарц 5 гр уураг тус тус агуулдаг байна. Хүнсний үйлдвэрлэлийн ажиллах хүчид өндөр шаардлага тавьдаг хөгжилтэй орнуудад хоолны хомсдолын асуудал гардаггүй ба тогтмол хэрэглэх уургийн зөвлөмж хэмжээ өндөр байдаг. Хэдий чинээ амьдралын идэвхитэй хэв маягтай байна төдий чинээ уураг агуулсан хоол хүнс хэрэгтэй байдаг. Эдийн төлжилт, фермент, нейротрансмиттерын боловсруулалтанд нэмэлт уураг хэрэгтэй байдаг. Сүүлийн үед жингээ хасах хөтөлбөрт уургийн өндөр агууламжтай тураах хоолны дэглэм чухал байр суурь эзлэж байна.

СЭТГЭЛ ХЯМРАЛ БА АМИНХҮЧЛҮҮД

Урт хугацааны сэтгэл хямрал нь бие махбодод туйлын хэрэгтэй аминхүчлүүд болох триптофан, тирозин, цистейн, ялангуяа метионины нөөцийг барагдуулдаг талаар би өөрийн нэгэн өгүүлэлдээ нийтлүүлж байсан юм. Бие махбодын үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэхийн тулд эдгээр аминхүчлүүд нь хатуу тогтоосон хэмжээгээр шаардагддаг. Хүний бие махбодод аминхүчил ямар ач холбогдолтойг задлан шинжилж үзэцгээе. Энэ нь бидэнд сэтгэл хямралын үйлчлэлийн механизмыг ойлгоход болон түүний гол илрэлүүдэд анхаарлаа хандуулж сурахад тусална. Хүний бие махбодод 20 төрлийн аминхүчил байх ба тэдгээрээс уураг ялгардаг. Аминхүчлүүд холилдсоны үр дүнд төрөл бүрийн уураг боловсордог. Гаргаж авсан уурагнууд нь хэмжээ, хэлбэрээрээ ялгаатай байдаг. Тэд гурван хэмжээст бүтэцтэй байх ба байнга нугларч, эргэлдэж байдаг. Энэ хөдөлгөөний үед тэд төрөл бүрийн ирмэгээр эргэлддэг ба химийн тодорхой түншүүдэд татагддаг. Бие биетэйгээ нийлэх, эсвэл үйлчлэлцэх нь хүссэн урвалыг үүсгэдэг. Энэ урвалын нийт нийлбэр нь газар дээр амьдрал үүсэх эх үндэс болсон. Бидний идэж буй хоол хүнс нь үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгтэй эрчим хүчнээс гадна, уураг боловсруулах түүхий эд болох үндсэн аминхүчлүүдийг бий болгодог. Илүү шингэн уусмалд уураг, ферментүүд нь чөлөөтэй хөдөлж, эргэдэг ба энэ нь түүнтэй харилцан үйлчлэлцэх химийн түншээ хайх ажлын үр дүнг нэмэгдүүлдэг. Үүнээс харахад усгүйжилт нь байгалийн энэ урвалыг удаашруулах, хэсгийн мэдрэхүйгээ алдах шалтгаан болдог. Хүний бие махбод 20 аминхүчлийн 12-ыг нь боловсруулдаг ба зайлшгүй хэрэгтэй уураг, нейротрансмиттерыг боловсруулах чадвартай болохын тулд үлдсэн 8-ыг нь гаднаас авдаг. Энэ "импорт"-оор авч байгаа бодисыг эссенциалын буюу орлуулдаггүй аминхүчлүүд гэж нэрлэдэг. Хүрэлцэх хэмжээний эдгээр аминхүчилгүйгээр





бие махбод үйл ажиллагаа явуулж чадахгүй. Дангаараа аминхүчлийн нэн чухал хэрэгцээ нь юу ч илэрхийлэхгүй бөгөөд бид түүгээр өөрийн бие махбодоо бүхий л арга хэмжээ аван ачаалдаг. Ийм харьцаа аюултай. Аминхүчил шингээх хурд нь бусад аминхүчлүүдийн тэнцвэртэй хэмжээнээс хамаардаг.

Илүүдэл аминхүчил нь сүйтгэх үр дагавартай ба бусад аминхүчлийн бодисын солилцооны хурдыг алдагдуулдаг. Иймээс бэлэн аминхүчил худалдаж авахдаа болгоомжтой байх хэрэгтэй. Орлуулдаггүй амин хүчлүүдэд изолейцин, лейцин, лизин, метионин, фенилаланин, треонин, триптофан ба валин ордог. Хэдийгээр тирозин фенилаланинаас, цистеин метионинаас нийлэгждэг ч тирозин, цистеиныг мөн орлуулдаггүй аминхүчилд оруулдаг. Залуу болон ахимаг насанд аргинин, гистидины боловсруулалтын хурд хязгаарлагддаг учраас эдгээрийг мөн орлуулдаггүй аминхүчлүүдэд хамааруулдаг. Ингээд 12 орлуулдаггүй аминхүчлийг бие махбод өөрийн хэвийн үйл ажиллагаагаа баталгаажуулахын тулд хөгжлийнхөө төрөл бүрийн шатуудад гаднаас авдаг. Сэтгэл хямрал болон архаг усгүйжилтийн үед метаболизмыг алдагдуулдаг хэд хэдэн зүйлүүдийг тайлбарлахын тулд тэдгээрийн заримыг нь авч үзье. Триптофан-халуунд маш мэдрэг, орлуулдаггүй аминхүчил. Биеийн хэм бага зэрэг нэмэгдэхэд триптофаны молекулууд илүү хурдан эргэлдэж эхэлдэг. Биеийн хэмийг нэмэгдүүлдэг усанд тэд хариу үйлдэл үзүүлж байгаа юм шиг байдаг. Бие махбод дах усны хэмжээ ихсэхэд ялангуяа ус биед дулаан ялгаруулахаар эсийн бүрхүүлд усны цахилгаан эрчим хүчийг ажиллуулахад триптофаны зарим үйл ажиллагаа гүйцэтгэх үр дүн нэмэгддэг. Тархины цусны судасны ханаар триптофан орох механизм их төвөгтэй байдаг. Тархины цусан хангамжийн саадын гаднах цусны шингэрүүлсэн нэгдэл нь триптофаныг тархины дотор түүний идэвхлийн төвд оруулахад үнэлж баршгүй их тус хүргэдэг. Триптофан нь нейротрансмиттер болох серотонин, түүний туслах триптамин, мелатониныг боловсруулахад түүхий эд болдог. Үүнээс гадна, триптофан нь ДНХ-ийн бүтцийн гэмтлийг таньж, сэргээн засахад чухал үүрэгтэй. ДНХ нэг амьд бодисоос нөгөөд шилжиж, амьдралын нөхөн үржлийн гол үндсэн материал болдог. Эсийн нөхөн үржлийн нууц нь ДНХ-д хадгалагддаг. Түүнийг нөхөн үржүүлэх нарийн ажиллагаа нь салбар эс эсвэл хүүхдийн эрхтний үүсэх хөгжилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Хорт хавдарын эс нь шинэ төрлийн эсэд алдаатай зөөгдсөн салбар эс гэж би бодож байна. Учир нь ДНХ-ийн тогтолцооны сэргээлт нь триптофаны механизм эвдрэхэд тасалдаж эхэлдэг. Дэлхийд нэртэй хорт хавдар судлаач доктор Джавед Икбал миний энэ үзлийн шинжлэх ухааны тайлбарыг судалсан. Урт хугацааны судалгааны үр дүнд тэрээр миний үзлийг хүлээн зөвшөөрч, олон өгүүлэл нийтлүүснийг www.watercure.com сайтаас олж уншиж болно. Одоо

үед триптофан нь лизины хоёр молекултай нэгдэж ДНХ-ийн цувуур угсарахад чанар шалгагч шиг үйлчилдэг фермент үүсгэдэг нь тогтоогдсон. Буруу бүрэлдсэн ДНХ-ийн хэсгийг задлах, засах үүргийг триптофаны нэгдлийн фермент хариуцдаг болох нь харагдаж байна. Тархины хувьд триптофан төрөл бүрийн нейротрансмиттерүүдэд дахин үүсэхдээ тархины цусан хангамжийн тогтолцоонд орох хэрэгтэй байдаг. Хүний бие махбодын бараг бүх асуудлууд триптофанаас нейротрансмиттерыг гарган авч ашигладаг тархины төвд түүний нэвтэрч орох хурд удааширнаас үүсдэг болох нь судалгаагаар батлагдсан юм. Би судалгаагаараа бие махбод дах усны агууламжийн түвшин, тархины цусан хангамжийн саадын дундуур триптофан өнгөрөх хурд хоёр хоорондоо шууд хамааралтай байгааг баталсан. Усгүйжилт нь саадын дундуур өнгөрөх триптофаны хэмжээг багасгадаг. Тархинд орох түүний түвшин нь өвдөлт мэдрэх эрчмийг тодорхойлдог. Хэдийчинээ бага триптофан байна, төдий чинээ өвдөлт эрчимтэй мэдрэгддэг. Триптофан тархинд орох нь нэмэгдэхэд бүрэн алга болох хүртэл өвдөлт сулардаг. Цангах дохио, усгүйжилтийн дүнд үүссэн өвдөлтийн хоорондын холбоо нь тархинд триптофан орох хурд буурсныг харуулдаг. Энэ нь байгаа усыг хуваарилах босго хэтэрсэн, архаг усгүйжилтэд дассан усгүйжилтийн үеийн өвдөлтийг бүртгэх механизмыг тайлбарладаг. Сэтгэл хямралаар үүссэн усгүйжилт нь бие махбодын нөөцөөс суллагдсан триптофаны чөлөөт хэлбэрийн хэмжээг ихэсгэдэг. Элгэнд чөлөөт триптофаны түвшинг хэмжих тогтолцоо байдаг. Тодорхой хэмжээнд хүрэхэд элэг триптофаныг боловсруулж, устгаж эхэлдэг, үүний дараа завсарын бүтээгдэхүүнийг гадагшлуулдаг. Энэ нь орлуулдаггүй аминхүчлээс салах харгис арга. Ус дутагдалтай үед чөлөөт триптофан нь хортой хаягдлыг угаахад цэвэрлэгч бодис шиг ашиглагддаг болохоор энэ нь хэрэгтэй байдаг. Гэвч ийм тохиолдолд сэтгэл хямралаар үүссэн триптофаны задрал нь энэ чухал аминхүчлийн нөөцийг багасгадаг байна. Сэтгэл хямралын үе дэх ийм үзэгдлийг арилгахын тулд яаралтай их хэмжээгээр ус ууж эхлэх хэрэгтэй. Ийнхүү усгүйжилт нь сэтгэл хямрал үүсгэж, олон өвчний явцыг хурдасгадаг байна. Триптофан нүдний солонгон бүрхүүлийн өнгийг бүрдүүлэхэд оролцдог. Мөн торлогийг гэмтээх чадвартай хэт ягаан туяа, эрчимтэй гэрлийн эсрэг шүүлтүүр болж үйлчилдэг. Триптофаны бас нэг чухал зүйл нь булчингийн хөдөлгөөнтэй холбоотой бодисын солилцооны механизмд үйлчилдэг явдал юм. Биеийн том булчингууд 20 аминхүчлээс валин, лейцин, изолейцин гэсэн гинжин салбартай 3 аминхүчлийг идэвхитэй өөрчлөн хувиргадаг. Үүний зэрэгцээ биеийн дасгал хөдөлгөөн, том булчингийн жингийн хөдөлгөөний үед энэ аминхүчлүүд нь өөрт агуулагдах эрчим хүчиндээ ашиглагддаг. Үүнээс гадна, тэд тархины цусан хангамжийн саадыг



өнгөрөх, тархинд нэвтрэх хурдаараа триптофантай уралддаг. Триптофаныг тархинд ортол тэд тайвширдаггүй. Өдөрт нэг цаг алхах ямар чухал байдгийг үнэлэх боломжгүй юм. Триптофаны энэ өрсөлдөгчдийг булчингийн эдээр шатааснаар бие махбодын сайн зохицуулагдсан физиологид хүрч болно. Тирозин нь бие махбодод нэн чухал хоёрдах аминхүчил. Хөдөлгөөний идэвхитэй холбоотой бие махбодын үйл ажиллагааг зохицуулдаг адреналин, ноадреналин нейротрансмиттерүүдийг боловсруулахад анхны материал болдог. Үүнээс гадна, тирозин нейротрансмиттер допамин, бамбайн булчирхайн даавар, арьсны нөсөө меланиныг боловсруулахад хэрэгтэй байдаг.

Үүний зэрэгцээ энэ аминхүчил нь инсулины хүлээн авагч зэрэг зарим чухал уургийг бий болгоход гол үүрэгтэй байдаг. Сэтгэл хямралын үед тирозиныг задалдаг фермент их идэвхитэй болдог. Тирозин боловсрохоос илүү хурдан түүний нөөцийг багасгах боломжийг энэ ферментэд олгох нь зарим чухал үйл ажиллагаануудыг гэмтээхэд хүргэдэг. Бие махбод усгүйжсэн болон сэтгэл хямралд ороход тирозин, триптофаны эвдрэх хурд ихэсдэг байна.

САЙН ЧАНАРЫН УУРГУУДЫН ЭХ ҮҮСВЭЭ

Сайн чанарын уураг нь өндөг, сүү, буурцагт ургамалд байдаг. Улаан вандуй, алтлаг шош зэрэг буурцагт ургамлын 24% нь сайн чанарын уургаас тогтдог. Уураг нь мөн хүнсний ногоонд, шинэ цацагт хяруул, тахиа, тугал, үхэр, гахай, загасны маханд агуулагддаг. “Шинэ” гэж тодотгож байгаагийн учир нь амьтны мах нь уургийн найрлага дах зарим чухал аминхүчлүүдийг хурдан устгадаг төрөл бүрийн ферментүүдийг агуулж байдаг. Хүчилтөрөгчийн удаан хугацааны үйлчлэл нь махны уурагт агуулагдах зарим аминхүчлүүдийг устгаж, сайн чанарын өөхийг ашиггүй, хуршсан болгодог. Хүнсний нэмэлт хэлбэрээр зарим аминхүчлүүдийг хэрэглэхдээ анхааралтай байх хэрэгтэй. Эдгээрийн зарим нь хүний бие махбодын витамин, эрдэс бодисуудын тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлдөг. Өндөг нь эрүүл, тэжээллэг хүнсний бүтээгдэхүүн юм. Ойролцоогоор өндөг 50 гр жинтэй ба 80 калорийн илчлэгтэй байдаг. Өндөгний уураг ойролцоогоор 33 гр, харин өндөгний шар нь 17 гр байдаг. Өндөгнд карбонат, эслэг байдаггүй бөгөөд хамгийн өндөр чанарын уураг ойролцоогоор 6 гр агуулагддаг. Өндөгний уургийн агууламж аминхүчлийн найрлагаар тэнцвэржсэн байдаг. Өндөг нь биотин зэрэг витамин, селен, фосфор, зэс гэх мэтийн эрдэс бодисоор баялаг байдаг. Өндөгний шар нь исэлдэлтийн эсрэг хүхрийн баялаг эх үүсвэр ба хүхэр нь хүний эрүүл мэндэд ашигтай нэн чухал элемент болох нь саяхан хүлээн зөвшөөрөгдсөн. Ойролцоогоор өндөгний 10% нь липид болон өөх тосноос бүрддэг байна. Өндөгний шарын липид онцгой найрлагатай. Өндөгний шард нейротрансмиттер ацетилхолиныг боловсруулах

түүхий эд лецитин, тархины үйл ажиллагааг дэмжих өөх тос докозагексаены хүчил их байдаг. Энэ хүчил нь тархины эсийн бүрхүүл, эс бие биетэйгээ шүргэлцэх цэг байнга төлжихөд нэн чухал байдаг. Нүдний мэдрэлийн бүтэц хараа сайжруулах, өнгө ялгахын тулд докозагексаены хүчлийг их хэмжээгээр ашигладаг. Өндөгнөөс гадна, хойт өргөрөгийн загас, замагт докозагексаены хүчил илэрсэн байна. Хоолны орцонд их хэмжээний өндөг агуулагдах нь холестеринны түвшинд сөргөөр нөлөөлдөггүй байна. Настайвтар нэгэн эр олон жилийн турш өдөрт 24 ширхэг өндөг иддэг байсан ба холестеринны хэмжээ нэмэгдэж байгаагүй нь анагаах ухаанд нэрд гарсан тохиолдол юм.

Зүрх судасны өвчний шалтгаан нь “муу холестрин” гэж үздэг хүнтэй таарвал түүнээс “Венийн судаснаас авсан цусны шинжилгээгээр холестеринны түвшинг тодорхойлдог нь худлаа гэж үү?” гэж асууж үзээрэй. Холестеринны түвшин үнэхээр цусны удаан урсгалаар холестеринны хуримтлал үүсгэж, судсанд товруу үүсэх, цусны судасны түгжрэл үүсэх шалтгаан болдог байсан бол хүмүүст венийн судасны түгжрэлийн тохиолдол их ажиглагдах байсан. Холестеринны хуримтлалаас венийн судас бөглөрсөн тухай судалгааны нэг ч мэдээлэл байхгүй байгаа нь түүнийг зүрх судасны өвчин үүсгэдэг гэж үзэх нь буруу бөгөөд шинжлэх ухааны үндэслэлгүй байгааг харуулж байна.

Тархи, зүрхний артерийн судсанд, мөн бие махбодын гол артерийн судасны дотор хананд яагаад холестеринны хуримтлал үүсдэгийг дахин тайлбарлая. “Усгүйжилт” гэсэн нэр томъёо нь артерийн судасны доторх бүрхүүлийн эсээс ус сордог өтгөн, хүчиллэг цусанд хамаардаг гэдгийг санаж байгаа байх. Энэ үед цусны хурдан хөдөлгөөн нь өтгөн цусны байнгын хортой үйлчлэлээр гэмтсэн, усаа алдаж тамирдсан артерийн судасны доторх ханыг бүрхсэн эмзэг эсүүдэд маш жижиг зураас гаргадаг. Холестерин олон үйл ажиллагаануудын нэг нь артерийн судасны эсийн бүрхүүлийн гэмтсэн хэсэг төлжиж дуусах хүртэл ус нэвтрүүлдэггүй өвөрмөц бүрхүүл бий болгодог. Холестерин нь артерийн судасны дотор ханыг хуурах, хагарахаас хамгаалсан ус нэвтэрдэггүй өвөрмөц бүрхүүл болж үйлчилдэг. Энэ үйл ажиллагаа нь бие махбод байнгын усгүйжилтийн үр дүнд их гэмтсэн үед хүний амь насыг аврахад чиглэгдсэн байдаг. Зүрхний өвчнөөр нас барсан хүмүүсийн тоо, цусан дах холестеринны түвшингийн бүх статистик нь миний үзэж байгаагаар усгүйжилт үхлийн аюултайгаас гадна, цусан дах холестеринны түвшинг нэмэгдүүлдэг болохыг харуулж байна. Бие махбод





дах холестеринны өөр нэг нэн чухал үйл ажиллагааг дараа нь үзнэ. Холестеринны үүргийн талаарх шинэ ойлголтод тулгуурлан өндөг нь хүний бие махбодын хүнсний хэрэгцээг хангах хамгийн сайн эх үүсвэр гэж би эргэлт буцалтгүй зөвлөх байна.

СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН

Сүүн бүтээгдэхүүнийг сайн шингээж чаддаг хүмүүст чихэрлэг амтгүй йогурт нь сайн чанарын уургийн эх үүсвэр болдог. Йогурт олон төрлийн витамин, ашигтай бактерийг агуулдаг ба эрүүл биеийн хоол боловсруулах замыг дэмжиж, хортой бактер, Candida зэрэг хортой мөөгний ургалтыг зогсооход тусалдаг. Сүүн бүтээгдэхүүний харшилтай хүн хоолны орцонд йогурт оруулах хэрэггүй. Бялаг нь мөн уургийн сайн эх үүсвэр. Шинэ бялаг амархан шингэдэг ба хадгалсан бялагаас илүү ач холбогдолтой. Зарим хүмүүс үнээний сүүг шингээхдээ муу байдаг. Ийм нөхцөлд хамгийн сайн арга нь түүнийг буурцагны сүүгээр орлуулах явдал юм. Хэрэв танд буурцагны сүү таалагдахгүй байвал түүнийг луувангийн шүүстэй хольж хэрэглэж болно. Ингэснээр та нэмэлт витамин, тэжээлийн бодис авна. Ийм коктейль амттай бөгөөд биед ашиг тустай байдаг.

ОРЛУУЛДАГҮЙ ӨӨХ ТОС

Өөх- хоол тэжээлийн орцны туйлын чухал нэмэлт. Өөх, тосны найрлаганд ордог зарим нэн чухал өөхний хүчлүүд эсийн бүрхүүлийг боловсруулахад гол түүхий эд болдог. Үүнээс гадна, тэд олон даавруудын гол найрлага болдог. Бэлгийн даавар боловсрох нь бие махбод дах холестерин зэрэг тодорхой өөх тоснуудаас хамаардаг байна. Байнга ашиглагдаж байдаг мэдрэлийн төгсгөлүүдийг нөхөн сэргээхэд "сайн" өөх мэдрэлийн эсэд хэрэгтэй. Нэн чухал тоснуудын тоонд омега-6 -поли -ханаагүй өөхний хүчил буюу линолевийн хүчил, омега-3, супер- ханаагүй өөхний хүчил буюу альфа-линолевийн хүчил ордог. Энэ өөхний хүчлүүд нь масел хэлбэрээр оршдог. Бидний бие махбод эдгээр орлуулдаггүй өөхний хүчлүүдийг боловсруулдаггүй бөгөөд тэдгээрийг хоол тэжээлээр авах шаардлага гардаг. Хүнд өдөрт дунджаар 6-9 гр линолевийн хүчил ба 2-9 гр альфа-линолевийн хүчил хэрэгтэй байдаг (омега-3). Энэ хүчлүүд нь ялангуяа тархины эс, түүний урт сэртэнд нэн хэрэгтэй. Урт сэртэн нь мэдрэл дамжуулах зай, хурдад нөлөөлж болохуйц ямар нэгэн саадыг арилгах, нэвтрүүлэхгүй байх ёстой тусгаарлагч бүрхүүлийг боловсруулдаг.

Нүд хурц хараа, юмсыг ялгаж танихад оролцдог нүдний торлог бүрхэвч дэх мэдрэлийн төгсгөлүүд нь энэ орлуулдаггүй амин хүчлүүдийг, ялангуяа докозагексаены хүчлийг эрчимтэй ашигладаг байна. Докозагексаены хүчил нь өөхний хүчил омега-3-аас нийлэгждэг ба тархины эсийн биохимийн найрлагад нэн чухал үүрэгтэй.

Судалгаагаар мэдрэлийн гаралтай сэтгэл хямралтай хүмүүст ихэнхдээ докогексаены хүчлийн дутагдал ажиглагддаг байна. Өндөг, хойт өргөрөгийн загас, замаг нь докогексаены хүчлийн баялаг эх үүсвэр болох талаар дээр дурдсан. Өөхний хүчил омега-3 ба омега-6 нь 3:1 гэсэн төгс харьцаагаар агуулагдах өөр нэг эх үүсвэр нь гэрэл орохгүй хар саванд, хүйтэн аргаар шахсан боловсруулсан маалингын тос юм. Усан үзмийн тос нь үүнтэй төстэй бүрэлдэхүүнтэй. Гүнжидийн тос мөн ханаагүй шинж чанартай байдаг. Ургамлын тос нь зарим орлуулдаггүй өөхний хүчлийн сайн эх үүсвэр болдог. Ургамлын тос нь хатуу өөхнөөс илүү сайн бөгөөд биеийн хэвийн нөхцөлд шингэн төлөвтэй байдаг ба наалдамхай өөхөнд хувирдаггүй. Орлуулдаггүй өөхний хүчлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл доктор Удо Эрасмусын "Анагаадаг болон үхүүлдэг өөх" гэсэн түүний номыг уншихыг зөвлөж байна (Dr.Udo Erasmus, Fats That Heal, Fats That Kill). Энэ сэдвээр бас өөр нэг сонирхолтой ном бол доктор Майкл А. Шмидтын "Ухаалаг өөх" юм (Dr. Michael A. Schmidt, Smart Fats). Үүнээс гадна, витамин, эрдэс бодисуудын талаар миний бодлоор маш их ашигтай мэдээлэл агуулсан ном бол Дениз Мортимерын "Витамин ба эрдэс бодисын талаарх бүрэн зурагт лавлах" юм.

Цөцгийн тос нь витамин К, А, Е, лецитин, фолийн хүчил зэрэг өөхөнд уусдаг олон витамин баялаг эх үүсвэр. Үүнээс гадна, цөцгийн тос кальци, фосфорыг ихээр агуулдаг. Хоолны орцонд тодорхой хэмжээний өөх байх нь бие махбодод хэрэгтэй. Урт наслахыг хүсэж байгаа бол өөхний хэрэглээнээс татгалзаж болохгүй. Эсийн бүрхүүлийн тусгаарлагчийг үйлдвэрлэхэд хэрэгтэй тусгай өөхнүүдийг бие махбод боловсруулах чадваргүй байдаг. Бие махбод нь хэрэгтэй зүйлийг нь өгөхгүй үед хоолны орцны нүүрс уснаас шаардлагатай зүйлээ боловсруулахыг оролддог. Гэвч бие махбод орлуулдаггүй өөхийг бүрдүүлэх үйл явцыг дуусгах чадваргүй бөгөөд боловсроогүй бүтээгдэхүүнийг бие махбод хураахыг шаарддаг. Үүний улмаас зарим хүмүүс өөхөлж таргалдаг. Хэрэв та жингээ хасахыг хүсэж байгаа бол таны хоолны орцонд ямар нэгэн хэмжээгээр өөх байх шаардлагатай. Грамм өөх бүр биед есөн калорий эрчим хүч өгдөг. Сүүлийн үеийн судалгаагаар тураах хоолны дэглэм нь хүрэлцээтэй хэмжээний өөх агуулсан байх хэрэгтэй гэдгийг баталсан байна.

ЖИМС, НОГОО БА НАРНЫ ГЭРЭЛ

Хүнд өдөр бүр жимс, хүнсний ногоо, ногоон ургамал хэрэгтэй байдаг. Эдгээр нь байгалийн гаралтай витамин, эрдэс бодисуудын сайн эх үүсвэр юм. Үүний зэрэгцээ ногоон ургамал нь тархины докогексаены хүчилд хэрэгтэй бета-каротиныг ихээр агуулдаг. Бие махбодын рН-ийн тэнцвэрийг тогтворжуулахад жимс, хүнсний ногоонууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хлорофиллд магни маш их



байдаг. Магни нь цусанд хүчилтөрөгч зөөгч гемоглобин хэрэгтэй байдаг шиг хлорофиллд мөн тийм чухал байдаг. Багтраа, ясны сийрэгжилт, хорт хавдартай хүмүүст нарны гэрэл сайн эм болдог. Нарны туяа арьсан дах холестерин хуримтлалд үйлчилж, түүнийг Д витамин болгож хувиргадаг ба тэр нь ясанд хүүхдийн өсөлтийг дэмждэг кальцийг тогтоон, ясыг хэлбэршүүлдэг. Үүнээс гадна, Д витамин нь гэдэсний замд кальцийн шингэцийг эрчимжүүлдэг. Кальци нь бие махбод дах хүчилд шууд саармагжуулах үйлчлэл үзүүлж, эсийн рН – ийн тэнцвэрийг үр дүнтэй зохицуулж, эцэст нь багтрааны хүндрэлээс салахад тусладаг. Хэрэв та өдөр бүр хүрэлцээтэй хэмжээний ус ууж, зайлшгүй хэрэгтэй давсаа аван, хурц наранд ба цэвэр агаарт бие махбодод ачаалал өгөхөд бие өөрөө тохирох эрчим хүч ашиглан өөрийн уураг, нүүрсус, өөхний хэрэгцээг авч эхэлдэг. Таны уургийн хэрэгцээ нэмэгддэг. Нүүрсусны хэрэгцээ багасч, харин өөх шатаадаг ферментүүд хоолны орцонд агуулагдахаас илүү их өөх хэрэглэж эхэлдэг. Бодисын солилцоонд холестерин хуримтлалыг татан оруулж болохгүй ба энэ нөөцөөс мөн аажмаар салах хэрэгтэй. Артерийн судасыг холестерин хуримтлалаас цэвэрлэх үйл явц хугацаа их зардаг боловч бие махбодод холестерин бөөгнөрөлийг зайлуулахад хэрэгтэй химийн бүх технологи байдаг.

ХОЛЕСТЕРИН БА ЯСНЫ СИЙРЭГЖИЛТ

Холестерин нь бие махбодод зайлшгүй хэрэгтэй гэдгийг та санаж байгаа байх. Бие махбод яагаад түүнийг ердийнхөөс илүү ихийг боловсруулдгийг тайлбарлах хэрэгтэй. Энэ үзэгдлийн талаарх өөрийн олсон олон тайлбаруудын нэгийг зөвлөө. Бие махбодод ус дутагдаж байгаа үед түүнд усны эрчим хүч бага боловсордогтой яг адилаар цахилган станцийн усан сан дүүргэдэг голын усны түвшин багасдаг. Цаг хугацаа өнгөрөхөд цахилгааны бүх үүсгүүрийг хангах ус хүрэлцэхгүй болдог. Бодит байдал дээр усан цахилгаан станцийн хямд эрчим хүч хүрэлцэхгүй болж эхлэхэд нүүрс, мазутыг шатааж эхэлдэг. Хүний бие махбодын ясан дах, эсвэл эсийн доторх кальцийн хуримтлал нь эрчим хүчний хоёрдах оновчтой эх үүсвэр болдог. Усны цахилгаан эрчим хүчний оронд кальцийн хоёр молекул нэгдэхэд үүсэх эрчим хүчийг ашигладаг. Кальцийн атом хосоороо холбогдохдоо АТФ-ын нэг молекулын эрчим хүчийг авдаг. Эсүүд нь хэрэгтэй үедээ задалж, түүнд агуулагдах эрчим хүчийг ашигладаг кальцийн атомын их нөөцтэй байдаг. Энэ үйл явцын нөлөөгөөр түлш шатаахад үүсдэг үнстэй харьцуулахаар их хэмжээний кальцийн чөлөөт атом бий болдог.

Кальцийн үнс (хэрвээ түүнийг ингэж нэрлэж болох бол) амархан дахин боловсордог ба эрчим хүч хангалттай үед кальцийн атом дахин холбогдож, эрчим хүч нөөцөлдөг. Нарны гэрэл-эрчим хүч нь арьсан дах холестерин Д витамин

болгож хувиргадаг. Д витамин нь кальцийг түүний хадгалагдаж, холбогддог эс, ясанд буцаах болон кальцийг дахин татан авах үйл явцыг хариуцдаг. Д витамин молекул эсийн бүрхүүл дэх өөрийн хүлээн авагчид холбогддог, нэгэн зэрэг кальцийн нэг атом эсийн бүрхүүлээр дамжин эсэд нэвтэрч байгаа Д витамин молекулын төгсгөлтэй мөн наалддаг байна. Д витаминтай, эсийн бүрхүүл дэх түүний хүлээн авагчтай холбогдсон кальци нь соронзон гол шиг ажилладаг ба бусад нэн чухал аминхүчил, элементүүдийн бүх гинжин хэлхээ кальцид наалдаж, түүнтэй цуг эсийн дотор татагдан ордог. Ийм маягаар холестерин Д витамин болгон хувиргадаг нарны гэрлийн эрчим хүч нь эсийн тэжээлийн механизмд шууд физиологийн үйлчилгээ үзүүлдэг байна. Кальци эсэд дахин орохдоо түүнд нэн чухал бодисуудыг авчирсан байдаг. Үүний үр дүнд эс метаболизм болон засварын ажлаа гүйцэтгэх материал авдаг. Үүний зэрэгцээ эсэд орж ирсэн нэмэлт эрчим хүч нь кальцийн атомыг холбоход, ирээдүйд ашиглахын тулд кальцийн холбоосд эрчим хүч нөөцөлж хуримтлуулах ээлжит эргэлтэнд ашиглагддаг. Ийм маягаар холестерин нь эрүүл эс, эсийн метаболизмд чухал нөлөө үзүүлдэг байна. Биед холестерин түвшин нэмэгдэхэд түүнийг гүйцэд ашиглах хэрэгтэй. Бие махбодын эсийн ажиллах чадвар, эрчим хүчний хангалт, үйл ажиллагааг нэмэгдүүлж холестерин аль болох Д витамин их гаргаж авахыг хичээх хэрэгтэй. Нарны гэрлийг холестерин түвшинг бууруулахад, яс бүрэлдэх үйл явцыг хурдасгахад ашиглах хэрэгтэй. Энэ нь арьсны хорт хавдар үүсгэхэд хүргэж болох юм гэж зарим нь бодож байж болох юм. Тэгвэл хорт хавдар нь усгүйжих, хөдөлгөөн хомсдох, буруу хооллох зэрэг шалтгаанаас үүсдэг байна. Хорь гаран жил долоо хоногийн 6 өдөр, өдөрт 3 цаг Тегераны үдийн халуун наранд би теннис тоглодог байсан. Надад хорт хавдрын ямар ч хэлбэр бий болоогүй. Зохиомол гэрэлтүүлэгтэй офисын өрөөнд, ширээний ард таны ясны нягт, холестерин түвшин хэвийн болохыг хүлээж сууж болохгүй. Нарны гэрлийн үйлчлэл дор эрчим хүч хувирах механизмыг ойлгодоггүй, энэ гинжин солилцооны төгсгөөгүй үйл явцыг “өвчин” харин нэн чухал элемент холестерин “муу” гэж үзэх мэргэжлийн эмч энэ тохиолдолд танд зөвлөгөө өгөхөөр гарч ирнэ. Сульдаатай хүүхдийг нарны гэрэлд байлгаж гажгийг зассан нь нарыг эмчилгээнд ашигласан анхны тохиолдол юм. Эмчилгээний энэ аргыг нараар эмчлэх буюу “гелиотеапия” гэж нэрлэдэг. Холестерин олон үйл ажиллагаануудыг шинжлэх ухааны үүднээс харахад нас ахих тусам холестерин түвшин аажмаар өсдөг ба ясны нягт аажмаар багасахад түүний элэгнээс ялгарах нь нэмэгддэг гэж би үзэж байна. Нягт багатай, холестерин түвшин нэмэгдэхийг ясны сийрэгжилт болж байгаагийн илэрхий шинж тэмдэг гэж би үзэж байна. Өглөөний наранд байж, бие махбод кальци



шингээхийг нэмэгдүүлэх нь ясны сийрэгжилтийг арилгах байгалийн арга юм.

БИЕЙН ДАСГАЛ ХӨДӨЛГӨӨН

Агаар, ус, давс, хоолны дараа орох амьдралын хамгийн чухал хүчин зүйл бол биеийн дасгал хөдөлгөөн байдаг. Таашаал авч болох бүх зүйлээс биеийн дасгал хөдөлгөөн нь хүний эрүүл мэндэд илүү чухал хэрэгтэй байдаг. Биеийн дасгал хөдөлгөөн нь яагаад өвчингүй, урт, удаан эрүүл байх зайлшгүй нөхцөл болдгийг авч үзье.

- Биеийн дасгал хөдөлгөөн нь судасны тогтолцоог сайжруулж, даралт ихсэлтийг арилгадаг.
- Булчингийн эддэх хялгасан судасыг нээж, цусны урсгалыг артерийн тогтолцоог эсэргүүцэхийг багасгаж, цусан дах сахарын түвшин болон цусны даралтыг хэвийн болгодог.
- Булчинг нэмж, азотын эерэг тэнцвэрийг бий болгон, булчинг түлш болон шатахаас хамгаалдаг.
- Өөх шатаах ферментийн идэвхийг эрчимжүүлж, түүнийг булчингийн үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгтэй эрчим хүч боловсруулахаар явуулдаг.

Дасгал хөдөлгөөнөөр хичээллэх үед булчингийн үйл ажиллагааны эрчим хүчний эх үүсвэр сахарын оронд хуримтлуулсан өөхийг ашигладаг байна. Биеийн дасгал хөдөлгөөн нь ашиглахгүй тохиолдолд хортой үйлчлэл үзүүлэх зарим аминхүчлүүдийг нэмэлт түлш болгож ашиглахыг булчинд шахдаг. Салаалсан гинжтэй аминхүчлүүдийн цусанд агуулагдах түвшин нэмэгдэх нь биеийн хөдөлгөөн багатай хүмүүст илүү тохиолддог ба бусад нэн чухал аминхүчлүүдийн нөөцийг багасгаж, нөхөж барахгүй хохирол учруулдаг. Нейротрансмиттерыг боловсруулахад тархинд байнга хэрэгтэй болдог орлуулдаггүй амин хүчлүүд нь энэ нэн эмзэгүүдийн тоонд багтдаг. Эдгээрээс хоёр хамгийн чухал нь триптофан ба тирозин байдаг. Тархи триптофаныг цусны даралт, сахарын түвшинг зохицуулахыг хариуцдаг сэтгэл гутралын эсрэг үйлчилгээтэй серотонин, мелатонин, триптомин, индоламиныг боловсруулахад ашигладаг. Тирозин нь биеийн төрөл бүрийн ачаалалыг зохицуулахад зайлшгүй хэрэгтэй адреналин, норадреналин, допаминыг боловсруулахад ашиглагддаг байна. Тирозины нөөцийг барагдуулах нь Паркинсоны өвчинд хүргэдэг. Дасгалжуулаагүй булчингийн үйл ажиллагаа нь байнга муудаж байдаг. Биеэс муудсан булчингийн эд ялгарахад цайр, витамин В6-ын нөөц багасаж, тодорхой шатанд хүрэхэд мэдрэлийн төрөл бүрийн хүндрэлүүд, сэтгэл санааны хямралыг үүсгэдэг. Энэ нь булчингийн хатингаршил, арьсны сүрьеэ гэх мэт аутоиммунны өвчин үүсэх шалтгаан болдог.

- Биеийн дасгал хөдөлгөөн нь булчинг нөөцөд их хэмжээний ус байлгахыг шахаж, цусны

судасны бүрхүүлийн доторх эсийг гэмтээж болзошгүй цусны өтгөрөлтийн ихсэлтийг арилгадаг.

- Чихрийн шижинтэй хүмүүсийн сахарын түвшинг багасгаж, инсулин болон бусад бэлдмэлийн хэрэгцээг бууруулдаг.
- Элэгний цусанд эргэлдэж байгаа болон түүнд хуримтлагдсан өөхнөөс сахар боловсруулах үйл явцыг эрчимжүүлдэг.
- Үений хөндийн дотор шилжин хөдөлдөг хоосон орон зай бий болгож, үений хөдөлгөөнийг сайжруулдаг. Вакуумны хүч нь хөндийд ус шингэхэд тусалдаг. Ус үений хөндийд мөгөөрсөн эсэд хэрэгтэй усанд ууссан тэжээлийн бодисыг авчирдаг. Үүнээс гадна, мөгөөрсөн дэх усны агууламж нэмэгдэх нь үений яс бие биенийхээ гадаргуугаар гулсахыг илүү гөлгөр болгох нэмэлт тосолгоог бий болгодог.
- Хөлийн эрэн булчин нь туслах “зүрх”-ний үйл ажиллагаа гүйцэтгэдэг. Бид зогсож болон хөдөлж байх үед булчин агшиж, сулрахад хөлний булчин татах хүчийг давж гардаг. Тэд хөлөнд ирж байсан хялгасан судасны тогтолцоон дах цусыг хөдөлгөдөг. Хөлний булчингийн байнгын агшилт нь татах хүчээр хөлний хялгасан цусны судасыг дээш татдаг. Ийм маягаар хөлний булчин бие махбодын хялгасан судасны тогтолцоонд зүрх шиг нөлөөлдөг. Биеийн дасгал хөдөлгөөний энэ давуу талыг цөөн хүмүүс үнэлдэг. Үүнээс гадна, хөлний булчин нь лимфийн тогтолцоон дах цусны эргэлтийг эрчимжүүлж, хөлний хаванг арилгадаг.
- Ясыг бэхжүүлж, ясны сийрэгжилтийг арилгахад тусалдаг.
- Нэн чухал даавруудын боловсруулалтыг эрчимжүүлж, сексийн идэвхийг дээшлүүлэн, бэлгийн хүсэл сонирхолыг ихэсгэдэг.
- Нэг цагийн явган явалт нь өөх шатаах дааврын идэвхийг бий болгож, энэ нь 12 цагийн турш үйлчилгээтэй байдаг. Өглөө, орой алхах нь энэ дааврыг хоногийн турш идэвхтэй байлгаж, артерийн судасны тогтолцоог холестерин хуримтлалаас цэвэрлэхэд туслан, бие махбодыг илүүдэл өөхний нөөцөөс салгадаг.
- Адреналинаас хамааралтай симпатик мэдрэлийн тогтолцооны идэвхийг нэмэгдүүлдэг. Үүнээс гадна, адреналин гистамины боловсруулалтанд саад болж, бие усжих нөхцөлд байхад харшил, багтрааг арилгахад тусалдаг.
- Байгалийн мансууруулах бодис эндорфин болон энкефалины боловсруулалт нэмэгдэхийг эрчимжүүлдэг. Хар тамхичдын мансууруулах бодисын тусламжтайгаар хүрэхийг оролддог тэр хэмжээний сэтгэл хөөрөлд хүргэдэг байна.

Үргэлжлэлийг дараагийн дугаарт